

Монгол Улсын Финтек инновацийн замын зураглал

Азийн Хөгжлийн Банк ТА 6991 - Монгол
Улсын Финтек салбарын эрх зүйн болон
зохицуулалтын орчныг хөгжүүлэх нь

Агуулга

1. Удиртгал	5
1.1 Замын зураглал боловсруулалтын үйл явц	5
2. Финтек Инновацын Замын зураглал	8
2.1 Алсын хараа ба зорилго	8
2.1 Финтек өсөлтийн тэргүүлэх чиглэлүүд	8
2.2 Хандлага ба тэргүүлэх чиглэлийг тодорхойлох шалгууруудын ерөнхий тойм	10
3. Финтек зохицуулалтад чиглэсэн хандлагыг бий болгох	13
3.1 Одоогийн нөхцөл байдал ба тулгамдаж буй асуудал	13
3.2 Санал болгож буй арга хэмжээ	14
3.2.1 Арга хэмжээ 1.1: Финтекийн бодлого, салбарын хөгжлийг уялдуулах Монгол улсын агентлаг хоорондын ажлын хэсэг байгуулах	14
3.2.2 Арга хэмжээ 1.2: Засгийн газрын түвшинд мэдээлэл хуваалцах механизмыг хөгжүүлэх	17
4. Салбарын оролцоог бэхжүүлэх	19
4.1 Одоогийн нөхцөл байдал ба тулгамдаж буй асуудал	19
4.2 Санал болгож буй арга хэмжээ	19
4.2.1 Арга хэмжээ 2.1: Финтек Консьерж (ФК) үйлчилгээг бий болгох	20
5. Инновацын таатай орчныг бий болгох	24
5.1 Одоогийн нөхцөл байдал ба тулгамдаж буй асуудал	24
5.2 Санал болгож буй арга хэмжээ	25
5.2.1 Арга хэмжээ 3.1: Инновацийг дэмжихийн тулд Төлбөрийн системийн журамд нэмэлт, өөрчлөлт оруулах	25
5.2.2 Арга хэмжээ 3.2: Финтек төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид АСН системд шууд хандах боломжийг дэмжих зорилгоор зохицуулалтыг хянаж үзэх	28
5.2.3 Арга хэмжээ 3.3: Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай (ББСҮА) хуулийн төслийн шинэчлэлтийг хянан үзэх	31
5.2.4 Арга хэмжээ 3.4: Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч компаниудад тусгай зөвшөөрлийн шаталсан тогтолцоог хэрэгжүүлэх	36
5.2.5 Арга хэмжээ 3.5: Нээлттэй банкны хөгжлийг удирдамж боловсруулах замаар дэмжих	39
6. Хэрэглэгчийн эрхийн хамгаалалтыг бэхжүүлэх	43
6.1 Одоогийн нөхцөл байдал болон тулгамдаж буй асуудлууд	43
6.2 Замын зураглалд санал болгож буй арга хэмжээ	44
6.2.1 Арга хэмжээ 4.1: Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг батлуулах	44
6.2.2 Арга хэмжээ 4.2: Зээлийн мэдээллийн тайлагнах хугацаа богиносгох	45
6.2.3 Арга хэмжээ 4.3-т Санхүүгийн Омбудсмений үйлчилгээг нэвтрүүлэх	49
6.2.4 Арга хэмжээ 4.4: Өрийн клиник байгуулах	53
7. Тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх	58
7.1 Одоогийн нөхцөл байдал ба тулгамдаж буй асуудлууд	58
7.2 Замын зураглалд санал болгож буй арга хэмжээ	58
7.2.1 Арга хэмжээ 5.1: Цахим болон тоон гарын үсгийн хууль зүйн үр дагаврыг тодорхой болгох	59
7.2.2 Арга хэмжээ 5.2: Цахим гарын үсгийн хууль зүйн хувьд хүчин төгөлдөрт тооцох шалгуурыг тодорхойлох	62
7.2.3 Арга хэмжээ 5.3: Санхүүгийн үйлчилгээний салбарт тоон гарын үсгийн бодит хэрэглээг хөнгөвчлөх	64
8. eKYC-н илүү өргөн хэрэглээг нэмэгдүүлэх	66
8.1 Одоогийн нөхцөл байдал болон тулгамдаж буй асуудал	66
8.2 Санал болгож буй арга хэмжээ	67
8.2.1 Арга хэмжээ 6.1: eKYC-ын шаардлагыг тодорхойлсон удирдамжтай болох	67
8.2.2 Арга хэмжээ 6.2: Хялбаршуулсан хянан шалгах тогтолцооны зохицуулалтыг нэвтрүүлэх, мөн МУТСТТХ-д биеллэн хийх KYC үйл явцын хэрэглээг тодорхой болгох	69

9. Сэндбоксын зохицуулалтын хэрэгжилтийг бэхжүүлэх	74
9.1 Одоогийн нөхцөл байдал болон тулгамдаж буй асуудлууд	74
9.2 Санал болгож буй арга хэмжээ	75
9.2.1 Арга хэмжээ 7.1: Сэндбоксоос гарсан сургамжийг бодлого, зохицуулалтад тусгахыг анхаарч хэрэгжүүлэх	75
9.2.2 Арга хэмжээ 7.2: Сэндбоксоод хүсэлт гаргагчдыг уян хатан байдлаар хүлээн авах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх	77
9.2.3 Арга хэмжээ 7.3: Сэндбоксоос гарах арга замыг тодорхой болгох	80
10. Засгийн газрын оролцогч талуудын чадавхийг бэхжүүлэх	83
10.1 Одоогийн нөхцөл байдал ба тулгамдаж буй асуудлууд	83
10.2 Замын зураглалд санал болгож буй арга хэмжээ	83
10.2.1 Арга хэмжээ 8.1: Засгийн газрын оролцогч талуудын чадавхийг бэхжүүлэх	83
11. Хавсралт	87
11.1.1 Хавсралт А: Үйл ажиллагааг тодорхойлох баримт бичгүүд	87

Нууцлалын мэдэгдэл: Энэхүү баримт бичиг болон түүнд агуулагдаж буй мэдээлэл нь өндөр нууцлалтай бөгөөд зөвхөн Азийн Хөгжлийн Банк болон түүний Монгол Улс дахь партнеруудын албан хэрэгцээнд зориулагдсан болно.

Зохиогчийн эрхээр хамгаалагдсан © 2025. Энэхүү баримт бичигт агуулагдаж буй мэдээлэл нь АА Аксес Партнершип Лимитедийн өмч бөгөөд түүнийг шууд болон шууд бусаар дахин боловсруулах, хуулбарлах, бусдад ашиглуулах, нийтэд ил болгох болон баримт бичигт тусгагдсанаас өөр зорилгоор ашиглахгүй байх нөхцөлөөр хангагдсан болно.

АА Аксес Партнершип Лимитед

1. Удиртгал

Финтек технологиудаас үүдэн гарч ирж буй сорилт болон боломжийг тооцоолсны үндсэн дээр Азийн Хөгжлийн Банк (“АХБ”)-аас (i) Монгол Улс дахь Финтек Инновацын экосистемийн хөгжилд дэмжлэг үзүүлэх; болон (ii) Монгол Улсын санхүүгийн салбарын хяналтын үйл ажиллагаанд Хяналтын технологи¹ (Suprtech)-ийг нэвтрүүлэх зорилгоор ТА 6991 дугаар Техникийн Туслалцаа (“ТТ”)-ны төсөл буюу “Финтекийн Эрх зүйн Зохицуулалтын Орчныг Хөгжүүлэх нь” төслийг зарласан. Аксес Партнершип² нь Улаанбаатар хотод байрлах Өмгөөллийн Фиделитас Партнерс ХХН хуулийн фирмийн дэмжлэгтэйгээр тус төслийн ТТ-ны багийн нэг хэсэг болон ажиллаж байна. ТТ-ны үр дүнгүүдийн нэг нь Монгол улс дахь Финтек инновацийн экосистемийг бэхжүүлэх хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, тодорхой алхмуудыг харуулсан Финтек инновацын замын зураглал юм.

1.1 Замын зураглал боловсруулалтын үйл явц

Финтек Инновацын Замын зураглалыг 2023 оны 10 дугаар сараас 2025 оны 03 дугаар сарын хооронд 18 сарын хугацаанд Монгол улсын төрийн болон хувийн хэвшлийн гол оролцогч талуудыг хамруулсан зохион байгуулалттай зөвлөлдөх уулзалтууд болон Финтек экосистемийг бий болгох дэлхийн сайн туршлагаудыг судалсны үндсэн дээр боловсруулсан. Оролцогч талуудад Монгол улсын санхүүгийн салбарын бодлого, зохицуулалтыг хариуцдаг эрх бүхий байгууллагууд болох (i) Монгол банк (“МБ”), (ii) Санхүүгийн зохицуулах хороо (“СЗХ”), (iii) Сангийн яам (“СЯ”), (iv) санхүүгийн үйлчилгээ, Финтек салбарын тоглогчид болон (v) судалгаа, хөгжүүлэлтийн оролцогчид багтсан.

Хэрэгжүүлэх тодорхой алхмуудыг дараах байдлаар тодорхойлсон:


А. Финтек Инновацын Системийн одоогийн нөхцөл байдлыг ойлгохын тулд орчныг шинжлэн судлах

Монголын Финтек инновацын экосистемийн одоогийн байдлыг ойлгох зорилгоор зохицуулалтын орчны судалгааг хийсэн. Инновацын экосистемийг бий болгох одоогийн зохицуулалтын тогтолцоонд хийсэн анхны дүн шинжилгээнд үндэслэн инновацын экосистемийн үндсэн 6 бүрэлдэхүүнийг тодорхойлсон бөгөөд эдгээр 6 бүрэлдэхүүний хүрээнд Монгол улсын бодлогын орчны одоогийн нөхцөл байдалд төвлөрсөн. Эдгээр 6 бүрэлдэхүүнийг (i) санхүүгийн үйлчилгээний салбар дах инновац, бизнес эрхлэлтийн таатай орчныг бий болгох үндсэн бүрэлдэхүүн; (ii) Монгол улсад хүчирхэг Финтек инновацын экосистемийг бий болгох Финтект чиглэсэн бодлого идэвхжүүлэгч бүрэлдэхүүн; болон (iii) судалгаа ба инновацын орчныг бий болгох бүрэлдэхүүн гэж ангилна. Схем А1-д бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн бодлогын олон талт онцлогуудыг тоймлон харуулав.

¹ Суптек буюу хяналтын технологи нь хяналтын байгууллагуудын хяналт шалгалтыг сайжруулах технологи юм. Энэ нь зохицуулалттай байгууллагууд (жишээ нь санхүүгийн байгууллагууд)-ын эрсдэлийн удирдлага, зохицуулалтын нийцлийг сайжруулахад ашиглагддаг Регтек буюу зохицуулалтын технологиос ялгаатай.

² Аксес Партнершип нь дэлхийд тэргүүлэх технологийн бодлогын зөвлөх юм. Бид компаниудыг дэлхийн зах зээлд нэвтрэх, оновчтой оролцоог хэрэгжүүлэхэд хамтран ажилладаг ба одоо байгаа болон шинээр гарч ирж буй технологиудад хэрхэн хамгийн сайн зохицуулалт хийх талаар засгийн газруудад зөвлөн ажилладаг. Бидний үйл ажиллагааны талаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг <https://accesspartnership.com/> сайтаас авах боломжтой.

СХЕМ 1



Source: Access Partnership analysis

Үнэлгээг Сангийн яам, Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороо зэрэг санхүүгийн салбарын эрх бүхий байгууллагуудын хамрах хүрээний салбаруудад чиглүүлсэн бөгөөд бодлогын зөвлөмжийг холбогдох талуудад чиглүүлж, хэрэгжүүлэх боломжтой эсэхийг баталгаажуулах зорилгоор бэлтгэсэн. (i) Үндэсний Финтекийн зохицуулалт болон хэрэгжилт; (ii) судалгаа ба хөгжүүлэлт; (iii) эдийн засгийн эргэлтэд оруулах замыг бий болгох бүрэлдэхүүнүүд нь үнэлгээ болон хэлэлцүүлгийн үе шатанд голлох байр суурийг эзэлнэ.

В. Монголын Финтек инновацын экосистемийн "зорилтот нөхцөл"-ийг бий болгох нь

Зорилтот нөхцөл нь Финтекийн бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт, нийлүүлэлтэд нөлөөлж буй гадаад хүчин зүйлс дээр тулгуурлан амжилттай, динамик Финтек инновацын экосистем ямар байх тухай алсын харааг илэрхийлнэ. “Зорилтот нөхцөл”-ийг хөгжүүлэх ажил нь хоёр хэсэгт хуваагдана.

- (i) **Финтек салбарын өсөлтийн хувилбарыг боловсруулах:** Финтек салбарын өсөлтийн цаашдын замналыг ойлгосноор Монгол Улсын тэргүүлэх ач холбогдол өгөхөөр зорьж болох шинэ технологи буюу Финтекийн инновацын салбаруудыг тодотгоно. Мөн Монгол Улсад Финтек инновацын тодорхой салбарыг дэмжих нөөцийн хуваарилалтад анхаарахад тусалж чадна. Хувилбарыг боловсруулахад дэлхийн болон дотоодын чиг хандлагад үндэслэн эрэлт, нийлүүлэлтийн хүчин зүйлс Монгол Улс дахь Финтек салбарын өсөлтөд хэрхэн нөлөөлж буйг шинжлэх ба Монгол Улстай ижил гараанаас эхэлсэн бөгөөд одоогоор төлөвшсөн Финтекийн зах зээлийн өсөлтийг судалж илүү боловсронгуй болгоно.
- (ii) **Дэлхийн улс орнуудын жишиг туршлагыг ойлгох:** Цаашид дүн шинжилгээнд оруулах дэлхийн Финтек төвүүдийн жагсаалтыг Монголд үйл ажиллагаа явуулах нөхцөл, соёлтой ижил төстэй байдал зэрэг хүчин зүйлс дээр үндэслэн сонгосон бөгөөд Монгол Улс одоогоор амжилт муутай байгаа салбаруудыг хамарсан болно. Эдгээр амжилттай экосистемийн жишиг туршлагыг Монголд хэрхэн ашиглах боломжтойг ойлгохын тулд (А)-д онцолсон зургаан үндсэн бүрэлдэхүүн хэсэг дээр үндэслэн жагсаалтад орсон төвүүдийн давуу талуудад дүн шинжилгээ хийнэ. Шинжилгээнд Монгол Улсад үйл ажиллагаа явуулах онцлог нөхцөл байдлыг авч үзэх ба уг нөхцөл байдлыг харгалзсан зөвлөмжийг практикт хэрэгжүүлэх боломжид анхаарлаа хандуулах болно.

С. Асуудалд дүн шинжилгээ хийж, замын зураглалыг боловсруулах

"Одоогийн нөхцөл" болон "зорилтот нөхцөл"-ийг харьцуулж, Монгол Улсын Финтек инновацын экосистемийн асуудлыг тодорхойлох зорилгоор дүн шинжилгээг хийж, үйл явц (А)-д онцолсон зургаан үндсэн бүрэлдэхүүн хэсэгт анхаарлаа хандуулна. Асуудлын дүн шинжилгээнд үндэслэн Монгол Улсын Финтек инновацын экосистемийн одоогийн болон зорилтот нөхцөл хоорондын зөрүүг арилгах алхмуудыг тодорхойлсон Замын зураглалыг боловсруулна. Замын зураглалд дараах гол онцлогуудыг хамааруулна:

- (i) **Илрүүлсэн асуудлыг арилгах зорилтот зөвлөмжүүд.** Зөвлөмжийг Монгол Улсын онцлогт тохируулан, Монгол Улсын өсөлтийн тэргүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэнэ.
- (ii) **Зөвлөмжийн логик дараалал.** Замын зураглал нь экосистемийг бий болгоход чиглэсэн урт хугацааны үзэл баримтлалыг авч үзэх зорилготой бөгөөд зөвлөмжийг хэрэгжүүлэх тодорхой цаг хугацаанд анхаарал хандуулахгүй. Үүний оронд хийх шаардлагатай шинэчлэлийн дарааллыг санал болгож, шаардлагатай тохиолдолд эдгээр үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжит оролцогч талууд эсвэл байгууллагууд, түүний дотор санхүүгийн үйлчилгээний зохицуулалтаас гадуурх байгууллагуудыг тоймлон харуулна.
- (iii) **Засгийн газрын оролцогч талуудын хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлсон.** Зарим зөвлөмжийн хувьд холбогдох оролцогч талууд санхүүгийн үйлчилгээний салбарт хамаарахгүй байж болно. Замын зураглал нь санхүүгийн зохицуулагчдын эрх мэдлийн хүрээнд хэрэгжүүлэх болон бусад оролцогч талуудтай үр дүнтэй хамтран ажиллах шаардлагатай гэх агуулгаар зөвлөмжийг хооронд нь ялгах болно.

2. Финтек Инновацын Замын зураглал

2.1 Алсын хараа ба зорилго

Монгол улсын Финтек Инновацын Замын зураглалын алсын хараа нь санхүүгийн тогтвортой байдлыг хангаж, хэрэглэгчийн эрхийг хамгаалахын зэрэгцээ өрсөлдөөнийг дэмжих найдвартай бөгөөд динамик Финтек инновацын экосистем юм. Ийм экосистем нь Монгол улсад Финтек үйлчилгээ тасралтгүй хөгжих, үйлчилгээний нөхцөл, хэрэглэгчийн эрх ашгийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж, Монгол улсын иргэдэд тогтвортой бөгөөд үр ашигтай өсөлтийг бий болгоно.

Үүнд хүрэхийн тулд Замын зураглалд Монгол улсын Финтек инновацын экосистемийг бэхжүүлэхэд чухал ач холбогдол бүхий 8 тэргүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх тодорхой үйл ажиллагаануудыг тусгасан. Эдгээр үйл ажиллагааг ямар дарааллаар хэрэгжүүлэх, үйл ажиллагаа тус бүрт ямар алхмуудыг хийх, тэдгээрийг удирдах, оролцох талуудыг Замын зураглалд тусгасан. Мөн Замын зураглалд үйл ажиллагаа тус бүрт жишиг болох олон улсын сайн туршлагуудыг багтаасан.

Ерөнхийдөө Замын зураглал нь Монгол улсын санхүүгийн зохицуулагч байгууллагуудад Финтек экосистемийн зорилгод хүрэх шинэчлэлүүдийг хэрэгжүүлэх зааварчилгаа болно. Замын зураглал нь оролцогч талуудтай хийсэн өргөн хүрээний зөвлөлдөх уулзалтаар тодорхойлсон дотоодын нөхцөл байдал, хязгаарлалтуудын талаарх ойлголтуудад үндэслэн СЗХ болон МБ-ны хувьд шууд хэрэгжүүлэх боломжтой практик арга хэмжээнүүдэд төвлөрөхийн зэрэгцээ ирээдүйн инновацын орчинг бүрдүүлэх урт хугацааны алсын хараа ямар байж болохыг тодорхойлсон.

2.2 Финтек өсөлтийн тэргүүлэх чиглэлүүд

Оролцогч талуудын оролцоотойгоор Финтекийн инноваци, өсөлтийг дэмжихэд хэрэгжүүлэх шаардлагатай найман тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон.

Хүснэгт 1

Гол чиглэлүүд	Тайлбар	Зөвлөмж
1. Финтек зохицуулалтад чиглэсэн хандлагыг бий болгох	Финтект ээлтэй зохицуулалтын орчныг бүрдүүлэх хандлагыг дэмжих	<ul style="list-style-type: none">Финтекийн бодлого, салбарын хөгжлийг уялдуулах Монгол улсын агентлаг хоорондын ажлын хэсэг байгуулахЗасгийн газрын түвшинд мэдээлэл хуваалцах механизмыг хөгжүүлэх
2. Салбарын оролцоог бэхжүүлэх	Зохицуулах байгууллагууд болон Финтек компаниудын харилцаа холбоог сайжруулах	<ul style="list-style-type: none">Финтек Консьерж (ФК) үйлчилгээг бий болгох
3. Инновацын таатай орчныг бий болгох	Шударга өрсөлдөх орчныг бий болгож, шинээр үүсэх эрсдэлүүдийг шийдвэрлэх замаар инновацыг дэмжих	<ul style="list-style-type: none">Төлбөрийн системийн журамд инновацийг дэмжих тухай нэмэлт, өөрчлөлт оруулахФинтек төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид АСН системд шууд хандах боломжийг дэмжих зорилгоор зохицуулалтыг хянаж үзэхБанк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай (ББСҮА) хуулийн төслийн шинэчлэлийг хянан үзэх

Гол чиглэлүүд	Тайлбар	Зөвлөмж
		<ul style="list-style-type: none"> Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нарыг түвшинд хуваасан тусгай зөвшөөрлийн тогтолцоог хэрэгжүүлэх Нээлттэй банкны хөгжлийг хэм хэмжээ боловсруулах замаар дэмжих
4. Хэрэглэгчийн хамгаалалтыг бэхжүүлэх	Хэрэглэгчийн хамгаалалтыг бэхжүүлэх замаар Финтекийн үйлчилгээнд итгэх итгэлийг нэмэгдүүлэх	<ul style="list-style-type: none"> Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хуулийг багтах Зээлийн мэдээллийг нийлүүлэх хугацааг богиносгох Санхүүгийн омбудсман үйлчилгээг бий болгох Өрийн клиник байгуулах
5. Цахим болон тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх	Финтек ашиглах тохиолдлуудыг идэвхжүүлэхийн тулд тоон болон цахим гарын үсгийг ашиглах хэм хэмжээг тодорхой болгож, бэхжүүлэх	<ul style="list-style-type: none"> Тоон болон цахим гарын үсгийн хууль зүйн үр нөлөөг тодорхой болгох Цахим гарын үсгийг хууль ёсны хүчинтэй болгох шалгуурыг тодорхой болгох Санхүүгийн салбар дахь тоон гарын үсгийн бодит хэрэгжилтийг дэмжих
6. eKYC-н хэрэглээг нэмэгдүүлэх	Финтек ашиглах тохиолдлуудыг идэвхжүүлэхийн тулд eKYC ашиглах хэм хэмжээг тодорхой болгож, бэхжүүлэх	<ul style="list-style-type: none"> eKYC шаардлагын талаар тодорхой хэм хэмжээг гаргах Хялбаршуулсан шалгалтын хүрээг нэвтрүүлж, МУТСТ хуулинд биечлэн танилт (KYC) хийх үйл явцын хэрэглээг тодорхой болгох
7. Сэндбоксыг зохицуулалтын хэрэгжилтийг бэхжүүлэх	Шинэ бизнес загваруудыг турших талбар болгон сэндбоксын үр нөлөөг сайжруулж, зохицуулалтын шинэчлэлд зориулсан санал хүсэлтийн механизмыг бэхжүүлэх	<ul style="list-style-type: none"> Сэндбоксын туршлагаас олж авсан бодлогын сургамжуудыг нэгтгэх замаар үе шатыг сайжруулах Сэндбоксоод орох өргөдөл гаргагчдыг сонгон шалгаруулах уян хатан хүрээг бий болгох Сэндбоксоос төгсөгчдийн гарах замыг тодорхой болгох
8. Засгийн газрын оролцогч талуудын чадавхийг бэхжүүлэх	Өрсөлдөөний асуудлуудыг илрүүлэх, шийдвэрлэх чиглэлээр зохицуулагч байгууллагуудын чадамжийг бэхжүүлэх	<ul style="list-style-type: none"> Засгийн газрын оролцогч талуудын чадавхийг бэхжүүлэх

2.3 Хандлага ба тэргүүлэх чиглэлийг тодорхойлох шалгууруудын ерөнхий тойм

ФинТек инновацыг дэмжих таатай орчныг бүрдүүлэхийн зэрэгцээ эрсдэлийг удирдах, хэрэглэгчдийг шинэ эрсдэлээс хамгаалахын тулд энэхүү замын зураглал дараах шалгууруудын үндсэн дээр зөвлөмжүүдийн дарааллыг тогтоосон. Үүнд: (1) шийдвэрлэх шаардлагатай гол эрсдэлийн ач холбогдол; (2) логик дараалал; (3) одоогийн чадамжтай нийцэх байдал.

- (i) **Шийдвэрлэх шаардлагатай гол эрсдэлийн ач холбогдол:** Гол эрсдэлүүдийн ач холбогдлыг харгалзан зөвлөмжүүдийн дарааллыг тогтоох нь Финтек экосистем дэх хамгийн тулгамдсан асуудлуудыг эхлээд шийдвэрлэхэд чиглэгдэнэ.
- (ii) **Логик дараалал:** Логик дараалал нь зайлшгүй шаардлагатай урьдчилсан алхмуудад суурилсан байх явдал юм.
- (iii) **Одоогийн чадамжтай нийцэх байдал:** Нөөц болон чадавх зэрэг практик хүчин зүйлсийг харгалзан үзэж зөвлөмжүүдийг одоогийн чадамжтай нийцүүлэхэд чиглэнэ.

Үүний зэрэгцээ Замын зураглалыг боловсруулахдаа дэлхийн өөр өөр сайн туршлагуудыг авч үзсэн бөгөөд үүнд тусгайлсан болон нэгдсэн Финтекийн хуулийг боловсруулах хувилбар багтсан. Гэсэн хэдий ч энэ хувилбарыг хэрэгжүүлэхгүй бөгөөд санал болгож буй хандлага бол шинээр хууль тогтоомж батлахын оронд одоогийн холбогдох хууль тогтоомжийг шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах тал дээр төвлөрч байна.

Монгол улсад санал болгож буй хандлага нь дотоодын зах зээлийн нөхцөл байдалд нийцсэн өөрчлөлтүүдийг хийх илүү уян хатан боломжийг олгохоос гадна зохицуулагч байгууллагуудад Финтект ээлтэй хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэх нөөц боломж, ойлголтыг бий болгох хугацааг олгох замаар аажмаар шилжилт хийхэд дэмжлэг үзүүлнэ. Мөн шинэ ойлголтыг хуучин хууль тогтоомжийн бүтцэд нэгтгэснээр хуулийн нийцлийг дэмжиж, зах зээлийн оролцогчдод тодорхойгүй байдлыг бууруулдаг. Бусад улс орнууд инновацыг дэмжихийн зэрэгцээ эрсдэлийг удирдах төстэй стратегийг хэрэгжүүлсэн байна. Сингапур улс өөрчлөгдөж буй дижитал санхүүгийн чиг хандлагуудыг тусгасан өөрчлөлтүүдийг [Төлбөрийн үйлчилгээний хууль](#) болон [Үнэт цаасны тухай хуульдаа](#) оруулсан. Мөн нэг жишээ нь Хонгконгийн виртуал банкны хандлага бөгөөд энэ нь [шаталсан зөвшөөрлийн тогтолцоог](#) хэрэгжүүлсэн. Эдгээр жишээнүүд нь шилжилтийг аажмаар хийх нь инновацийг дэмжихийн зэрэгцээ зохистой эрсдэлийн удирдлага болон зохицуулалтын хяналтыг хангах боломж олгодгийг харуулж байна.

Ирээдүйд финтек экосистемд томоохон өсөлт гарч, илүү төвөгтэй болж, аажмаар хийсэн шилжилтүүд нь шинэ зохицуулалтын хоосон зайг нөхөхөд хангалтгүй болох тохиолдолд Финтекийн тусгайлсан хууль баталж, тодорхой бөгөөд иж бүрэн тогтолцоог бий болгох шаардлагатай болно.

Диаграмм 1



Диаграм 2

Финтек замын зураглал дээрх зөвлөмжүүдийн дараалал

Үндсэн чиглэлүүд	Нэн даруй	Ойрын хугацаанд	Дунд хугацаанд	Урт хугацаанд
1) Финтек зохицуулалтад чиглэсэн хандлагыг бий болгох	Арга хэмжээ 1.1: Финтекийн бодлого, салбарын хөгжлийг уялдуулах Монгол улсын агентлаг хоорондын ажлын хэсэг байгуулах	Арга хэмжээ 1.2: Засгийн газрын түвшинд мэдээлэл хуваалцах механизмыг хөгжүүлэх		
2) Салбарын оролцоог бэхжүүлэх		Арга хэмжээ 2.1: Финтек Консьерж (ФК) үйлчилгээг бий болгох		
3) Инновацийн таатай орчныг бий болгох	Арга хэмжээ 3.1: Инновацийг дэмжихийн тулд Төлбөрийн системийн журамд нэмэлт, өөрчлөлт оруулах Арга хэмжээ 3.2: Финтек төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид АСН системд шууд хандах боломжийг дэмжих зорилгоор зохицуулалтыг хянаж үзэх	Арга хэмжээ 3.3: Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай (ББСҮА) хуулийн төслийн шинэчлэлтийг хянан үзэх		Арга хэмжээ 3.4: Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч компаниудад тусгай зөвшөөрлийн шаталсан тогтолцоог хэрэгжүүлэх Арга хэмжээ 3.5: Нээлттэй банкны хөгжлийг удирдаж боловсруулах замаар дэмжих
4) Хэрэглэгчийн эрхийн хамгаалалтыг бэхжүүлэх	Арга хэмжээ 4.1: Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг батлуулах	Арга хэмжээ 4.2: Зээлийн мэдээллийн тайлагнах хугацаа богиносгох	Арга хэмжээ 4.3-т Санхүүгийн Омбудсмений үйлчилгээг нэвтрүүлэх	Арга хэмжээ 4.4: Өрийн клиник байгуулах
5) Цахим болон тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх		Арга хэмжээ 5.1: Цахим болон тоон гарын үсгийн хууль зүйн үр нөлөөг тодорхой болгох Арга хэмжээ 5.2: Цахим гарын үсгийн хууль зүйн хувьд хүчин төгөлдөрт тооцох шалгуурыг тодорхойлох	Арга хэмжээ 5.3: Санхүүгийн үйлчилгээний салбарт тоон гарын үсгийн бодит хэрэглээг хөнгөвчлөх	
6) eKYC-ийн илүү өргөн хэрэглээг нэмэгдүүлэх		Арга хэмжээ 6.1: eKYC-ын шаардлагыг тодорхойлсон удирдамжтай болох	Арга хэмжээ 6.2: Хялбаршуулсан хянан шалгах тогтолцооны зохицуулалтыг нэвтрүүлэх, мөн МУТСХ-д биечлэн хийх KYC үйл явцын хэрэглээг тодорхой болгох	
7) Сэндбоксын зохицуулалтын хэрэгжилтийг бэхжүүлэх		Арга хэмжээ 7.1: Сэндбоксоос гарсан сургамжыг бодлого, зохицуулалтад тусгахыг анхаарч хэрэгжүүлэх	Арга хэмжээ 7.2: Сэндбоксоод хүсэлт гаргагчдыг уян хатан байдлаар хүлээн авах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх Арга хэмжээ 7.3: Сэндбоксоос гарах арга замыг тодорхой болгох	
8) Засгийн газрын оролцогч талуудын чадавхийг бэхжүүлэх	Арга хэмжээ 8.1: Засгийн газрын оролцогч талуудын чадавхийг бэхжүүлэх			

3 Финтек зохицуулалтад чиглэсэн хандлагыг бий болгох

Финтекийн зохицуулалтыг уялдуулан нийцүүлэх нь инновацыг дэмжих, зохицуулалтын олон янз байдлыг бууруулах, хяналтыг бэхжүүлэх тогтвортой тогтолцоог бүрдүүлэх чухал ач холбогдолтой. Үүнийг хэрэгжүүлэх гол алхмууд нь Финтекийн бодлогыг уялдуулах Монгол улсын агентлаг хоорондын ажлын хэсэг байгуулж, засгийн газрын түвшинд мэдээлэл хуваалцах механизмыг хөгжүүлэх юм.

3.1 Одоогийн нөхцөл байдал ба тулгамдаж буй асуудал

Монгол улсад Финтек салбарын хөгжлийг одоогоор Сангийн яам, Монгол банк болон Санхүүгийн зохицуулах хорооны хамтын ажиллагааны хүрээнд янз бүрийн агентлаг хоорондын зохицуулах байгууллагуудаар дамжуулан хэрэгжүүлж байна. Үүнд Үндэсний төлбөрийн системийн зөвлөл болон Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл багтана. Гэсэн хэдий ч Финтекийн хөгжлийг үндэсний хэмжээнд чиглүүлэх албан ёсны эрх мэдэл байхгүй. Мөн санхүүгийн салбарын агентлагуудаас бусад төрийн байгууллага хоорондын уялдаа холбоо хязгаарлагдмал байгаа бөгөөд Финтекийн хөгжил, санхүүгийн зохицуулах байгууллагуудаас гаргаж буй шинэ төрлийн зохицуулалтыг бусад төрийн байгууллагууд төдийлөн бүрэн ойлгохгүй байна. Тулгамдаж буй гол асуудлуудыг дараах байдлаар тодорхойлов.

- **Финтекийн хөгжлийг чиглүүлэх төрийн байгууллагуудын нэгдсэн тогтолцоо байхгүй.** Финтек хөгжлийн зохицуулалтыг одоогоор санхүүгийн салбарын бодлогод нийцүүлэх шаардлагатай тохиолдолд үндэслэж зохицуулагч байгууллагууд хэрэгжүүлж байна. Үндэсний төлбөрийн системийн зөвлөл болон Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл нь Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Монгол банкны оролцоотойгоор зөвхөн шаардлагатай үеүдэд Финтек инновацтай холбоотой асуудлуудыг хэлэлцдэг. Гэсэн хэдий ч эдгээр байгууллагууд нь үндэсний төлбөрийн системийн зохицуулалт, хяналт болон санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн тодорхой эрх мэдэлтэй бөгөөд Финтекийн хөгжлийг чиглүүлэх нь тэдний эрх мэдлийн хүрээнд албан ёсоор багтаагүй. Монгол улсад Финтекийн хөгжлийг хариуцах албан ёсны эрх мэдэл бүхий зохицуулах байгууллага байхгүй юм. Цаашлаад Финтекийн бодлого, зохицуулалтын хүрээнд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам болон Хууль зүй, дотоод хэргийн яам зэрэг санхүүгийн салбарт үл хамаарах зохицуулах байгууллагуудтай институцийн түвшинд зохицуулалт хийх боломжтой байгууллага байхгүй.
- **Засгийн газрын түвшинд Финтекийн бодлого, зохицуулалтын талаарх мэдлэг дутмаг.** Санхүүгийн салбарт үл хамаарах засгийн газрын агентлагууд нь Финтекийн бизнес загварууд болоод тэдгээрийн хурдацтай хөгжиж буй шинэ чанараас хамаарах хэрэгцээ шаардлагад нийцсэн шинэ хууль, тогтоомжийг төдийлөн ойлгохгүй байна. Жишээ нь зөвлөлдөх уулзалтын үеэр оролцогч талууд татварын албан хаагчид Финтекийн зарим бизнес загваруудын санхүүгийн урсгалд хэрхэн татвар ногдуулах талаар мэдэхгүй байгааг дурдсан. Энэ нь Финтек компаниуд өөрсдийнх нь бизнесийн загварт нийцэхгүй байгаа хууль тогтоомжийг хэрэглэх шаардлагатай болж, өөрсдийнхөө бизнесийн загварыг тодруулах, тайлбарлах зэргээр ихээхэн цаг хугацааг зарцуулж, инновацийн өсөлтийг сааруулах үр дагавартай.

3.2 Санал болгож буй арга хэмжээ

Санхүүгийн зохицуулах хороо, Монгол банк болон салбарын оролцогчдоос ирүүлсэн санал хүсэлтэд үндэслэн Финтекийн бодлого, салбарын хөгжилд чиглэсэн засгийн газрын хандлагыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийн тулд Монгол улсын Финтек салбарын агентлаг хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх хоёр үйл ажиллагааг санал болгож байна. Үүнд (санал болгож буй дарааллын дагуу хэрэгжүүлнэ):

- (i) Финтекийн бодлого, салбарын хөгжлийг уялдуулах Монгол улсын агентлаг хоорондын ажлын хэсэг байгуулах
- (ii) Засгийн газрын түвшинд мэдээлэл хуваалцах механизмыг хөгжүүлэх

3.2.1 Арга хэмжээ 1.1: Финтекийн бодлого, салбарын хөгжлийг уялдуулах Монгол улсын агентлаг хоорондын ажлын хэсэг байгуулах

Хүснэгт 2: Арга хэмжээ 1.1-ийн хураангуй

Зорилт	Финтекийн хөгжлийг чиглүүлэх албан ёсны эрх мэдэл бүхий агентлаг хоорондын ажлын хэсгийг байгуулах, ажлын хэсэгт санхүүгийн зохицуулах байгууллагууд болон бусад төрийн байгууллагуудыг оролцуулан төрийн бүх түвшний бодлого, хөтөлбөрүүдийг уялдуулан зохицуулах ажлыг бэхжүүлнэ.
Тайлбар	<p>Монгол банк болон Санхүүгийн зохицуулах хороогоор хамтран удирдуулсан Монгол улсын Финтек Ажлын Хэсэг (МФАХ)-ийг байгуулж, Финтекийн бодлого, хөгжилд хамаарах бусад агентлагуудыг гишүүнээр хамруулж болно.</p> <p>МФАХ нь Монгол улсын засгийн газрын агентлагууд хооронд Финтект хамаарах бодлого, зохицуулалтыг уялдуулан, Финтек инновацид таатай орчныг хөгжүүлэхэд чиглэхийн зэрэгцээ хэрэглэгчийн хамгаалалт, зах зээлийн нэгдэл, системийг тогтвортой байдлыг хангаж ажиллана.</p> <p>МФАХ-ийн тогтвортой байдал, үндэсний санхүүгийн тогтвортой байдлын зорилт болон инновацид төвлөрсөн санаачилгыг хангахын тулд МФАХ болон Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл, Монгол Улсын Их Хурлын Инновац, Цахим бодлогын байнгын хороо зэрэг чиглүүлэх байгууллагууд хооронд зохион байгуулалт бүхий тайлагналын механизм, суваг бий болгох хэрэгтэй.</p>
Хэрэгжилтийг удирдах субъект	Монгол банк болон Санхүүгийн зохицуулах хороо
Оролцогч талууд	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Сангийн яам, Хадгаламжийн даатгалын корпораци, Эдийн засаг, хөгжлийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Татварын ерөнхий газар, Харилцаа холбооны зохицуулах хороо, бусад шаардлагатай агентлагууд.
Алхмууд	<p>Монгол улсын Финтек ажлын хэсгийг байгуулахад дараах алхмуудыг хэрэгжүүлнэ:</p> <ol style="list-style-type: none"> Чиглүүлэх төслийн бүлэг байгуулах. Монгол банк болон Санхүүгийн зохицуулах хорооны удирдлагад шууд тайлагнах бүлгийг байгуулж, МФАХ-ийг байгуулах бэлтгэл ажлыг хангана. Төслийн бүлэг нь бусад агентлагуудтай тэдний боломжит оролцоо болон хамрах хүрээний талаар зөвлөлдөх, МФАХ-ийг байгуулахад шаардлагатай хууль эрх зүйн өөрчлөлтүүдийг зохицуулах талаар тусгасан Ажлын даалгавар (TOR)-ыг боловсруулахаас эхэлнэ.

Төслийн бүлэг нь түр хугацаанд зохион байгуулагчийн үүрэг гүйцэтгэх хүрээнд энэхүү Замын зураглалд заасан үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэх нь тохиромжтой.

2. **Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах.** Албан ёсоор МФАХ байгуулахын тулд хуульд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай болно. Санхүүгийн зохицуулах хороо болон Монгол банк хоорондын хамтын ажиллагааны хүрээнд хийгдэх үйл ажиллагааны жагсаалтын хүрээнд Финтекийн үйл ажиллагааг нэмж өргөжүүлэх хэрэгтэй. Ялангуяа Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт Санхүүгийн зохицуулах хороо, Монгол банк болон Засгийн газартай хамтран ажиллах гурван талт харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээг тодорхойлсон бөгөөд энэ зүйлд “Финтекийн бодлого ба салбарын хөгжил” гэсэн хамтын ажиллагааны чиглэл нэмж өргөжүүлэх хэрэгтэй.
3. **Ажлын даалгавар (“TOR”) боловсруулах.** МФАХ-д Монгол улсад Финтек инновацыг дэмжих бүрэн эрхийг нь тодорхой тусгасан, ажлын хэсэгт багтсан төрөл бүрийн оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг тодорхой байлгахын тулд Ажлын даалгавар чухал үүрэгтэй. Ажлын даалгаварт (i) зорилго ба эрх хэмжээ, (ii) удирдлагын бүтэц ба гишүүнчлэл (жишээ нь агентлагуудын дээд түвшний оролцоо шаардлага гэх мэт) (iii) МФАХ-ийн үүрэг хариуцлага, гишүүн бүрийн хүлээх үүрэг, (iv) хамтын ажиллагааны горим (жишээ нь уулзалтын давтамж, тайлагналтын процесс гэх мэт) зэргийг тусгах хэрэгтэй. Шаардлагатай тохиолдолд Ажлын даалгаварт МФАХ-ийн үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай санхүүгийн шалгууруудыг тусгах боломжтой.

МФАХ-ийн зарим гол чиг үүрэг нь бодлогын зохицуулалт, салбарын хөгжил, инновацын идэвхжүүлэлт, хэрэглэгчийн хамгаалалт, боловсрол, олон улсын хамтын ажиллагааг дэмжих хүрээнд ажлын урсгалыг зохион байгуулах зэрэг багтана. Илүү нарийвчилсан тайлбарыг Хавсралт А, Бокс А-д тусгасан санал болгож буй Үйл ажиллагааг тодорхойлох баримт бичгийн загвараас үзнэ үү.

4. **Хариуцлага болон хяналтын тогтолцоог хангах тайлагналын механизмыг бий болгох.** Зохион байгуулалттай тайлагнах процессыг бий болгох хэрэгтэй. Тодруулбал, МФАХ нь өөрийн үйл ажиллагаа болон Финтекийн хөгжлийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны хураангуйг СЗХ-ны жилийн тайланд тусгах өөрийн гэсэн хэсэгтэй байх хэрэгтэй. Мөн Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 9.1-т “Хороо хуулийн хэрэгжилт, түүнчлэн өөрийн санхүүгийн болон үйл ажиллагааныхаа талаар Улсын Их Хуралд тайлагнана” гэж, 10.5-д “Хороо үйл ажиллагааныхаа жилийн тайланг Засгийн газар, Монгол банкинд хүргүүлнэ” гэж тус тус заасны дагуу дээрх мэдээллийг Улсын Их Хурал болон Монгол банкинд хүргүүлэх нь зүйтэй. МФАХ-ийн хамрах хүрээ болон тайлангийн бүтцийн талаар Ажлын даалгаварт дэлгэрэнгүй тусгавал зохино.

Хүснэгт 3: Арга хэмжээ 1.1-т хамаарах сайн туршлагууд

Байршил	Тайлбар	Монгол улсад хэрэгжүүлж болох гол шийдлүүд
Ази	<p>Азийн Үнэт цаасны салбар ба Санхүүгийн зах зээлийн холбоо³</p> <p>Азийн Үнэт цаасны салбар ба Санхүүгийн зах зээлийн холбооны “Финтекийг үр дүнтэй хөгжүүлэх сайн туршлагууд”-ын 10 сайн туршлагын нэг нь “Сайн туршлага №5: Финтекийн нөлөөлөлд өртөж болох банк, үнэт цаас, даатгал, харилцаа холбоо зэрэг өөр өөр салбаруудыг үндэсний хэмжээнд тогтвортой дэмжихийн тулд агентлаг хоорондын хамтын ажиллагааг хангах” гэжээ.</p>	<p>Агентлаг хоорондын ажлын хэсэг байгуулах нь Финтекийн хууль тогтоомжуудын уялдаа, нийцлийг хангахад шаардлагатай гол бүрэлдэхүүн хэсэг гэж хүлээн зөвшөөрөх нь элбэг байна.</p>
Хонгконг	<p>Финтек санаачилгыг хэрэгжүүлэх Чиглүүлэх бүлэг (CGFin).⁴</p> <p>CGFin нь Санхүүгийн үйлчилгээ, төрийн сангийн нарийн бичгийн даргаар удирдуулсан агентлаг хоорондын бүлэг юм. Чиглүүлэх бүлэг нь Хонгконг улсын Мөнгөний газар, Үнэт цаас, фьючерсийн комисс, Даатгалын газар, Албан журмын нийгмийн даатгалын сангийн газар, Хөрөнгө оруулалтын газар, Киберпорт болон Хонгконг улсын Шинжлэх ухаан, Технологийн паркуудын корпорацитай зэрэг байгууллагуудын төлөөллүүдийг хамардаг.</p> <p>CGFin нь Финтекийн хөгжил, зохицуулалтын тэнцвэртэй байдлыг хадгалахын зэрэгцээ Финтектэй холбоотой бодлогыг улсын хэмжээнд цогцоор нь хөгжүүлэх, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үндсэн үүрэгтэй.</p> <p>CGFin нь эх газрын болон хилийн чанад дахь зах зээлийн хамтын ажиллагааг дэмжих, санхүүгийн дэд бүтцийг сайжруулах, Финтекийн хүний нөөцийг хөгжүүлэхэд болон бусад салбар хоорондын Финтек хамтын ажиллагааг холбогдох Финтекийн бодлогын хяналтыг хэрэгжүүлдэг.</p>	<p>Финтекийн хөгжилд таатай орчныг бий болгохын тулд Финтекийн зохицуулалтад хамаарах бүх оролцогч талуудын уялдаа холбоог хангах нь чухал юм.</p>
Ирланд	<p>Ирланд улсын Санхүүгийн хэлтсийн Финтек Чиглүүлэх бүлэг⁵</p> <p>Финтек чиглүүлэх бүлэг нь финтекийн экосистемийн хөгжилд чухал ач холбогдол бүхий төрийн байгууллагуудын албан тушаалтнуудыг нэгтгэдэг. Үүнд Ирланд улсын Төв банк, Нэмэлт болон дээд боловсрол,</p>	<p>МФАХ-ийн эцсийн хамрах хүрээ нь салбарын оролцооны хөтөлбөрүүдийг зохион байгуулж, Монгол улсын</p>

³ Азийн Үнэт цаасны салбар ба Санхүүгийн зах зээлийн холбоо. Финтек хөгжлийн шилдэг туршлагууд, Эндээс үзнэ үү: <https://www.asifma.org/wp-content/uploads/2018/05/asifma-best-practices-for-effective-development-of-fintech-june-2017.pdf>

⁴ CGFin (n.d.). Финтек санаачилгыг хэрэгжүүлэх хоёрдугаар уулзалт. Эндээс үзнэ үү: <http://www.government-world.com/coordination-group-on-implementation-of-fintech-initiatives-convenes-second-meeting/?print=pdf>

⁵ Ирланд улсын Засгийн газар (n.d.). Ирланд улсын санхүүгийн үйлчилгээний салбарын хөгжлийн 2026 он хүртэлх стратеги, Эндээс үзнэ үү: <https://assets.gov.ie/238832/e6d8cd40-7d4a-48f3-863b-1726ab3eeaa6.pdf>

Байршил	Тайлбар	Монгол улсад хэрэгжүүлж болох гол шийдлүүд
	<p>Судалгаа, Инновац, Шинжлэх ухааны газар болон бусад аж ахуйн нэгж байгууллагуудын албан тушаалтнууд багтдаг. Энэхүү чиглүүлэх бүлгийн үндсэн үүрэг нь ЕХ-ны Дижитал Санхүүгийн Багц хуульд заасны дагуу Финтекийн бодлого боловсруулахад идэвхтэй хувь нэмэр оруулах, хууль тогтоомжийн төсөл санал болгох явдал юм.</p> <p>Энэхүү бүлэг нь (i) агентлагуудын дунд хэрэглэгчийн боловсрол, дижитал хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг зохицуулах, (ii) гол оролцогч талуудад чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх (салбарын оролцогч талуудын харилцаа холбоог нэмэгдүүлэх), (iii) түүнчлэн Финтекийн олон улсын бодлогын хөгжлийг ажиглах зэрэг үүрэгтэй.</p> <p>Мөн Сангийн яам өөрийн жил бүрийн ажлын тайлангийн тодорхой хэсэгт Финтекийн Чиглүүлэх Бүлгийн хийсэн гол алхмууд болон түүний ахиц дэвшлийг оруулах үүрэг хүлээдэг. Тодруулбал, тайлан нь тус бүрийн үйл ажиллагааг хариуцсан гол удирдлагыг тодорхойлж, үйл ажиллагаа нь дууссан, төлөвлөгөөний дагуу явж байгаа, саатсан эсвэл цуцлагдсан байдлыг тодорхойлно. Энэ нь хариуцлагыг бий болгож, Финтекийн Чиглүүлэх Бүлгийн ажлын ил тод байдал, нээлттэй байдлыг хангадаг.</p>	<p>Финтекийн стратегийг хэрэгжүүлэхэд идэвхтэй хувь нэмэр оруулах чиглэлээр өргөжих боломжтой.</p>

3.2.2 Арга хэмжээ 1.2: Засгийн газрын түвшинд мэдээлэл хуваалцах механизмыг хөгжүүлэх

Хүснэгт 4: Арга хэмжээ 1.2-ын хураангуй

Зорилт	Финтектэй холбоотой бодлогын шинэчлэлт, зохицуулалтын өөрчлөлтүүдийг түгээх суваг нь төрийн байгууллага хооронд Финтектэй холбоотой бодлого, зохицуулалтуудын нэгдсэн ойлголтын дутмаг байдлыг шийдвэрлэх боломжтой.
Тайлбар	<p>Энэ суваг нь төрийн бүх албан хаагчид нэвтрэх боломжтой дотоод вэбсайт (жишээлбэл, засгийн газрын дотоод сүлжээ) хэлбэртэй байж болно. Үүгээр Финтек салбарт нөлөөлж буй бодлого болон Финтек компаниудын зохицуулалтын талаарх өөрчлөлт, мэдээллээр хангах боломжтой.</p> <p>Хууль тогтоомжийн текстийг бүхэлд нь оруулдаг одоогийн порталууд (жишээ нь, legalinfo.mn)-аас ялгаатай нь засгийн газрын одоо байгаа үйл явцад шинэ бодлогын үр дагавар, хэрэглээг тодруулахад төвлөрдөг.</p>
Хэрэгжилтийг удирдах субъект	МФАХ
Оролцогч талууд	Одоогийн төрийн байгууллага хоорондын мэдээллийн санд хандах эрхтэй бүх яамд, төрийн байгууллагуудын төлөөллүүд
Алхмууд	Засгийн газрын түвшинд мэдээлэл хуваалцах механизмыг хөгжүүлэхийн тулд дараах алхмуудыг хэрэгжүүлэх боломжтой.

1. **Мэдээлэл хуваалцах механизмыг хөгжүүлэх мэдээлэл технологийн төсөл хэрэгжүүлэх.** Үйл ажиллагаа 1.1-ийн дагуу байгуулагдсан МФАХ нь мэдээлэл хуваалцах суваг хөгжүүлэх мэдээлэл технологийн төслийн багийг бүрдүүлэх боломжтой. Төслийн багийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монгол банкны төлөөлөгчид удирдаж, төрийн байгууллагууд хоорондын мэдээлэл хуваалцах одоогийн механизм (жишээ нь төрийн үйлчилгээний дотоод портал ажилладаг бол)-ыг хянан, мэдээлэл хуваалцах сувгийн хэрэглэгчийн шаардлагыг судлан (боломжит хэрэглэгчид, хуваалцах боломжтой мэдээллийн хэлбэр, шинэчлэлийн давтамж гэх мэт), мэдээлэл хуваалцахад тохиромжтой хувилбарыг боловсруулах боломжтой.
2. **Мэдээлэл хуваалцах дотоод платформ байгаа эсэх, эсвэл гуравдагч талын шийдэл шаардлагатай эсэхийг үнэлэх.** Хэрэв тийм платформ байгаа тохиолдолд төслийн баг нь тухайн платформ агентлагуудын хэрэгцээ шаардлагад хангалттай нийцэж байгаа эсэх, нэмэлт сайжруулалт эсвэл шинэ платформ шаардлагатай эсэхэд үнэлгээ хийнэ. Тийм платформ байхгүй тохиолдолд төслийн баг нь шинэ платформ бий болгоход шаардлагатай гол функцүүдийг тодорхойлон, МФАХ-д тохирох зөвлөмж боловсруулна.
3. **Засгийн газрын агентлагууд хооронд мэдээлэл хуваалцах сувгаар мэдээлэл илгээх стандарт протокол боловсруулах.** Үүнд чиглүүлэгчдийг томилох, мэдээлэл илгээх загвар болон цагийн хуваарийг стандартчилах зэрэг орж болно. Байгууллага бүр хууль тогтоомжид орсон нэмэлт өөрчлөлт, шинээр батлагдсан хууль тогтоомжийн талаар мэдээлэл илгээх ажилтныг томилох хэрэгтэй. Мөн мэдээлэл илгээхэд зориулсан тодорхой, стандарт загваруудыг боловсруулж, тодорхой хугацааг тохируулсан байх хэрэгтэй. (хууль батлагдсанаас эсвэл нэмэлт өөрчлөлт оруулснаас хойш ажлын X хоногийн дотор гэх мэт)
4. **Байгууллага бүрийн албан тушаалтнууд мэдээлэл хуваалцах сувгийн талаар мэдээлэлтэй байж, хэрхэн ашиглахыг мэддэг байх нөхцөлийг бүрдүүлэх төлөвлөгөө боловсруулах.** Монгол Улсын бүх агентлагуудын мэдээллийн уялдаа холбоог сайжруулах зорилгоор мэдээлэл хуваалцах платформын бүх функцын хэрэглэгчдийг сургах, хэрэглээг нэмэгдүүлэх шаардлагатай. Үүний дараа мэдээлэл хуваалцах сувгийн ажиллагааг хэвийн хадгалах, хэрэглэгчдийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх үүргийг МФАХ-ийн “бодлого зохицуулалт ба хөгжүүлэлт” чиглэл хариуцах боломжтой.

4 Салбарын оролцоог бэхжүүлэх

Финтекийн өсөлтийг дэмжих таатай орчныг бүрдүүлэхийн тулд салбарын оролцогчид болон зохицуулах байгууллагууд хооронд бодлогын чиглэл болон дэмжлэгийн санаачилгын талаар тогтмол санал хүсэлт авч, уялдаа холбоог хангах нь чухал юм. Үүнд хэрэгжүүлэх гол алхмуудын нэг нь Финтек Консьерж (ФК) үйлчилгээг бий болгох явдал.

4.1 Одоогийн нөхцөл байдал ба тулгамдаж буй асуудал

2021 оноос Монгол банкны дэргэд “Инновацийн оффис” ажиллаж эхэлсэн бөгөөд Төлбөрийн системийн тухай хуулийн хүрээнд төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдийг дэмжиж, Монгол банктай харилцах боломжийг олгодог. 2024 оны 9 дүгээр сард энэхүү санаачилгыг илүү гүнзгийрүүлэн, өргөжүүлж “Инновацийн төв” хэлбэрээр хөгжүүлсэн ба уг төв нь (i) Монгол банкны зохицуулалттай үйлчилгээнд хамаарах Финтек компаниудад холбогдох бодлого, зохицуулалтын талаар мэдээ, мэдээлэл авахад дэмжлэг үзүүлэх; (ii) Финтек компаниудтай бодит уулзалт, харилцаа тогтоох замаар тэдний хэрэгцээ шаардлага, тулгарч буй бодлогын хүндрэлүүдийг тодорхойлох; (iii) Монгол Улсын Финтек бодлогыг салбарын шинэ хандлага, технологийн хөгжилтэй нийцгэй байлгах зорилготой. Энэ нь Финтек компаниуд зохицуулах байгууллагуудтай харилцаа холбоотой байж бодлогын өөрчлөлтүүдийг ойлгох, Финтект хамаарах бодлогод өөрсдийн санал, байр суурийг хүргэхэд тулгардаг бэрхшээлүүдийг шийдвэрлэх эерэг үр дүнтэй. Гэсэн хэдий ч ихэнх Финтек компаниуд Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтад хамаардаг бөгөөд Санхүүгийн зохицуулах хороо нь Банк бус санхүүгийн байгууллагын гол зохицуулах байгууллага тул Финтек салбарын харилцаа, хамтын ажиллагаанд Монгол банк болон Санхүүгийн зохицуулах хороо хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх нь чухал юм. Тулгамдаж буй асуудлыг дараах байдлаар тодорхойлов.

- **Салбарын асуудал шийдвэрлэхэд чиглэсэн Санхүүгийн зохицуулах хорооны эрх мэдэл хязгаарлагдмал.** Санхүүгийн зохицуулах хороо нь ББСБ-ууд болон Сэндбоксын албыг хариуцан ажилладаг агентлагын хувьд тусгай зөвшөөрөл, зохицуулалтын шаардлагуудтай холбоотой асуудлууд болон Финтек Сэндбоксоор дамжуулан татвар, хууль сахиулах байгууллагатай холбоотой асуудлаар тодруулсан хүсэлтүүдийг тогтмол хүлээн авдаг. Гэсэн хэдий ч Сэндбоксын алба нь эдгээр асуултад хариу өгөхөд зориулагдсан тусгай нөөц бололцоогүй бөгөөд энэ нь тэдний албан ёсны үүрэгт багтдаггүй. Илүү өргөн хүрээнд авч үзвэл Санхүүгийн зохицуулах хороо нь одоогоор эдгээр хүсэлт, асуудлыг шийдвэрлэхэд зориулагдсан нөөц хуваарилах бүрэн эрхгүй. Иймд Санхүүгийн зохицуулах хороонд салбарын оролцоог хангах тодорхой чиг үүргийг олгох нь туйлын чухал байна.
- **Зохицуулалтын тодорхойгүй байдал болон тодруулга авах тодорхой платформ байхгүй нь сорилт болж байна.** Хэдийгээр Монгол банкны дэргэр Инновацын оффис ажиллаж байгаа ч дэмжлэг нь зөвхөн төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч компаниудаар хязгаарлагдаж, бусад төрлийн Финтек бизнесүүдийг зохих зааварчилгаагүйгээр орхиж байна. Үүнээс үүдэлтэйгээр Финтек компаниудын дунд зохицуулалтын тодорхойгүй байдал байсаар байна. Ийм орчин нь уг салбарт шинээр оролцогчдод хүндрэл болж улмаар Монгол улсын Финтек инновацын экосистемийг хөгжүүлэхэд саад болж болзошгүй.

4.2 Санал болгож буй арга хэмжээ

Санхүүгийн зохицуулах хороо, Монгол банк болон салбарын оролцогчдоос ирүүлсэн санал хүсэлтэд үндэслэн Санхүүгийн зохицуулах хороо болон Монгол банкны хамтын оролцоотойгоор иж бүрэн дэмжлэг үзүүлэх Финтек консьерж үйлчилгээг бий болгохыг санал болгож байна. Энэхүү үйлчилгээ нь Финтектэй холбоотой бүхий л асуудлыг шийдвэрлэж, салбарын хариу үйлдлийг сайжруулах, улмаар зохицуулалтын тодорхойгүй байдлыг бууруулах нэг цэг болж ажиллана.

4.2.1 Арга хэмжээ 2.1: Финтек Консьерж (ФК) үйлчилгээг бий болгох

Хүснэгт 5: Арга хэмжээ 2.1-ийн хураангуй

Зорилт	Монгол банкны Инновацийн оффис болон Санхүүгийн зохицуулах хорооны Сэндбоксын алба хамтарсан Финтек Консьерж (ФК) үйлчилгээг бий болгох
Тайлбар	Финтек консьерж үйлчилгээ нь салбарын оролцогчдод Финтектэй холбоотой асуудлуудыг хөндөж холбогдох агентлаг (Санхүүгийн зохицуулах хороо болон Монгол банк)-т дамжуулах нэг цэг болдог. Финтек консьерж үйлчилгээ нь Монгол банк болон Санхүүгийн зохицуулах хорооноос бодлого, зохицуулалтын аливаа өөрчлөлтийг салбарын оролцогчдод шат дараатайгаар хүргэх, мөн салбарын зүгээс төрийн зохицуулагч байгууллагуудтай холбоо тогтоож, тулгарч буй асуудал, төрийн бодлогын талаарх санал хүсэлтээ хүргэх боломжтой нэгдсэн платформ болж үйлчилдэг.
Хэрэгжилтийг удирдах субъект	Монгол банкны Инновацийн оффис болон Санхүүгийн зохицуулах хорооны Сэндбоксын алба
Алхмууд	<p>Хэрэгжүүлэх тодорхой алхмуудыг дараах байдлаар тодорхойлов.</p> <ol style="list-style-type: none"> Салбарын оролцоонд Санхүүгийн зохицуулах хорооны бүрэн эрхийг бэхжүүлэхийн тулд Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах. Үүнд Санхүүгийн зохицуулах хорооны бүрэн эрх, бусад зохицуулагч байгууллагуудтай хамтран ажиллахтай холбоотой бүх зүйл заалтад өөрчлөлт оруулах хэрэгтэй. Тухайлбал: <ul style="list-style-type: none"> 6-р зүйл: Хорооны бүрэн эрх <p>Санхүүгийн зохицуулах хорооны бүрэн эрхийг тодорхойлсон 6-р зүйлд “Санхүүгийн зохицуулах хороо нь Финтек консьерж (“ФК”) үйлчилгээг хөгжүүлж, зохицуулах замаар санхүүгийн инновацийг дэмжих, зохицуулах үүргийг хүлээнэ. ФК нь финтек салбарын оролцогчдод зориулсан нэг цэг болж, зохицуулалтын зөвлөмж өгөх, сэндбоксад орох боломжийг хялбаршуулж, зохицуулах байгууллагууд, салбарын болон бусад оролцогчдын хамтын ажиллагааг идэвхжүүлэх чиглэлээр ажиллана.” гэсэн агуулгатай нэмэлт өөрчлөлтийг оруулах.</p> <ul style="list-style-type: none"> 10-р зүйл: Хороо Монгол банк, Засгийн газартай харилцах <p>Финтекийн асуудлаар Санхүүгийн зохицуулах хороо нь Монголбанк болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллахыг хуульчилсан нэмэлт өөрчлөлтийг 10 дугаар зүйлд оруулах хэрэгтэй. Үүнийг дараах байдлаар тусгаж болно: “Санхүүгийн зохицуулах хороо нь Монгол банк болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, финтекийн зохицуулалтын хандлага ба инновацийн асуудлаар уялдаа холбоог хангах үүрэгтэй. Санхүүгийн</p>

зохицуулах хороо нь Монгол банктai хамтран Финтек консьерж үйлчилгээг хянах, зохицуулагч байгууллага хоорондын зохицуулалттай холбоотой асуудлыг шийдвэрлэх чиглэлээр хамтран ажиллана.”

2. **Шинээр бий болсон Финтек Консьерж үйлчилгээний хүрээг тодорхойлох баримт бичиг (TOR)-ийг боловсруулах.** Монголбанкны Инновацийн Оффис болон Санхүүгийн зохицуулах хорооны Сэндбокс алба хамтран Финтек консьерж үйлчилгээ (ФК)-г бий болгох үйл ажиллагааг хянах боломжтой. ФК нь салбарын оролцогчидтой харилцах, дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй гэдгийг тодорхой зааж, удирдлагын бүтэц нь ойлгомжтой байхын тулд, тодорхой үүрэг, зорилго бүхий Ажлын даалгаврыг (TOR) боловсруулж гаргах шаардлагатай. Ажлын даалгаварт (i) ФК-ийн бүрэн эрх болон зорилгууд, (ii) удирдлага болон тайлагналын бүтэц, (iii) үйл ажиллагааны зарчмууд зэргийг тусгаж болно. Хавсралт А-ын Бокс В-д санал болгож буй Үйлчилгээний хүрээг тодорхойлох баримт бичгийн загварыг оруулав.
3. **Танилцуулга хийх.** ФК үйлчилгээг бий болгосны дараа салбарын оролцогч талуудын дунд танилцуулга хийх нь чухал бөгөөд энэ нь тэдэнд ФК үйлчилгээг оролцооны суваг болгон ашиглах боломжийг олгох юм. Үүний тулд санхүүгийн үйлчилгээний салбарын байгууллагууд ФК үйлчилгээ болон үүнийн чиг үүргийн талаар ойлголттой болохуйц маркетингийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх хэрэгтэй.

Хүснэгт 6: Арга хэмжээ 2.1-г хамаарах сайн туршлагууд

Байршил	Тайлбар	Монгол улсад хэрэгжүүлж болох гол шийдлүүд
Их Британи	<p>Их Британи улсын Санхүүгийн зохицуулах газрын Инноваци төсөл.⁶</p> <p>Их Британи улсын Санхүүгийн Зохицуулах Газар (СЗГ) 2024 онд дэлхийн анхны Инноваци Төвийг байгуулсан. Эхэн үедээ уг төв нь байгууллагын бусад газар, нэгжүүдээс шилжин ирсэн ажилтнуудаар удирдуулсан жижиг хэлтэс хэлбэрээр ажиллаж байсан. Нөөц бололцоо нь хязгаарлагдмал байсан тул СЗГ нь дэмжлэг хүссэн бизнесүүдэд тодорхой шалгууруудыг тогтоон оруулж байв. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ● Инноваци нь бодит байх. ● Шууд болон шууд бус хэрэглэгчид тодорхой үр ашигтай байх. ● Тухайн бизнес нь зохицуулалтын тогтолцоог ойлгож хэрэгжүүлэхэд цаг хугацаа болон нөөц бололцоогоо зарцуулсан байх. 	<p>ФК үйлчилгээгээр дэмжлэг авах боломжтой бизнесүүдийн төрөлд тодорхой шалгуур үзүүлэлтүүдийг тогтоох нь нөөцийг үр ашигтай хуваарилах, ерөнхий зөвлөх үйлчилгээ болохоос сэргийлэх нь чухал юм. Энэ нь ФК үйлчилгээг хязгаарлагдмал хүний нөөцөөр</p>

⁶ Олон улсын Валютын сан (2023). Финтек зохицуулалтын институцийн зохицуулалт: Хянагчдыг хянах нь, Эндээс үзнэ үү: <https://www.imf.org/-/media/Files/Publications/FTN063/2023/English/FTNEA2023004.ashx>

Байршил	Тайлбар	Монгол улсад хэрэгжүүлж болох гол шийдлүүд
	<ul style="list-style-type: none"> Тухайн бизнес нь шууд дэмжлэг хүсч буй бодит хэрэгцээгээ харуулах. <p>Эдгээр заавар нь дэмжлэг хамгийн их шаардлагатай газруудад хүрч, хүчтэй нөлөө үзүүлэхэд чиглэдэг бөгөөд шинээр байгуулагдсан, нөөц хязгаарлагдмал байгууллагын хувьд зайлшгүй арга зам юм.</p>	<p>хүргэх тохиолдолд илүү чухал ач холбогдолтой.</p>
Их Британи	<p>Их Британи улсын Санхүүгийн зохицуулах газрын Инноваци төсөл.⁵</p> <p>Их Британи улсын СЗГ-аас Инноваци Төвөөр дамжуулан үр дүнтэй дэмжлэг үзүүлэх зорилгоор төрөл бүрийн арга хэрэгслийг ашигладаг. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> Имэйл, зөвлөх үйлчилгээгээр дамжуулан хувь хүмүүст гарын авлага хүргэх Албан бусаар чиглүүлэх (СЗГ-ын дүрэм журам, зохицуулалтын дагуу) Холбогдох зохицуулалтын хэсгүүдрүү чиглүүлэх Тусгай зөвшөөрөл болон энгийн зөвшөөрөл авахад дэмжлэг үзүүлэх Тусгай зөвшөөрөл болон энгийн зөвшөөрөлтэй компаниудад дэмжлэг үзүүлэг 	<p>Төрөл бүрийн арга хэрэгсэл ашиглах нь Монгол улсад бизнесийн асуудлуудыг үр дүнтэй зохицуулж, илүү төвөгтэй асуудлуудад хүний нөөцийг оновчтой хуваарилах боломжийг олгоно.</p>
Австрали	<p>Австралийн Үнэт цаас, Хөрөнгө оруулалтын комисс (“ASIC”)-ын Инновацийн Төв.⁷</p> <p>2015 онд байгуулагдсан ASIC-ийн Инновацийн төв нь Австралийн Финтек компаниудад тулгарч буй бүх Финтек болон Регтекийн зохицуулалтын асуудлуудыг шийдвэрлэх нэг цэгийн үйлчилгээний үүрэгтэй. Тус дэмжлэг нь Финтекийн бизнест нөлөөлж болзошгүй Австралийн өргөн хүрээний зохицуулалтын тогтолцоо, түүнчлэн Хамтын нөхөрлөлийн Засгийн газрын сайжруулсан зохицуулалтын сэндбокс орчин зэрэг санаачилгуудаар дамжуулан шинэлэг бизнес эрхлэгчдэд өөрсдийн боломжит зохицуулалтын үүрэг хариуцлагын талаар дэмжлэг үзүүлэх хэлбэрээр олгодог. Мөн ASIC Инновацийн төв нь Финтектэй холбоотой салбар дахь дотоодын болон олон улсын яриа, түншлэлийн платформ болдог.</p>	<p>ФК үйлчилгээний хамрах хүрээг явцдаа Финтектэй холбоотой олон улсын хэлэлцүүлэг, түншлэлийн платформ болгон өргөжүүлж болно.</p>
Хонгконг	<p>Үнэт цаас, фьючерсийн комисс (SFC) Финтекийн холбоо барих цэг⁸</p> <p>Финтекийн холбоо барих цэгийг Хонг Конгийн Үнэт цаас, фьючерсийн хорооноос (SFC) байгуулсан бөгөөд Хонг Конг дахь Финтекийг хөгжүүлэх, хэрэглэхэд оролцож буй бизнес эрхлэгчидтэй харилцах харилцааг сайжруулах зорилготой. Энэхүү платформ нь Финтекийн компаниудад зориулсан</p>	<p>Финтекийн салбарт оролцож буй компаниудын нэг цэгийн холбоог бий болгох нь зохицуулалтын</p>

⁷ ASIC (п.д.). Инновацийн төв. Эндээс үзнэ үү: <https://asic.gov.au/for-business/innovation-hub/>

⁸ Үнэт цаас, фьючерсийн комисс (SFC) (2024). Финтекийн холбоо барих цэг. Эндээс үзнэ үү: <https://www.sfc.hk/en/Welcome-to-the-Fintech-Contact-Point>

Байршил	Тайлбар	Монгол улсад хэрэгжүүлж болох гол шийдлүүд
	<p>холбоо барих нэг сувгаар хангаж, зохицуулалтын асуудлаар харилцан яриа өрнүүлж, холбогдох санхүүгийн зохицуулалтын талаар зааварчилгаа өгдөг. Харилцаа холбоог хялбарчлах замаар SFC нь Финтекийн салбарт бизнес эрхлэгчдийг дагаж мөрдөх шаардлагыг илүү үр дүнтэй удирдахад нь туслах зорилготой.</p>	<p>харилцаа холбоог оновчтой болгоход тусалж, бизнесүүд дагаж мөрдөх шаардлагын талаар цаг тухайд нь удирдамж, дэмжлэг авах боломжийг олгоно.</p>

5 Инновацын таатай орчныг бий болгох

Финтекийн өсөлтийг хангах таатай орчныг бүрдүүлэхийн тулд бодлого, зохицуулалт нь инновацид чиглэсэн, шинээр гарч ирж буй бизнесийн загвар, технологийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай. Хэрэгжүүлэх үйл ажиллагаануудад (a) инновацийг дэмжих зорилгоор Төлбөрийн системийн журамд нэмэлт, өөрчлөлт оруулах; (b) Финтек төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдийн RTGS болон АСН системд шууд оролцохыг дэмжих зорилгоор зохицуулалтыг хянан үзэх; (c) уламжлалт бус бизнесийн загварт тавих зохицуулалтын хяналтыг сайжруулах зорилгоор Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах; (d) төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдэд компаниудад зориулсан шаталсан тусгай зөвшөөрлийн тогтолцоог хэрэгжүүлэх; (e) банкуудад тусгай зөвшөөрлийн шаталсан аргыг хэрэгжүүлэх; (f) салбараар удирдуулсан хандлагаар нээлттэй банкны хөгжлийг дэмжих зэрэг орно.

5.1 Одоогийн нөхцөл байдал ба тулгамдаж буй асуудал

Илүү уян хатан, шинэлэг Финтекийн зах зээлийг бий болгохын тулд Монгол Улс эрсдэл багатай гэж үнэлэгдсэн салбаруудад зохих хамгаалалтыг бий болгохын зэрэгцээ зохицуулалтын түвшинг бууруулах, эрсдэлд суурилсан хяналтад чиглэсэн зохицуулалтын тогтолцоог бий болгох алхмуудыг авч үзэх боломжтой. Энэ нь санхүүгийн тогтвортой байдлыг хангахын зэрэгцээ зах зээлийн өрсөлдөөнийг дэмжиж, шинэлэг туршлагыг дэмжих болно. Тодруулбал, дараах асуудлуудыг дурдаж болохоор байна.

- **Зах зээлд нэвтрэх оролдлогыг удаашруулж, өрсөлдөөнд сөргөөр нөлөөлж болзошгүй зохицуулалтууд.** Төлбөрийн системийн журамд карт хүлээн авагчийн мерчантуудаас авах болон карт гаргагчид төлөх шимтгэлийн хязгаарлалтуудыг тогтоосон. Эдгээр хязгаарлалт нь карт хүлээн авагчдын олж болох орлогын хэмжээг хязгаарлаж, улмаар инновацыг дэмжих урам зоригийг бууруулж байна. Өрсөлдөөн нэмэгдэхэд саад учруулж болзошгүй бусад хэсэгт банк бус төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид нь зөвхөн төлбөр тооцооны төлөөлөгч банкаар дамжуулан төвлөрсөн төлбөрийн дэд бүтцэд нэвтрэх боломжтой байх, бүх төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид системд эзлэх хэмжээ, эрсдэлээс үл хамааран ижил тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийн нөхцөл тогтоосон зохицуулалт багтана. Эдгээр нь жижиг, анхдагч түвшний компаниудад сул тал болж, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч болон Финтек экосистемийн хөгжилд саад учруулж болзошгүй юм.
- **Зохицуулалтын уян хатан байдлыг хязгаарлаж, шинээр гарч ирж буй эрсдлийг хангалтгүй удирддаг тусгай зөвшөөрлийн тогтолцоо.** Одоогийн тусгай зөвшөөрлийн тогтолцоо нь BNPL болон мөнгөний зах зээлийн арилжаа зэрэг Финтекийн тодорхой бизнесийн загварууд нь хяналт зохицуулалтын гадна үйл ажиллагаа явуулж байгаа нь тодорхой бус байдал, хэрэглэгчийн эрхийн хамгаалалт бүрхэг байдалд хүргэж байна.

5.2 Санал болгож буй арга хэмжээ

Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк болон салбарын оролцогчдоос ирүүлсэн санал хүсэлтэд үндэслэн Финтекийн салбарт зах зээлд нэвтрэх, өрсөлдөөнийг дэмжих замаар инновацид таатай орчин бүрдүүлэхийн тулд дараах зөвлөмжийг боловсруулав. Үүнд (санал болгож буй дарааллын дагуу хэрэгжүүлнэ):

- (i) Инновацийг дэмжихийн тулд Төлбөрийн системийн журамд нэмэлт, өөрчлөлт оруулах
- (ii) Финтек төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид АСН системд шууд хандах боломжийг дэмжих зорилгоор зохицуулалтыг хянаж үзэх
- (iii) Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай (ББСҮА) хуулийн төслийн шинэчлэлтийг хянан үзэх
- (iv) Уламжлалт бус Финтек бизнесийн загварт тавих зохицуулалтын хяналтыг сайжруулах үүднээс Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах
- (v) Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч компаниудад шаталсан тусгай зөвшөөрлийн тогтолцоог хэрэгжүүлэх
- (vi) Нээлттэй банкны хөгжлийг удирдамж боловсруулах замаар дэмжих

Тайлбар: Арга хэмжээ 3.1 болон 3.2 нь зах зээлд нэвтрэх, өрсөлдөөнийг бүрдүүлдэг харилцан уялдаатай хүчин зүйлүүд байдаг тул хамтад нь хэрэгжүүлэх нь тохиромжтой. Аль нэгийг нь дангаар нь хэрэгжүүлэх нь төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдэд өрсөлдөөний таатай орчныг бий болгох зорилготой үр дүнд хүрэхгүй.

5.2.1 Арга хэмжээ 3.1: Инновацийг дэмжихийн тулд Төлбөрийн системийн журамд нэмэлт, өөрчлөлт оруулах

Хүснэгт 7: Арга хэмжээ 3.1-ийн хураангуй

Зорилт	Төлбөрийн системийн журамд нэмэлт, өөрчлөлт оруулснаар карт хүлээн авагчдын авах болон карт гаргагчдад төлөх шимтгэлийн хязгаарлалтуудыг багасгах.
Тайлбар	<p>Төлбөрийн системийн журамд карт хүлээн авагчийн мерчантуудаас авах болон карт гаргагчид төлөх шимтгэлийн талаар олон төрлийн хязгаарлалтуудыг тогтоосон. Эдгээр хязгаарлалт нь олж болох орлогын дээд хэмжээг хязгаарлаж, зах зээлд нэвтрэх, инновацийг хөгжүүлэх боломжийг бууруулна. Тухайлбал, дараах зохицуулалт байна:</p> <ol style="list-style-type: none">(i) Төрийн зарим үйлчилгээнд мерчантын үйлчилгээний шимтгэл авахыг хязгаарладаг. Төлбөрийн системийн журмын 5.32-т зааснаар карт хүлээн авагч нь төрийн үйлчилгээний болон орон сууцны хэрэглээний төлбөрт мерчантаас хураамж авах эрхгүй. Гэхдээ тэд хэрэглэгчдээс гүйлгээ бүрээс 300 хүртэл төгрөгийн хураамж авах боломжтой;(ii) Бараа үйлчилгээний төлбөрийг картаар хүлээн авсан тохиолдолд карт хүлээн авагчийн мерчантаас авах гүйлгээний шимтгэлийн дээд хязгаар нь гүйлгээний үнийн дүнгийн 3% байхаар тогтоосон.(iii) Карт хүлээн авагч нь мерчант дээр хийгдсэн гүйлгээний үнийн дүнгийн 0.3%-с доошгүй хэмжээтэй шимтгэлийг карт гаргагчид төлөхөөр тогтоосон.

	<p>Ялангуяа (i)-т дурдсан хязгаарлалт нь карт хүлээн авагчдад энэхүү төлбөрийг хэрэглэгчээс авахгүй байхаар шийдсэн тохиолдолд алдагдал хүлээхэд хүргэж болзошгүй. Энэ нь төлбөрийн үйлчилгээгээр дагнасан жижиг Финтек компаниудад ихээхэн ач холбогдолтой байх бөгөөд ихэнх тохиолдолд эдгээр компаниуд томоохон банкууд шиг төрөлжсөн орлогын эх үүсвэргүй байдаг. Үүний үр дүнд жижиг компаниуд эцсийн хэрэглэгчдээс төлбөр авахаас өөр аргагүй болж, томоохон тоглогчидтой өрсөлдөх чадварыг бууруулж, салбарын инновацид сөргөөр нөлөөлнө. Ерөнхийдөө өрсөлдөөний орчинд сөргөөр нөлөөлдөг шимтгэлийн хязгаарлалтыг цуцлах нь Финтек төлбөрийн үйлчилгээний өсөлтийг дэмжиж, мерчантууд болон хэрэглэгчдэд ашиг тусаа өгөх боломжтой.</p>
<p>Хэрэгжилтийг удирдах субъект</p>	<p>Монголбанкны Төлбөр тооцооны газар</p>
<p>Алхмууд</p>	<p>Дараах алхмуудыг хэрэгжүүлэх боломжтой.</p> <ol style="list-style-type: none"> 1. Төрийн үйлчилгээний төлбөрт мерчантын шимтгэл авахыг хязгаарласныг хасах. Төрийн байгууллагуудаас мерчантын үйлчилгээний шимтгэл авахыг хориглосон одоогийн хязгаарлалт нь үнэ тогтоох бүтцэд гажуудал үүсгэж, өрсөлдөөнд сөргөөр нөлөөлж байна. Энэ нь карт хүлээн авагчид гарах зардлаа нөхөхийн тулд хувийн хэвшлийн хэрэглэгчдэд илүү өндөр хураамж тогтоох замаар зөрүүг тэнцүүлэхээс өөр аргагүйд хүргэдэг. Зах зээлийн тэгш байдлыг хангахын тулд Монголбанк Төлбөрийн системийн журмын 5.32 дахь заалттай холбоотой төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн мерчанттай байгуулах гэрээнд төрийн үйлчилгээний төлбөр, орон сууцны хэрэглээний төлбөрөөс бусад картын гүйлгээнд үед мерчант нь карт эзэмшигчээс шимтгэл авахгүй байх тухай тусгахаар заасныг хасах хэрэгтэй. Журмын 5.32 болон 5.33 дах заалтуудыг хассанаар байгууллагын хэлбэрээс үл хамааран бүх байгууллагуудад ижил тэгш хандаж, журмын 5.29-өөс 5.34 дэх заалтын зохицуулалтууд бүгдэд нь ижил үйлчилнэ.⁹ Энэ нь Хүснэгт 8-д үзүүлэх АНУ-ын хэрэгжүүлж буй хандлагатай нийцнэ. 2. Карт хүлээн авагчийн мерчантаас авах гүйлгээний шимтгэлд тогтоосон хязгаарлалтыг хасах. Журмын 5.29 дүгээр зүйлд бараа, үйлчилгээний төлбөрийг картаар хүлээн авсан тохиолдолд карт хүлээн авагчийн авах гүйлгээний шимтгэлийн дээд хязгаар нь гүйлгээний үнийн дүнгийн 3 хувь байхаар заасан. Энэ нь одоогоор хязгаарлалт мэт харагдахгүй байгаа боловч (зөвлөлдөх уулзалтын үеэр зах зээлийн ханш ойролцоогоор 1 хувь орчим байдгийг ажигласан) урт хугацаандаа зах зээлд нэвтрэх, өрсөлдөөнд сөргөөр нөлөөлж, инновацид сөрөг үр дагавар авчрах боломжтой. Тиймээс инновацид саад болох нөхцөлийг багасгах үүднээс энэ заалтыг хасах нь зүйтэй. 3. Зах зээлийн нөхцөл байдалд тогтмол хяналт тавьж, гүйлгээний шимтгэлийн доод хязгаарыг арилгах шаардлагатай эсэхэд үнэлгээ хийх. Үүний тулд Төлбөр тооцооны газар нь шимтгэлийн

⁹ Журмын 5.32-5.33 дах заалтуудад карт хүлээн авагч банк болон карт эзэмшигчдэд тавигдах хязгаарлалтын хүрээ, нөхцөлүүдийг заасан. Энэ талаарх дэлгэрэнгүйг Төлбөрийн системийн журмаас харах боломжтой: [ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ЖУРАМ](#)

доод хязгаарыг хэвээр үлдээх эсэхийг тодорхойлох зорилгоор салбарын орчныг жил бүр үнэлэх хэмжүүрийг тогтооно. Одоогоор гүйлгээний шимтгэлийн доод хязгаар нь жижиг компаниудын оролцоог дэмжиж байгаа бөгөөд энэ нь нэмэлт орлогын эх үүсвэрүүдээр төлбөрийн бүтээгдэхүүнээ хөнгөлж чадах томоохон компаниудад жижиг компаниудтай шударгаар өрсөлдөхөд бэрхшээл үүсгэхүйц маш бага шимтгэл тогтоохоос сэргийлж байна. Төлбөр тооцооны газар нь шинэ оролцогчдын тоо, эргэлдэж буй мөнгөн хөрөнгийн хэмжээнд орж буй өөрчлөлтүүд, карт гаргагчийн зах зээл дэх инноваци зэрэг хэмжүүрүүдийг хянан үзэх замаар зах зээлийн хөгжлийн түвшинг хэмжих боломжтой. Эдгээр үзүүлэлтүүд нь зах зээлийн төлөвшлийг илэрхийлэх тул хэрэглэгчийн ашиг сонирхолд сөргөөр нөлөөлж болзошгүй зах зээлийн шаардлагагүй гажуудлыг үүсгэхээс сэргийлэх үүднээс шимтгэлийн доод хязгаарыг хасахыг санал болгож байна.

Эдгээрийг нэгтгэн, санал болгож буй нэмэлт, өөрчлөлтүүдийг нэрлэвэл 1) төрийн үйлчилгээний төлбөрт мерчантын шимтгэлийн хязгаарлалтыг арилгах, 2) 3%-ийн шимтгэлийн дээд хязгаарыг арилгах, 3) гүйлгээний шимтгэлийн доод хязгаарыг хянах механизмыг бий болгох. Эдгээр нь хамтдаа илүү динамик төлбөрийн зах зээлийг бий болгож, өндөр ашиг олох боломжийг нэмэгдүүлж, улмаар карт хүлээн авагчдад инноваци хийх, үйлчилгээгээ сайжруулах боломжийг нэмэгдүүлж, эцсийн дүнд урт хугацаандаа мерчантууд болон хэрэглэгчдэд ашигтай байх болно.

Хүснэгт 8: Арга хэмжээ 3.1-г хамаарах сайн туршлагауд

Байршил	Тайлбар	Монгол улсад хэрэгжүүлж болох гол шийдлүүд
Европын холбоо	<p>Европын холбооны Гүйлгээний шимтгэлийн журам¹⁰</p> <p>Европын холбоо 2015 онд Гүйлгээний шимтгэлийн журмыг баталсан бөгөөд картын гүйлгээний шимтгэлийн дээд хязгаарыг тогтоосон. Жишээ нь Журмын 3 дугаар зүйлд төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид нь хэрэглэгчийн дебит картын гүйлгээнд 0.2%-иас дээш хэмжээгээр шимтгэл авахгүй гэж, 4 дүгээр зүйлд төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид нь хэрэглэгчийн кредит картын гүйлгээнд 0.3%-иас дээш хэмжээгээр шимтгэл авахгүй гэж заасан.</p> <p>Гүйлгээний шимтгэлийн дээд хэмжээг ингэж тогтоосон зорилго нь мерчант болон хэрэглэгчийн төлбөрт хэт өндөр зардал гаргахаас урьдчилан сэргийлэх юм. Энэ зохицуулалт нь мерчантуудын зардлыг бууруулж, карт гаргагч болон хүлээн авагч банкуудын хувьд илүү сайн өртөг нэмсэн үйлчилгээг санал болгох өрсөлдөөнийг нэмэгдүүлсэн.</p>	<p>Шимтгэлийн дээд хязгаарыг тогтоох нь хэрэглэгчдэд урамшуулал олгохтой холбоотойгоор карт гаргагчдад төлөх шимтгэлийг бууруулж, мерчантын хэт өндөр зардлыг бууруулахад тусалдаг.</p>

¹⁰ EUR-Lex. Карт дээр суурилсан төлбөрийн гүйлгээний солилцооны шимтгэлийн тухай Европын парламент болон зөвлөлийн 2015/751 тоот журам (EX). Эндээс үзнэ үү. [:https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/HTML/?uri=CELEX:32015R0751#:~:text=Payment%20service%20providers%20shall%20not,for%20any%20debit%20card%20transaction.](https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/HTML/?uri=CELEX:32015R0751#:~:text=Payment%20service%20providers%20shall%20not,for%20any%20debit%20card%20transaction.)

АНУ	<p>Дурбины нэмэлт, өөрчлөлт (Додд-Фрэнк Уолл Стритийн шинэчлэл ба хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль)¹¹</p> <p>Дебит картын гүйлгээний шимтгэлийг зохицуулах Додд-Фрэнкийн хуулийн нэг хэсэг болгон Дурбины нэмэлт өөрчлөлтийг баталсан. Үүний зорилго нь шимтгэлийн хэмжээг зардалд үндэслэн тооцоолж бүх мерчантуудад ижил үйлчлэхээр зохицуулсан. Нэмэлт, өөрчлөлт нь мерчантын үйлчилгээний ерөнхий шимтгэлээс илүү дебит картын гүйлгээний шимтгэлийг голчлон зохицуулж байгаа боловч энэхүү зохицуулалт нь шимтгэлийн тооцоход төрийн байгууллагууд ямар ч тусгай чөлөөлөлтгүй гэдгийг харуулж байна.</p> <p>Дурбины нэмэлт, өөрчлөлтийн заалтууд нь төлбөр хүлээн авч буй мерчантын төрлөөс үл хамааран дебит карт гаргагч бүх байгууллагад тэгш үйлчилдэг. Үүний үр дүнд, шимтгэлийн бүтэц нь төрийн байгууллагуудад давуу эрх олгох эсвэл чөлөөлөх зорилготой биш гэдгийг харуулж байна.</p>	Шударга өрсөлдөөнийг дэмжихийн тулд төрийн байгууллагууд болон хувийн компаниудад ижил хандах ёстой.
-----	---	--

5.2.2 Арга хэмжээ 3.2: Финтек төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид АСН системд шууд хандах боломжийг дэмжих зорилгоор зохицуулалтыг хянаж үзэх

Хүснэгт 9: Арга хэмжээ 3.2-ын хураангуй

Зорилт	Банк бус төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдэд Автомат клиринг хаус (АСН) системд шууд холбогдох боломжийг олгох үүднээс банк бус төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдийн шууд оролцоонд хамгийн бага түвшний стандартуудыг тогтоож, өрсөлдөөнийг дэмжих.
Тайлбар	<p>Автомат клиринг хаус системийн дүрмийн журмын 5 дах хэсгийн дагуу төлбөрийн үйлчилгээ үзүүлж буй банк бус санхүүгийн байгууллага (ББСБ) нь АСН системд зөвхөн шууд бус оролцогчоор холбогдохоор зохицуулсан. Сүлжээнд холбогдохын тулд шууд оролцогчтой, ерөнхийдөө банктай төлбөр тооцооны гэрээ байгуулахыг шаарддаг. Энэ нь ББСБ-уудын зардлыг нэмэгдүүлж, төлбөрийн үйлчилгээний зах зээлд шударгаар өрсөлдөх чадварыг хязгаарлаж байна.</p> <p>Төлбөр тооцооны төлөөлөгч (Спонсор банк) нь АСН системд нэвтрэхийг хүссэн шинэ төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдээс хураамж авч, цахим гүйлгээг боловсруулахад шаардлагатай дэд бүтцээр ББСБ-уудыг хангадаг зуучлагч юм. Энэ нь ашиг сонирхлын зөрчил үүсгэх эрсдэлтэйгээс гадна зардлыг нэмдэг. Спонсор банкууд, ихэвчлэн одоогийн банкууд, төлбөрийн үйлчилгээний зах зээлд шууд өрсөлдөгч болох төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдээс давуу байдлаа хадгалахын тулд өөрсдийн энэ үүргээ ашиглах эрсдэлтэй.</p>
Хэрэгжилтийг хангах субъект	Монголбанк

¹¹ Холбооны бүртгэл. Дебит картын солилцооны хураамж ба чиглүүлэлт, Эндээс үзнэ үү, <https://www.federalregister.gov/documents/2023/11/14/2023-24034/debit-card-interchange-fees-and-routing#:~:text=A%20section%20of%20the%20Dodd,issuer%20with%20respect%20to%20the>

Оролцогч талууд	Салбарын оролцогчид, Монгол улсын Монопын эсрэг газар (АМА)
Алхмууд	<p>Төлбөрийн үйлчилгээний зах зээлд шударга өрсөлдөөнийг бий болгохын тулд Автомат Клиринг Хаус системийн дүрмийн журамд дараах нэмэлт өөрчлөлтийг оруулах боломжтой.</p> <ol style="list-style-type: none"> Спонсор банкаар дамжуулан АСН-д холбогдох сонголтыг хэвээр үлдээхийн зэрэгцээ шаардлагатай стандартыг хангасан банк бус төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийг АСН-д шууд холбогдох боломжийг олгох нэмэлт, өөрчлөлтийг Автомат Клиринг Хаус системийн дүрмийн журамд оруулах. Сингапур, Канадын загваруудын нэгэн адил (Хүснэгт 10-д үзүүлсэн) Монголбанк банк бус төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдийг зөвхөн спонсор банкаар дамжуулан оролцохоос гадна өөр горимоор АСН системд оролцох нөхцөлийг олгох ёстой. Одоогоор Автомат Клиринг Хаус системийн дүрмийн журмын 5.3-т “Энэ дүрмийн 5.1.8, 5.1.9¹²-д заасан оролцогч нь зөвхөн шууд бус оролцогчоор холбогдоно.” гэж заасан. Энэ заалтыг 5.1.8, 5.1.9-д заасан оролцогчид өргөтгөсөн 5.4¹³ -т заасан шууд оролцогчийн хамгийн бага түвшний шаардлагыг хангасан тохиолдолд шууд оролцогчоор, эдгээр шаардлагыг хангаагүй бол шууд бус оролцогчоор холбогдох тухай нэмэлт, өөрчлөлтийг оруулах хэрэгтэй. Энэ хүрээнд 5.1.8 ба 5.1.9-д заасан оролцогчид АСН-д шууд нэвтрэхийн тулд хангах ёстой хамгийн бага шаардлагуудыг тогтоохын тулд 5.4-т өөрчлөлт оруулах шаардлагатай. Банк бус төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдийг шууд оролцогч болгоход тавигдах шаардлагуудыг тодорхойлохын тул салбарын оролцогчид болон холбогдох агентлагуудтай хамтран ажиллах. Энэ ажлыг Монголбанкнаас удирдан холбогдох агентлагууд болон салбарын төлөөлөгчдийг оролцуулсан зөвлөлдөх уулзалт зохион байгуулж, Төлбөрийн системийн журмын 3.1.2 дах заалтыг хэлэлцэхээс эхэлж болно. Уг заалтад төлбөр тооцоог цаг тухайд нь найдвартай гүйцэтгэж, заавал байлгах нөөцийн шаардлагыг бүрэн хангасан байх зэрэг төлбөр тооцооны төлөөлөгч АСН-д шууд холбогдохын тулд тавигдах тодорхой шаардлагуудыг тогтоосон байдаг. Дээрх уулзалтын үр дүнд банк бус төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч (Автомат клиринг хаус системийн дүрмийн журмын 5.1.8, 5.1.9-д заасан оролцогчид)-д зориулсан дээрх шаардлагуудтай төсөөтэй боловч илүү оновчтой тодорхойлсон шаардлагуудыг боловсруулах эсэхийг үнэлэх хэрэгтэй. Хамгийн чухал нь банк бус төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдэд тогтоох шаардлагуудыг дахин тохируулах нь тэдэнд давуу тал олгож байна гэсэн үг биш бөгөөд төвлөрсөн төлбөрийн системд шууд холбогдох тэгш боломжоор хангах зорилготой юм. Монгол улс Хүснэгт 10-т үзүүлсэнчлэн Канад улсын шууд оролцооны шаардлагуудыг харгалзан үзэх боломжтой.

¹² 5.1.8-д Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 10.1-д заасан үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрөл бүхий этгээдийг, 5.1.9-д өөрийн төлбөрийг илгээх, хүлээн авах зорилго бүхий хуулийн этгээдийг хэлнэ.

¹³ Автомат клирингийн төвийн системийн дүрмийн 5.4-т АСН-д оролцогчид улсын төлбөрийн төвлөрсөн дэд бүтцэд шууд оролцоход тавигдах шаардлагуудын жагсаалтыг нарийвчлан тусгасан болно. Үүнд Банксүлжээ системээр дамжуулан хийх төлбөрийн тооцоонд тавигдах шаардлага, Автомат клирингийн төвийн системийн дүрмийн 3 дугаар хавсралтын дагуу АСН системд илгээсэн гүйлгээний ангилал, сувагчлалыг үнэн зөв хийх, үйл ажиллагааны бусад үзүүлэлтүүд багтана.

Хүснэгт 10: Арга хэмжээ 3.2-т хамаарах сайн туршлагууд

Байршил	Тайлбар	Монгол улсад хэрэгжүүлж болох гол шийдлүүд
Сингапур	<p>Сингапур улсын шууд холболтын загвар</p> <p>Сингапур улсын Төлбөрийн үйлчилгээний хуулийн дагуу сонгогдсон төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид нь Сингапурын Мөнгөний удирдах газар (MAS)-ын Цахим төлбөрийн систем (MEPs)-ийн RTGS системд шууд холбогдох боломжтой байдаг. Энэхүү загвараар төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид нь төв банк эсхүл зохицуулах байгууллагаас тогтоосон үйл ажиллагааны, техникийн болон аюулгүй байдлын хатуу шаардлагуудыг хангах шаардлагатай. Хангасан тохиолдолд төвлөрсөн төлбөрийн дэд бүтцэд шууд холбогдох боломжтой ба зуучлагч банкуудаар дамжих шаардлагагүй.</p>	<p>Монгол улс зохицуулалтын нарийн шаардлагуудыг хангаж байгаа төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдийг шууд холбогдох боломжийг харгалзан үзэх боломжтой. Энэ хандлага нь төлбөр тооцоог оновчтой болгож, төлбөрийн үйлчилгээний зардлыг бууруулснаар өрсөлдөөнийг нэмэгдүүлэх боломжтой.</p>
Канад	<p>Канад - Төлбөрийн системээр дамжуулан холбогдох¹⁴</p> <p>Канадын Payments Canada компанийн удирддаг автомат клиринг хауст холбогдох загвар нь банк бус төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдэд оролцох хоёр өөр хэлбэрийг санал болгодог. Нэг талаас, банк бус төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь Payments Canada-аас тогтоосон зээл, эрсдэл, төлбөр тооцооны хатуу шаардлагуудыг хангаснаар шууд гишүүнчлэлийн хүсэлт гаргаж болно.¹⁵ Энэхүү шууд холболт нь төлбөрийн үйл ажиллагаанд хяналтыг сайжруулж, гүйлгээний зардлыг бууруулна. Нөгөө талаас бүрэн гишүүнчлэлийн шалгуурыг хангаагүй эсвэл нөөц бага зарцуулах хандлагыг илүүд үзэж буй банк бус төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид спонсор банкууд эсвэл зөвшөөрөгдсөн гуравдагч этгээдийн хандалтын үйлчилгээ үзүүлэгчтэй хамтран шууд бусаар оролцох боломжтой.</p> <p>Санхүүгийн болон кибер аюулгүй байдлын хатуу шаардлагуудын жишээнд өргөдөл гаргагчийн зээлжих зэрэглэлийг ерөнхийдөө хөрөнгө оруулалтын зэрэглэлтэй (BBB ба түүнээс дээш) дүйцүүлэх, ACSS болон Lynx¹⁶</p>	<p>АСН системд оролцох хэд хэдэн аргыг бий болгох нь сүлжээний аюулгүй байдал, бүрэн бүтэн байдлыг хангахын зэрэгцээ зах зээлийн инновацийг дэмжих банк бус төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдийн оролцоог өргөжүүлдэг.</p>

¹⁴ Payments Canada. Эндээс үзнэ үү: <https://www.payments.ca/>

¹⁵ Канадын банк. Канадын Банкны төлбөр тооцооны болон дансны бодлого, Эндээс үзнэ үү: <https://www.bankofcanada.ca/core-functions/financial-system/bank-canadas-settlement-account-policies-for-payments-canada-payment-systems/>

¹⁶ Lynx бол Канадын орчин үеийн өндөр дүнтэй төлбөрийн систем бөгөөд хуучин LVTS-ийг орлож, их дүнтэй гүйлгээг бодит цаг хугацаанд хийх боломжийг олгодог. Автомат клирингийн систем (ACSS) нь Канад улсын жижиглэнгийн

	<p>төлбөр тооцооны данс эзэмшигчдээс өндөр хүртээмжтэй банкны систем (HABS) нэртэй банкаар боловсруулсан аюулгүй программаар дамжуулан дансны үйлчилгээнд хандахыг шаардах зэрэг багтана.^{17, 18}</p> <p>Энэхүү шууд бус холболт нь байгуулагдсан банкуудын одоо байгаа нийцлийн тогтолцоо, техникийн дэд бүтцийг хөшүүрэг болгож, интеграцийн үйл явцыг хялбаршуулдаг. Ерөнхийдөө Канадын арга нь шууд болон шууд бус оролцооны горимыг санал болгосноор банк бус төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдэд зориулсан клирингийн системийн хүртээмжийг нэмэгдүүлж, улмаар инновацийг дэмжиж, зах зээлийн оролцоог өргөжүүлдэг.</p>	
--	--	--

5.2.3 Арга хэмжээ 3.3: Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай (ББСҮА) хуулийн төслийн шинэчлэлтийг хянан үзэх

Хүснэгт 11: Арга хэмжээ 3.3-ын хураангуй

Зорилт	<p>Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай (ББСҮА) хуулийн төслийг хянан үзэж, одоогоор банк бус санхүүгийн үйл ажиллагааны жагсаалтад багтаагүй санхүүгийн үйлчилгээ, үйл ажиллагааг явуулахад Санхүүгийн зохицуулах хорооноос зөрчилгүй тухай албан бичиг (NOL) гаргах эрхийг олгохоор өөрчлөх.¹⁹</p>
Тайлбар	<p>Одоогийн Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулиар Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулах 11 тодорхой төрлийн үйл ажиллагааг хуульчилсан ба зарим Финтек компаниуд дээрх зохицуулалтын хүрээнд хамаарахгүй бусад төрлийн үйл ажиллагаа (ж.нь, Одоо аваад дараа төл (BNPL) үйлчилгээ, мөнгөний зах зээлийн арилжаа) эрхэлж байна.</p> <p>УИХ-д өргөн барьсан ББСҮА тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөр өргөн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй ББСБ-уудыг зохицуулах илүү уян хатан боломжийг Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-д олгосон. Тухайлбал, шинэчилсэн хуулийн төслийн 6.3.7-д хуульд банк бус санхүүгийн үйл ажиллагаа гэж тодорхойлсонд хамаарахгүй тодорхой төрлийн үйл ажиллагааг банк бус санхүүгийн нэмэлт үйл ажиллагаа гэж үзэн зохицуулах боломжийг СЗХ-нд олгожээ. Гэсэн хэдий ч 6.7 дугаар зүйлийн дагуу нэмэлт үйл ажиллагаа эрхлэх компани эхлээд ББСБ-ын үйл</p>

худалдааны үндсэн систем болох бага дүнтэй, өндөр дүнтэй гүйлгээг хойшлуулсан цэвэр үндсэн дээр тооцоолж, барагдуулдаг АСН-ийн Канад дахь дүйцэхүйц систем юм.

¹⁷ Өндөр хүртээмжтэй банкны систем (HABS) нь Канадын банкуудын банкны чухал үйлчилгээнд тасралтгүй нэвтрэх, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах зорилгоор ашигладаг найдвартай платформыг хэлнэ.

¹⁸ Канадын банк. Канадын Банкны Lynx-ийн төлбөр тооцооны дансанд нэвтрэх бодлого болон автоматжуулсан төлбөр тооцооны систем. Эндээс үзнэ үү: <https://www.bankofcanada.ca/core-functions/financial-system/bank-canadas-settlement-account-policies-for-payments-canada-payment-systems/bank-canada-settlement-account-access-policy-lynx-automated-clearing-settlement-system/>

¹⁹ Зөрчилгүй тухай бичиг (NOL) нь одоогийн зохицуулалтын дагуу тусгай зөвшөөрөл шаарддаггүй тодорхой үйл ажиллагаа эрхэлдэг компани эсвэл хувь хүмүүст ямар нэгэн эсэргүүцэл байхгүй гэсэн зохицуулагч байгууллагаас гаргасан албан ёсны баримт бичиг юм. Финтекийн салбарт одоо байгаа тусгай зөвшөөрлийн ангилалд хамаарахгүй шинэлэг санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг компанид NOL олгож, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн нэгдмэл байдлын үндсэн шаардлагуудыг дагаж мөрдөхийн зэрэгцээ зохицуулагч байгууллагын зөвшөөрсөн хүрээнд үйл ажиллагаа явуулах боломжийг олгодог.

	<p>ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байхыг шаардаж байгаа нь шинэчилсэн хуулийн төсөл нь хязгаарлагдмал хэвээр байна. Өөрөөр хэлбэл, энэ нь одоогийн ББСБ-д бүхэлдээ хамаарахгүй инновацлаг бизнес загвар бүхий шинэ Финтек компаниудыг зах зээлд нэвтрэхэд саад болж болзошгүй.</p> <p>СЗХ-нд шинээр гарч ирж буй Финтек технологи, бизнесийн загваруудад хяналт тавих уян хатан байдлыг хангах үүднээс хэрэв үйл ажиллагаа нь хуулиар тодорхойлсон банк бус санхүүгийн үйл ажиллагааны ангилалд хамаарахгүй бол СЗХ-оос NOL олгох, тогтмол хяналт шалгалт хийх, харин Банк бус санхүүгийн байгууллагын газар эсвэл холбогдох хэлтэс нь тусгай зөвшөөрөл олгох шаардлагатай эсэхийг тодорхойлохыг санал гаргаж байна.</p>
Хэрэгжилтийг хангах субъект	СЗХ
Оролцогч талууд	МФАХ
Алхмууд	<p>Хэрэгжүүлэх алхмуудыг дараах байдлаар тодорхойлов.</p> <ol style="list-style-type: none"> Тусгай зөвшөөрөлтэй эрхлэх ББСҮА-ны 11 төрөлд үл хамаарах санхүүгийн үйлчилгээ эрхлэхэд СЗХ-оос NOL гаргах боломжийг олгох үүднээс ББСҮА тухай хуулийн төслийн 6.7 дах заалтад нэмэлт өөрчлөлт оруулах. Зохицуулалтыг инновацтай зэрэгцүүлэх нь хүндрэлтэй байдаг тул NOL нь бизнес эрхлэгчдэд санхүүгийн шинэ үйлчилгээг турших уян хатан нөхцөлөөр хангахын зэрэгцээ зохицуулагчдад хяналтаа хадгалах завсрын ашигтай хэрэгсэл байх боломжтой. Тодруулбал, ББСҮА тухай хуулийн төслийн 6.7-д Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд нь СЗХ-оос NOL олгосноос бусад тохиолдолд нэмэлт үйл ажиллагааг дангаар эрхлэхгүй гэж өөрчлөх. NOL олгохтой холбоотой заалт, журам боловсруулах. NOL олгох шийдвэр гаргах үйл ажиллагааг зохицуулсан удирдамж/журмыг СЗХ боловсруулах шаардлагатай. Журамд санхүүгийн үйлчилгээ нь одоогийн зохицуулалтын хүрээнд хамаарахгүй болохыг баталгаажуулах, тухайн бизнес нь нарийн тодорхойлсон үйл ажиллагааны хамгаалалтын хүрээнд хэрэглэгчийн болон системийн эрсдэлийг хянах боломжтойг үнэлэх зэрэг үйл ажиллагааг багтаана. NOL-н дагуу үйл ажиллагаа явуулж буй компаниудын үйл ажиллагаа, засаглалыг чиглүүлэх заалтуудыг мөн боловсруулах шаардлагатай. Жишээлбэл, NOL олгогдсон бизнесүүдийн зах зээлд учруулж болзошгүй эрсдэлийг тогтмол хугацаанд үнэлэх, хангалттай хөрвөх чадварыг хангах зэрэг заалтуудыг тусган, тухайн бизнес нь санхүүгийн үүргээ биелүүлэх чадвартай, хэрэглэгчдийн хөрөнгө хамгаалагдсан байх нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байж болно. NOL боловсруулахын тулд Хүснэгт 12-г заасан Кени улсын загвараас эх сурвалж авах боломжтой. Тодорхой бөгөөд давхардалгүй зохицуулалтын чиг үүргийг хангахын тулд төрийн байгууллага, агентлагууд хооронд шилжүүлэх, чиглүүлэх процессыг бий болгох. ББСҮА тухай хуулийн төслийн 6.3.7-д дээрх нэмэлт өөрчлөлтийг оруулснаар

одоогийн 11 төрлийн ББСҮА-ны жагсаалтад багтаагүй үйл ажиллагааг ББСБ-ын нэмэлт үйл ажиллагаа болгон зохицуулах боломжийг СЗХ-нд олгож байгаа тул СЗХ-нд хяналтын давхардал үүсэх эрсдэлтэй. Жишээ нь, одоогоор ямар нэгэн зөвшөөрөл, тусгай зөвшөөрлөөр зохицуулагдаагүй байгаа мөнгөний захын үйл ажиллагаа энэ тодорхойлолтын дагуу ББСБ-ын нэмэлт үйл ажиллагаа гэж ангилагдах ба ББСБГазрын эрхлэх асуудлын хүрээнд багтах боломжтой. Гэхдээ, мөнгөний захын платформуудад өрийн бичиг зэрэг үнэт цаасыг хамардаг тул үнэт цаастай холбоотой нарийн төвөгтэй эрсдлийг удирдах чиглэлээр мэргэшсэн Үнэт цаасны газар илүү оновчтой зохицуулалт хийх боломжтой. Хяналтын давхардал, зохицуулалтын стандартын зөрүү, нөөцийг үр ашиггүй ашиглах байдал болон зохицуулалтын боломжит цоорхой зэргээс сэргийлэхийн тулд СЗХ нь тухайн бизнесийг зохих газар эсвэл зохицуулагч байгууллага руу шилжүүлэх, чиглүүлэх замаар зохицуулалтын тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай. Үүнийг илүү тодорхой, үйл ажиллагааны үр ашигтай байдлыг хангах зорилгоор бүтэцжсэн чиглүүлгийн протокол (referral protocol)-ыг албан ёсоор хэрэглэж, нэвтрүүлснээр хэрэгжүүлэх боломжтой. Монгол Улс Энэтхэгийн Төв Банкны нэвтрүүлсэн загвараас зарим жишгийг авч, шилжүүлгийн үйл явцыг боловсруулахаар ашиглаж болно (12-р хүснэгт). Энэ нь мөн **Хавсралт А-ийн А бокст** байрлах жишиг Үйл ажиллагааг тодорхойлох баримт бичиг (TOR) баримт бичигт тусгагдсан МФАХ-ийн гүйцэтгэх үндсэн чиг үүргүүдийн нэг хэсэг болох юм.

4. **NOL-н хугацаа дуусахад бизнесээ үргэлжлүүлэх үйл явцыг зохицуулсан журам боловсруулах.** NOL нь шилжилтийн шинж чанартай бөгөөд бизнесийг зохих тусгай зөвшөөрлийн нөхцөл рүү шилжүүлэх тухайлсан хугацаа (жишээ нь: хоёр жил)-г тодорхойлох нь чухал. Энэ нь шинэ тусгай зөвшөөрөл эсвэл одоо байгаа зохицуулалтын стандарттай нийцэж байж болно. Хэрэв бизнес нь тусгай зөвшөөрлийн шаардлагыг бүрэн хангахгүйгээр зөвшөөрлийн хүрээнээс гадуур үйл ажиллагаа явуулсаар байвал СЗХ NOL-г бичгийг хүчингүй болгож, бизнесийг үйл ажиллагаа явуулахыг зогсоохыг шаардах боломжтой. Мөн NOL-н хугацааг тодорхой хугацаагаар сунгах боломжтой байж болно. Бизнес эрхлэгчдэд ойлгомжтой байлгах зорилгоор СЗХ нь ашиглахад хялбар болгох үүднээс журамд NOL дуусах үйл явцтай холбоотой мэдээллийг багтаасан байх хэрэгтэй.
5. **Финтекийн хууль тогтоомжуудыг хэрхэн боловсруулах талаар удирдамж гаргах.** Финтекийн хөгжил нь зохицуулалтын хөгжлөөс харьцангуй түрүүнд явж байгааг харгалзан МФАХ нь шинэ бизнесийн загваруудыг зохицуулах боломжийг олгох, уян хатан, технологийн хувьд төвийг сахисан (neutral) хэллэг ашиглан шинэ зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл боловсруулах хэрэгтэй. Энэ нь нэмэлт зохицуулалтын өөрчлөлт шаардлагагүйгээр шинэ хүрээнд орж болох бизнесийн загваруудыг хүлээн авах боломжийг бий болгоно. Энэхүү арга нь Монгол Улсад Финтек зохицуулалтын урт хугацааны тогтвортой байдлыг хангаж, бизнес эрхлэгчид болон хөрөнгө оруулагчдад илүү тодорхой байдлыг бий болгоно. 12-р

хүснэгтэд Сингапур хэрхэн төстэй хуулиудыг боловсруулсан жишээг харуулав.

Хүснэгт 12: Арга хэмжээ 3.3-т хамаарах сайн туршлагаууд

Байршил	Тайлбар	Монгол улсад хэрэгжүүлэх гол шийдлүүд
Кени	<p>NOL ашиглан турших-сурах аргачлал²⁰</p> <p>2007 онд Safaricom компани Кени улсын Төв Банк (СВК)-д M-Pesa гэдэг гар утасны мөнгөн шилжүүлгийн үйлчилгээг эхлүүлэх санал тавьсан. Энэ нь зохицуулалтын асуудал үүсгэсэн бөгөөд уг загвар нь өмнө нь байхгүй байсан тул СВК нь харилцаа холбооны оператороос санхүүгийн үйлчилгээ үзүүлэх нь одоогийн банкны системд хэрхэн нийцэх талаар тодорхойгүй байв.</p> <p>Тухайн үед, Банкны хууль нь банк бус санхүүгийн байгууллагуудаас санал болгож буй төлбөрийн бүтээгдэхүүнийг зохицуулах хууль эрх зүйн үндсийг хангаж өгөөгүй байсан бөгөөд СВК нь банк бус санхүүгийн гүйлгээг хянах тодорхой эрх мэдэлгүй байсан. Гэсэн хэдий ч, энэхүү шинэ үйлчилгээний өргөн хүрээ болон боломжийг харгалзан, СВК нь хуульчдын багийг цуглуулан, Итгэлцлийн дансны шаардлагуудыг боловсруулсан (улмаар энэ нь Итгэлцлийн хуулийн хэлбэрээр хөгжсөн). Мөн, СВК нь M-Pesa-г тодорхой нөхцөлүүдийн дагуу үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрөх тухай NOL гаргасан.</p> <p>Эдгээр нөхцөлүүдэд:</p> <ul style="list-style-type: none"> • Хэрэглэгчдийг залилан, мөнгө алдагдах, хувийн мэдээллийн зөрчил, болон үйлчилгээний чанарын асуудлуудаас хамгаалах системийн бүрэн бүтэн байдлыг хангах. • Мөнгө угаахтай тэмцэхэд шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэх. • Зохицуулагч байгууллагуудад шаардлагатай үед холбогдох баримт бичигт зөвшөөрөл олгож, зохистой бүртгэл хөтлөх. 	<p>Зохицуулалтын тогтолцоо хөгжиж байгаа энэ үед тодорхой хамгаалалт бүхий NOL-ыг олгох замаар зах зээлийн өсөлт ба хэрэглэгчийн эрхийг хамгаалсан инновацлаг Финтек бизнесүүдийг үйл ажиллагаа явуулах боломжийг олгох.</p>

²⁰ Дэлхийн Банкны Групп (2020). Зохицуулах байгууллагуудын Финтект үзүүлж буй хариу арга хэмжээ. Эндээс үзнэ үү: <https://documents1.worldbank.org/curated/en/579101587660589857/pdf/How-Regulators-Respond-To-FinTech-Evaluating-the-Different-Approaches-Sandboxes-and-Beyond.pdf#page=27>

	<ul style="list-style-type: none"> Агентууд болон хэрэгэлгч хоорондын харилцааг зохицуулсан хууль тогтоомжийн нийцлийг хангах. <p>NOL-ыг олгосноор Safaricom компани M-Pesa-г эхлүүлж, эхний 9 сарын дотор 1 сая хэрэглэгчтэй болж, 18 сарын дотор 4 сая хэрэглэгчтэй болсон. Өнөөдөр, Кени улсын ДНБ-ийн 50%-иас илүү нь M-Pesa-аар дамжиж, энэ нь дэлхий даяар хамгийн амжилттай гар утасны мөнгөний платформуудын нэг болсон.</p>	
Энэтхэг	<p>Энэтхэгийн чиглүүлгийн буюу дамжуулах механизм</p> <p>Энэтхэгт, Энэтхэгийн Төв Банк (RBI) нь Үнэт цаас ба Арилжааны зөвлөл (SEBI), Даатгалын газар, Хөгжлийн Бага Хороо (IRDAI) зэрэг бусад зохицуулагч байгууллагуудтай ойр хамтран ажилладаг. Энэтхэгийн тогтолцоо нь олон санхүүгийн салбарыг хамарсан үйл ажиллагааг тодорхойлох боломжийг бүрдүүлэх шилжүүлгийн механизмуудыг агуулсан байдлаар хөгжсөн. Жишээлбэл, уламжлалт бус зээл олголт эсвэл финтек инновациуд гарч ирэх үед, RBI болон SEBI зохицуулалт хийж, нэг байгууллага нь тусгай хяналтыг хэрэгжүүлэхийн тулд асуудлыг нөгөө рүү шилжүүлсэн. Энэ олон агентлагын хамтын ажиллагаа нь шинэлэг санхүүгийн үйлчилгээг зохицуулалтгүй үлдээхгүй байхын зэрэгцээ хэрэглэгчийн ашиг сонирхлыг хамгаалахад тусалдаг.</p>	<p>Монгол Улс нь олон зохицуулагч байгууллагын онцлог мэргэжлийг ашиглан бүтэцжсэн олон хэлтэс болон агентлагийн шилжүүлгийн механизмыг нэвтрүүлэх боломжтой бөгөөд ингэснээр шинэ санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг инновацыг боогдуулахгүйгээр зохистой хяналтад оруулах боломжийг олгоно.</p>
Сингапур	<p>Сингапурын Үнэт цаас ба Фьючерсийн тухай хууль (SFA) болон Төлбөрийн үйлчилгээний тухай хууль (PSA)</p> <p><u>Үнэт цаас ба Фьючерсийн тухай хууль</u>²¹</p> <p>SFA нь "санхүүгийн хэрэглүүр" болон холбогдох нэр томъёоны өргөн тодорхойлолтыг мөн адил ашигладаг бөгөөд энэ нь шинээр гарч ирж буй хэрэгслүүдийг (жишээ нь, тодорхой токенжуулсан хөрөнгө) уламжлалт ангилалд тохирохгүй байсан ч хянаж, зохицуулалтын хяналтад оруулах боломжтой гэсэн үг юм. Тодруулбал, хуульд "Санхүүгийн хэрэгсэл" гэдэгт хэлбэр, бүтцээс үл хамааран санхүүгийн зах зээлд оролцоход дэмжлэг үзүүлэх аливаа гэрээ, зохицуулалтыг оруулна" гэж тодорхойлсон. Энэ тодорхойлолт нь Мөнгөний зохицуулах газарт хууль тогтоомжийн шинэчлэлийг хүлээхгүйгээр</p>	<p>Монгол Улсын Зөвшөөрлийн тухай хуульд инновацлаг бизнесийг шууд зөвшөөрөл, тусгай зөвшөөрлийн шаардлагад хамруулах, хууль тогтоомжийг үе үе шинэчлэхгүйгээр зохицуулалтын хяналтыг дэмжих үүднээс илүү уян хатан хэллэг ашиглах хэрэгтэй.</p>

²¹ Сингапурын хууль тогтоомжууд, Үнэт цаас, фьючерсийн тухай хууль 2001, Эндээс үзнэ үү: <https://sso.agc.gov.sg/Act/SFA2001>

	<p>өөрийн зохицуулалтын хүрээнд финтекийн шинэчлэлийг нэвтрүүлэх боломжийг олгосон.</p> <p>SFA нь финтек компаниудад хяналттай нөхцөлд шинэлэг бүтээгдэхүүнийг турших боломжийг олгодог механизмуудыг (заавар зөвлөмж, сэндбоксын зохицуулалтын заалт зэрэг хэлбэртэй) багтаасан байдаг. Энэхүү сэндбокс орчин нь зохицуулалтын шаардлагыг хэрэгцээтэй үед нь тохируулан өөрчлөх хууль зүйн бүрэн эрхийн үндсэн дээр хэрэгждэг.</p> <p><u>Сингапурын Төлбөрийн үйлчилгээний тухай хууль</u>²²</p> <p>Төлбөрийн үйлчилгээний тухай хууль нь бүх нөхцөлийг оролцуулсан байхаар өргөн хүрээний, технологийн хувьд төвийг сахисан тодорхойлолтуудыг ашигладаг. Жишээлбэл, хуулийн нэр томъёоны тодорхойлолт хэсэгт (ихэвчлэн эхний хэсгүүдэд буюу 2-р бүлэг) “төлбөрийн үйлчилгээ” гэдгийг өргөн хүрээнд, технологийн хувьд төвийг сахисан байдлаар тодорхойлсон.</p> <p>Жишээ нь ““Төлбөрийн үйлчилгээ” гэдэгт хэрэглэж буй технологиос үл хамаарч төлбөрийн гүйлгээг гүйцэтгэх, клиринг, үр дүнгийн төлбөр тооцоо гүйцэтгэх зэрэг бүхий л үйлчилгээг ойлгоно” гэж тодорхойлсон. Ийнхүү тодорхойлсноор хэрэв шинэ төрлийн финтек загвар (блокчэйнд суурилсан мөнгөн гуйвуулгын үйлчилгээ гэх мэт) гарч ирэх тохиолдолд хуульд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагагүйгээр зохицуулалтанд хамруулах боломжтой.</p>	
--	--	--

5.2.4 Арга хэмжээ 3.4: Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч компаниудад тусгай зөвшөөрлийн шаталсан тогтолцоог хэрэгжүүлэх

Хүснэгт 13: Арга хэмжээ 3.4-ийн хураангуй

Зорилт	Өрсөлдөөн ба инновацийг дэмжих, жижиг инновацлаг компаниуд зах зээлд нэвтрэх саадыг багасгах зорилгоор Монгол улс төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдэд зориулсан тусгай зөвшөөрлийн шаталсан тогтолцоог нэвтрүүлэх. Энэ хандлага нь төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч компаниудад тавигдах зохицуулалтын шаардлагыг тэдний зах зээлийн хэмжээ болон санхүүгийн салбарт учруулж болзошгүй эрсдэлтэй нь уялдуулан тогтоох боломжийг олгодог.
Тайлбар	Монголын төлбөрийн үйлчилгээг хөгжүүлэх, шинэчлэх нь санхүүгийн салбарт нэн тэргүүний зорилт хэвээр байна. ²³ Гэхдээ оролцогч талууд

²² Сингапурын хууль тогтоомжууд, Төлбөрийн үйлчилгээний тухай хууль 2019, Эндээс үзнэ үү: <https://sso.agc.gov.sg/Act/PSA2019>

²³ АХБ Гүйцэтгэлийн тайлан (2024). Монгол улсын Төлбөрийн системийн шинэчлэлийн төсөл, Эндээс үзнэ үү: <https://www.adb.org/sites/default/files/project-documents/46312/46312-001-pcr-en.pdf#page10>

	<p>одоогийн зохицуулалтын шаардлагууд нь жижиг компаниудын хувьд хэтэрхий хатуудсан, эрсдэлийн янз бүрийн түвшинг харгалзан үзээгүй гэдгийг илэрхийлсэн. Хэт хатуу зохицуулалтын шаардлага нь бодит эрсдэлтэй пропорциональ биш байх тохиолдолд инновацид саад учруулж болзошгүй.</p> <p>Үүнийг шийдвэрлэхийн тулд Монгол улс жижиг компаниуд зах зээлд нэвтрэхэд тулгарч буй зохицуулалтын саад бэрхшээлийг бууруулах зорилгоор төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдэд урт болон дунд хугацааны тусгай зөвшөөрлийн шаталсан тогтолцоог хэрэгжүүлэх тал дээр ажиллах боломжтой.</p>
Хэрэгжилтийг хангах субъект	Монголбанк
Оролцогч талууд	Монополийн эсрэг газар болон салбарын оролцогчид
Алхмууд	<p>Хэрэгжүүлэх алхмуудын дараах байдлаар тодорхойлов.</p> <ol style="list-style-type: none"> Зах зээлийн төлөвшлийг тодорхойлох үзүүлэлтүүдийг хянаж, тусгай зөвшөөрлийн шаталсан тогтолцоог хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох. Монгол улсын одоогийн Финтек төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдийн жижиг зах зээлийг харгалзан Монголбанк гүйлгээний хэмжээ, өсөлтийн чиг хандлага болон зах зээлийн бүтэц зэрэг гол үзүүлэлтүүдийг хянан үзэж, зах зээлийн төлөвшлийг дүгнэх, тусгай зөвшөөрлийн шаталсан тогтолцооны хэрэгцээ, шаардлагыг үе шаттайгаар үнэлэх боломжтой. Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдэд зориулсан тусгай зөвшөөрлийн шаталсан тогтолцоог боловсруулах төслийн багийг бүрдүүлэх. Үүнийг боловсруулахдаа Монголбанк нь төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдийг зах зээлийн хэмжээ, эрсдэлд үндэслэн тэдгээрийн үүрэг, хяналтыг ялгасан хоёр шат бүхий зохицуулалтын загварыг хянаж үзэх боломжтой. Жишээлбэл, шатлалуудыг боломжит эрсдэлүүд болон гүйлгээний хэмжээгээр нь тодорхойлж болох бөгөөд тодорхой босгоос хэтэрсэн төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдэд илүү хатуу зохицуулалтын шаардлага ногдуулах боломжтой. Хүснэгт 14-т үзүүлсэн Сингапурын Төлбөрийн үйлчилгээний биллд тусгасан хосолмол-хяналтын тогтолцоо үүнтэй төстэй ойлголт юм.

Хүснэгт 14: Арга хэмжээ 3.4-г хамаарах сайн туршлагууд

Байршил	Тайлбар	Монгол улсад хэрэгжүүлж болох гол шийдлүүд
Сингапур	<p>Сингапурын Төлбөрийн үйлчилгээний билл²⁴</p> <p>Сингапур улсын Төлбөрийн үйлчилгээний биллээр төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдийг гүйлгээний хэмжээ болон эрсдэлээс нь хамааран хосолмол-хяналтын зохицуулалтын</p>	<p>Монгол улс бага эрсдэл бүхий болон өндөр эрсдэл бүхий төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдийг ялгаж зааглах эрсдэлд суурилсан, тусгай зөвшөөрлийн шаталсан тогтолцоог нэвтрүүлснээр</p>

²⁴FinTechNewsSG (2019). Сингапурын Төлбөрийн үйлчилгээний шинэ хууль гэж юу вэ?. Эндээс үзнэ үү: <https://fintechnews.sg/26334/mobilepayments/payment-services-act-singapore/>

	<p>тогтолцоог бий болгосон. Сард 3 сая сингапур доллараас бага дүнтэй гүйлгээ хийдэг үйлчилгээ үзүүлэгч нь Стандарт төлбөрийн байгууллага (SPI)-ын тусгай зөвшөөрөлд хамаарах ба энэ босгоос дээш хэмжээний гүйлгээтэй үйлчилгээ үзүүлэгчид нь зохицуулалтын нэмэлт шаардлагыг хангаж Том төлбөрийн байгууллага (MPI)-ын тусгай зөвшөөрөлд хамаардаг. Энэхүү шаталсан арга нь жижиг компаниудад уян хатан зохицуулалтын дор өсөн дэвших боломжийг олгож, харин өндөр эрсдэл бүхий үйл ажиллагааг илүү хатуу хяналтаар зохицуулах боломжийг олгоно.</p> <p>Уг хуулийн уян хатан, эрсдэлд суурилсан загвар нь зохицуулагч байгууллагуудад бизнес бүрийн цар хүрээ, эрсдэлийн хүрээнд нийцүүлэн, инноваци, хэрэглэгчийн эрхийг хамгаалах боломжийг олгодог. Дээр дурдсанчлан, Мөнгөний зохицуулах газар нь бага эрсдэл бүхий компаниудад Стандарт төлбөрийн байгууллагын тусгай зөвшөөрөл олгож, өндөр эрсдэл бүхий үйл ажиллагаанд илүү нэмэгдүүлсэн шаардлага тавьдаг.</p>	<p>жижиг компаниудыг зах зээлд нэвтрэх боломжийг бий болгож, өрсөлдөөн болон инновацийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ өндөр эрсдэл бүхий үйл ажиллагаанд хатуу хяналт, хэрэглэгчийн хамгаалалтын шаардлагыг хангуулах боломжтой.</p>
<p>Хонгконг</p>	<p>Хонгконг улсын Дижитал банкны тухай удирдамж²⁵</p> <p>Ухаалаг Банкны Эрин²⁶ хөдөлгөөнийг дэмжих зорилгоор Хонгконг улс 2017 онд хэд хэдэн санаачилгыг гаргасан. Эдгээр 7 санаачилгын 1 нь “Хонгконг улсад дижитал банкныг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх” юм. Үүнийг финтек инновацийг дэмжих, шинэ төрлийн харилцагчийн туршлагыг санал болгох гол тулгуур гэж үзсэн.</p> <p>Хамгийн чухал нь дижитал/виртуал банкууд нь жижиг, дунд бизнес эрхлэгчдийг (SMEs) хамруулсан жижиглэн зах зээлд чиглэдэг тул санхүүгийн оролцоог дэмждэг байна.²⁷</p> <p>Дижитал банкуудыг танилцуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор, Хонгконгийн Мөнгөний зохицуулалтын газар (HKMA) зах зээлд шинээр орж ирж буй компаниудад тулгарах саад бэрхшээлийг бууруулах, өрсөлдөөн болон инновацийг нэмэгдүүлэх стратеги болгон</p>	<p>Монгол улс бага эрсдэлтэй болон өндөр эрсдэлтэй санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдийг ялгаж зааглан, эрсдэлд суурилсан тусгай зөвшөөрлийн шаталсан тогтолцоог нэвтрүүлэх боломжтой.</p>

²⁵ Банкны журам. Виртуал банкуудын зөвшөөрөл: 16(10) хэсгийн дагуу Мөнгөний зохицуулах газраас гаргасан заавар. https://www.hkma.gov.hk/media/eng/doc/key-information/guidelines-and-circular/guideline/guideline_eng_virtual_bank_20180608.pdf

²⁶ Хонгконгийн Мөнгөний зохицуулах газар, Ухаалаг банк: Эндээс үзнэ үү: <https://www.hkma.gov.hk/eng/key-functions/banking/smart-banking/>

²⁷ Хонгконгийн Мөнгөний зохицуулах газар, Дижитал банк. Эндээс үзнэ үү: <https://www.hkma.gov.hk/eng/key-functions/banking/banking-regulatory-and-supervisory-regime/digital-banks/>

	<p>Дижитал Банкны тухай удирдамжийг танилцуулсан.</p> <p>Энэ нь хамгийн доод шаардлагуудыг (Банкны Журмын 7-р хавсралтад үзүүлсэн) тодорхойлон, дижитал банкууд хатуу бус нөхцөлд үйл ажиллагаагаа төгөлдөршүүлэх боломжийг олгох түр хугацаа олгосноор хэрэгжсэн.</p>	
--	--	--

5.2.5 Арга хэмжээ 3.5: Нээлттэй банкны хөгжлийг удирдамж боловсруулах замаар дэмжих

Хүснэгт 15: Арга хэмжээ 3.5-ын хураангуй

Зорилт	Монголбанк нь нээлттэй банкны хөгжлийг дэмжих удирдамж боловсруулах
Тайлбар	<p>Одоогоор Монгол улсад төрийн болон хувийн хэвшлийн оролцогчид нээлттэй банкны хэрэгцээ шаардлагыг төдийлөн эрэлхийлээгүй боловч илүү хөгжингүй Финтек экосистемрүү шилжиж байгаа энэ үед анхаарал хандуулах талбар болохыг тэмдэглэсэн.</p> <p>Урт хугацаандаа нээлттэй банкны хөгжлийг дэмжих зарим алхмуудыг хийж болно. Монгол Улс нээлттэй банкны үйл ажиллагааг дэмжих дэд бүтцийг хөгжүүлэх, нээлттэй банкны санаачлагуудыг дэмжихдээ бусад улс орны туршлагыг авах боломжтой. Үүнд сайн дураар өгөгдөл хуваалцахад тавигдах шаардлага, харилцан ажиллах чадварыг сайжруулах техникийн тусгай стандартыг дагаж мөрдөх үүргийг тодорхойлсон бодлого, түүнчлэн банкууд болон гуравдагч талын үйлчилгээ үзүүлэгч (TPP) хооронд нээлттэй Хэрэглээний Програмчлалын Интерфейс (API) хөгжүүлэх, ашиглах зааварчилгаа өгөх хүрээ, удирдамжийг боловсруулах зэрэг багтаж болно.</p>
Хэрэгжилтийг хангах субъект	Монголбанк
Алхмууд	<p>Нээлттэй банкны хөгжлийг дэмжихийн тулд дараах алхмуудыг хэрэгжүүлэх боломжтой.</p> <ol style="list-style-type: none"> 1. Урт болон дунд хугацаанд нээлттэй банкны зохицуулалт хийх платформ (ажлын хэсэг гэх мэт) бий болгох. Монгол улсад нээлттэй банкны салбарын өсөлтийг дэмжихийн тулд МФАХ нь зах зээл хангалттай төлөвшсөн гэж үзэх хүртэл засгийн газар болон салбар хооронд чиглүүлэх ажлын хэсэг байгуулах боломжтой. Энэхүү платформ нь Монгол Улсад нээлттэй банкны салбарыг хөгжүүлэхэд чиглэгдсэн удирдамж, тогтолцоог хамтран боловсруулахад тус дөхөм болох бөгөөд МФАХ-ийн хүрээнд тусдаа ажлын хэсэг болж ажиллаж болно. Их Британи улсын Санхүүгийн зохицуулах газар (FCA) болон Төлбөрийн системийн зохицуулах газар (PSR)-ын байгуулсан Стратегийн ажлын хэсэг (SWG)-ийн туршлагад үндэслэн салбарын болон өргөн хүрээний оролцогчдоос санал авч, нээлттэй банкны цаашдын хөгжилд зориулсан алсын хараа

болон стратегийн замын зураглалыг боловсруулсан. (Хүснэгт 16-с дэлгэрэнгүй үзнэ үү)²⁸

2. **Нээлттэй банкны тогтолцоог бий болгож, салбарын удирдамж боловсруулах.** Финтек Замын зураглалд заасан үйл ажиллагаануудыг гүйцэтгэж, илүү ахисан шатанд орсны дараа МФАХ-ийн дэргэдэх нээлттэй банкны ажлын хэсэг нь арилжааны банкууд, финтек компаниуд болон салбарын холбоодтой хамтран ажиллаж, салбарын хөгжлийг удирдах зохицуулалтын тогтолцоог боловсруулж эхлэх боломжтой. Энэхүү тогтолцоо нь харилцаа холбооны протоколууд (жишээ нь, Representation State Transfer (REST)), өгөгдлийн формат (жишээ нь, JavaScript Object Notation (JSON)), болон API-ийн тодорхойлолтуудын дэлгэрэнгүй зааварчилгааг агуулсан, Хонконг болон Сингапурын загварууд гэх мэт сайн туршлагаас санаа аван боловсруулж болно. (Дэлгэрэнгүй мэдээллийг **Хүснэгт 16-с** үзнэ үү). Энэхүү аргачлал нь тогтолцоог практик бөгөөд ирээдүйд чиглэсэн болгох бөгөөд санхүүгийн үйлчилгээний салбарт аюулгүй бөгөөд үр ашигтай өгөгдөл хуваалцах үндсийг тавих болно.

Хүснэгт 16: Арга хэмжээ 3.5-д хамаарах сайн туршлагууд

Байршил	Тайлбар	Монгол улсад хэрэгжүүлж болох гол шийдлүүд
Их Британи	<p>Их Британийн Стратегийн Ажлын Хэсэг (SWG)²⁹</p> <p>Нээлттэй банкны ирээдүйг тодорхойлох зорилгоор, Их Британийн Санхүүгийн Зохицуулах газар (FCA) болон Төлбөрийн Системийн Зохицуулах газар (PSR) хамтран Хамтарсан Зохицуулалтын Хяналтын Хороо буюу Стратегийн Ажлын Хэсэг (SWG)-ийг байгуулсан.</p> <p>Ажлын хэсэг нь салбарын болон оролцогчд талуудын саналыг нэгтгэн, нээлттэй банкны алсын хараа болон стратегийн замын зураглалыг боловсруулсан. Тодруулбал, Стратегийн ажлын хэсэг нь дараах гол зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Оролцогч талуудын санаа бодлыг цуглуулах: Нээлттэй банкны алсын хараа, стратегийн чиглэлийг мэдээлэхийн тулд салбарын түншүүд болон өргөн хүрээний оролцогч талуудын санал бодлыг нэгтгэх. 	<p>Оролцогч талуудад тулгуурласан бүтэцтэй зохицуулалтын тогтолцоо нь нээлттэй банкны инновацийг үр дүнтэй дэмжихийн зэрэгцээ зах зээлийн бүтээмжийг хадгалж үлддэг.</p>

²⁸ Хязгаарлагдмал Нээлттэй Банк. Нээлттэй банкны ирээдүй – Стратегийн Ажлын хэсэг. Эндээс үзнэ үү: <https://www.openbanking.org.uk/swg/>

²⁹ Хязгаарлагдмал Нээлттэй Банк. Нээлттэй банкны ирээдүй – Стратегийн Ажлын хэсэг. Эндээс үзнэ үү: <https://www.openbanking.org.uk/swg/>

	<ul style="list-style-type: none"> ● Шинэ байгууллагыг тодорхойлох: Нээлттэй банкны хэрэгжилтийг хангах залгамжлагч буюу Шинэ байгууллагын урт хугацааны засаглал, санхүүжилтийн боломж, тэргүүлэх чиглэлийн талаар зааварчилга өгөх. ● Үйл ажиллагааны хуваарилалтын талаарх зөвлөгөө өгөх: Шинэ байгууллага ямар үйл ажиллагааг удирдан явуулах болон бусад байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх үүрэг, хариуцлагын талаар санал дэвшүүлэх. ● Нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих: Нарийвчилсан, өгөгдөлд тулгуурласан баримт бичгээр дамжуулан Хорооны нэмэлт хүсэлтийг шийдвэрлэх. <p>Ажлын хэсгийн бүтэцжсэн оролцоо нь олон төрлийн оролцогчдыг нэгтгэн, Их Британийн нээлттэй банкны стратегийн замын зураглалыг боловсруулж, инновацийг хурдасгаж, үр дүнтэй зохицуулалтын хамтын ажиллагааны жишээ болсон.</p>	
Хонгконг	<p>Хонгконгийн нээлттэй банкны удирдамж³⁰</p> <p>Хонгконг нээлттэй банкны үйл ажиллагаанаас гарах боломжуудыг ашиглах, хэрэглэгчдэд зориулсан банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг сайжруулах зорилгоор банкуудыг дэмжих хэд хэдэн санаачилга гаргасан. Жишээлбэл, 2018 онд Хонгконгийн Мөнгөний зохицуулалтын газар (НКМА) нь салбарын оролцогч талуудтай хамтран Хонгконгийн Банкны салбарын Нээлттэй API хүрээ (Open API Framework)-г боловсруулж, нийтэлсэн бөгөөд банкууд болон гуравдагч талын үйлчилгээ үзүүлэгч хоорондын нээлттэй API хөгжүүлэх, ашиглах чиглэлээр зааварчилгаа өгөх зорилготой байв.</p> <p>Энэхүү Нээлттэй API хүрээ нь салбарын сайн туршлагатай нийцүүлэх зорилгоор олон улсын техникийн болон аюулгүй байдлын стандартуудыг санал болгосон. Жишээлбэл, Representational State Transfer (REST)-ийг харилцаа холбооны протокол болгон, Javascript Object Notation (JSON)-ийг өгөгдлийн формат болгон санал болгож байгаа бөгөөд эдгээр нь практик хэрэглээтэй, салбарын өргөнөөр</p>	<p>Харилцаа холбооны протоколууд болон өгөгдлийн форматын талаарх зааварчилгаа, зөвлөмжүүдийг боловсруулж, албан ёсны түвшинд нэвтрүүлэх нь үндэсний нээлттэй банкны салбар илүү уялдаа холбоотой болох чиглэлд өөрийн хурдаар ахиж хөгжихөд дэмжлэг үзүүлдэг.</p>

³⁰ DSG Pay. Хонгконг дахь нээлттэй банкны хүчирхэг өсөлт. Эндээс үзнэ үү: <https://www.dsghongkong.com/blog/open-banking-in-hong-kong/>

	<p>хүлээн зөвшөөрөгдсөн стандартууд юм (Хавсралт В, Хонгконгийн Нээлттэй API хүрээ).³¹</p> <p>Нээлттэй API Хүрээний 28-р заалт нь банкууд өөрсдийн өгөгдлийн тодорхойлолтуудыг гаргах шийдэлтэй байж болох ч, тэд эдгээр тодорхойлолтуудыг (ихэвчлэн "өгөгдлийн толь бичиг" гэж нэрлэдэг) салбарын нийтлэг хэрэглэгддэг туршлагын дагуу, жишээлбэл, OpenAPI тодорхойлолттой нийцүүлэн нийтлэх үүрэгтэй гэж заажээ. Энэ нь банк бус гуравдагч талын үйлчилгээ үзүүлэгчдийн төлбөрийн системд оролцох боломжийг дэмжиж, тэдний банкны Нээлттэй API тодорхойлолтуудад нийцсэн аппликейшнүүдийг хөгжүүлэхэд тусалдаг.</p>	
--	--	--

³¹ Хонгконгийн Мөнгөний зохицуулалтын газар (2018). Хонгконгийн Банкны салбар дах Нээлттэй банкны хүрээ. Эндээс үзнэ үү: <https://www.hkma.gov.hk/media/eng/doc/key-information/press-release/2018/20180718e5a2.pdf>

6. Хэрэглэгчийн эрхийн хамгаалалтыг бэхжүүлэх

Санхүүгийн хэрэглэгчийн эрхийн хамгаалалтыг бэхжүүлэх нь финтек инновацийн экосистемийн тогтвортой хөгжлийг дэмжихэд чухал ач холбогдолтой. ББСБ-ын тоо огцом нэмэгдэж, зах зээлд шинээр нэвтэрч буй өргөн хүрээний бизнес загварууд, зээлийн хүртээмж огцом нэмэгдсэн нь шинэ төрлийн эрсдэлүүдийг бий болгож байна. Ялангуяа, СЗХ болон Монгол банкны оролцогч талууд финтект суурилсан ББСБ-аас олгож буй зээлийн хүртээмж хэт хялбар болсноос үүдэн хэрэглэгчийн өрийн хэмжээ нэмэгдэж буй асуудал, мөн цахим залилан, луйварын тоо өсч буйд санаа зовниж байгаагаа илэрхийлжээ.

6.1 Одоогийн нөхцөл байдал болон тулгамдаж буй асуудлууд

Санхүүгийн хэрэглэгчийн эрхийн хамгаалалтыг бэхжүүлэх нь финтек инновацийн экосистемийн тогтвортой хөгжлийг дэмжихэд чухал ач холбогдолтой. ББСБ-ын тоо огцом нэмэгдэж, зах зээлд шинээр нэвтэрч буй өргөн хүрээний бизнес загварууд, зээлийн хүртээмж огцом нэмэгдсэн нь шинэ төрлийн эрсдэлүүдийг бий болгож байна. Ялангуяа, СЗХ болон Монгол банкны оролцогч талууд финтект суурилсан ББСБ-аас олгож буй зээлийн хүртээмж хэт хялбар болсноос үүдэн хэрэглэгчийн өрийн хэмжээ нэмэгдэж буй асуудал, мөн цахим залилан, луйварын тоо өсч буйд санаа зовниж байгаагаа илэрхийлжээ.³² Тулгамдаж буй гол асуудлуудыг дараах байдлаар тодорхойлов.

- **Хэрэглэгчийн зээлийн хязгаарыг хэрэгжүүлэхэд техникийн болон зохицуулалтын чадамж хязгаарлагдмал байна.** Хэрэглэгчийг зээлийн дарамтаас сэргийлэх зорилгоор өр орлогын харьцаа (DSTI ratio)-г нэвтрүүлсэн боловч уг харьцааг хэрэгжүүлэхэд олон хүндрэл тулгарч байна. Нэгдүгээрт, Монголбанкны Зээлийн мэдээллийн сан (ЗМС)-аас зээлийн мэдээллийг хүлээн авах, цуглуулах үйл явц техникийн хязгаарлалтаас шалтгаалан (жишээлбэл, Монголбанк руу зээлдэгчид мэдээлэл илгээхэд өдөр тутмын мэдээлэл хүлээн авах серверийн багтаамж хязгаарлагдмал) цаг хугацааны хувьд хоцрогдолтой байдаг бөгөөд зээлдүүлэгчид зээлийн мэдээллийг цаг тухайд нь шинэчлэх шаардлагыг хуулиар тогтоогоогүй. Хоёрдугаарт, Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд нь зээлийн мэдээллийг санхүүгийн байгууллагуудад хүргэхдээ Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийн зээлийн мэдээллийг хадгалах, хамгаалах журмын 9.9.9-р зүйлд заасны дагуу 72 цагийн дотор шинэчлэх үүрэгтэй. Гуравдугаарт, Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ) нь банк бус санхүүгийн байгууллага (ББСБ) болон хадгаламж, зээлийн хоршоодын (ХЗХ) хяналтын байгууллага боловч эдгээр санхүүгийн байгууллагуудаас зээлийн мэдээлэл авахыг хууль ёсоор шаардах бүрэн эрхгүй байна. Үүний үр дүнд, зээлдүүлэгч байгууллагуудын баримтлах ёстой DSTI харьцааг тооцоолох үндэслэл болох зээлийн мэдээлэл хоцрогдолтой байж, зээлдэгч нь тухайн харьцааг хэтрүүлэн зээл авах эрсдэлтэй байна.
- **Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах (СХХ) зорилготой, нөхцөл байдалд тохирсон зохицуулалтын тогтолцоо шаардлагатай байна.** Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хэрэглэгчийн эрхийн хамгаалах тогтолцоо (жишээ нь Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль) болон Монголбанк, СЗХ-ны эрх мэдлийн хүрээнд санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах оролдлого байгаа ч финтекийн инновацитай холбоотойгоор гарч буй шинэ эрсдэлүүдэд хариу өгөхөд хангалтгүй, оновчтой биш байна. 2019 онд Азийн Хөгжлийн Банкнаас санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчныг сайжруулах, зохицуулагч байгууллагуудын уялдаа холбоог нэмэгдүүлэх зорилгоор

³² Монгол банк (2022). Санхүүгийн залилан Типологийн тайлан 2022. Эндээс үзнэ үү: <https://fiu.mongolbank.mn/en/r/543>

техникийн туслалцаа үзүүлж, олон улсын сайн туршлагад нийцсэн шинэчилсэн хуулийн төсөл боловсруулагдаж 2022 онд хууль санаачлагчид хүргүүлсэн боловч УИХ-д өргөн баригдаагүй байна.

- **Санхүүгийн байгууллагуудтай холбоотой маргааныг шийдвэрлэх боломж хязгаарлагдмал.**³³ Санхүүгийн хэрэглэгчид маргаантай асуудлыг шийдвэрлэхдээ Монголбанк (банкуудын шийдвэр хүчин төгөлдөр болохын өмнө ирсэн хэрэглэгчийн гомдлыг хүлээн авч, хянан шийдвэрлэдэг), СЗХ (өөрийн хяналтын байгууллагууд болон хэрэглэгчийн хоорондын маргааныг шийдвэрлэх эрхтэй), эсвэл шууд шүүхийн журмаар шийдвэрлүүлэх зэрэг сувгуудаар хандах боломжтой: Гэвч шүүхээр шийдвэрлэх үйл явц цаг хугацаа их шаарддаг, зардал өндөртэй.³⁴ Шүүхэд хандах тохиолдолд маргааны шинж чанараас хамааран захиргааны, эрүүгийн эсвэл иргэний хэргийн шүүхээр эцэслэн шийдвэрлэдэг.
- **Хэрэглэгчдийн санхүүгийн мэдлэг, боловсрол сул байна.** Монгол Улсад санхүүгийн салбар хурдацтай хөгжиж байгаа ч хэрэглэгчдийн, ялангуяа өндөр настнуудын дижитал болон санхүүгийн боловсрол хоцрогдож байна. Монголбанк болон СЗХ-аас богино хугацааны сургалтууд зохион байгуулж байсан боловч хэрэглэгчдийн нэмэгдэж буй өр, зээлийн асуудлыг шийдвэрлэхийн тулд илүү тогтвортой, урт хугацааны арга хэмжээ шаардлагатай байна.

6.2 Замын зураглалд санал болгож буй арга хэмжээ

СЗХ, Монголбанк болон хувийн хэвшлийн салбарын оролцогч талуудын санал хүсэлтийн үндсэн дээр санхүүгийн салбар дахь хэрэглэгчийн эрхийг хамгаалах, мөн хэрэглэгчийн дижитал, санхүүгийн мэдлэгийг сайжруулах зорилгоор дараах дөрвөн арга хэмжээг хэрэгжүүлэхийг санал болгож байна. Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэх дарааллын хувьд:

- Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг батлуулах;
- Зээлийн мэдээлэл тайлагнах хугацааг богиносгох журам боловсруулж хэрэгжүүлэх;
- Санхүүгийн салбарын маргаан шийдвэрлэх омбудсмен үйлчилгээний тогтолцоог бий болгох;
- Өрийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх өрийн клиник байгуулж ажиллуулах.

6.2.1 Арга хэмжээ 4.1: Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг батлуулах

Хүснэгт 17: Арга хэмжээ 4.1-ийн хураангуй

Зорилт	Шинээр үүсч буй санхүүгийн эрсдэлүүдэд үр дүнтэйгээр хариу арга хэмжээ авахын тулд Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай (СХЭХТ) хуулийн төслийг батлуулах нь нэн тэргүүний зорилт байна. Уг хуулийн төслийг 2022 онд боловсруулсан ч УИХ-д өнөөдрийг хүртэл өргөн баригдаагүй байна.
Тайлбар	Азийн хөгжлийн банк (АХБ) нь 2019 онд Монгол Улсад санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчныг үнэлэх, мөн оролцогч талуудын уялдаа холбоог хангасан хэрэглэгчийн эрхийг хамгаалах тогтолцоог дэмжих зорилгоор техникийн туслалцаа үзүүлсэн. Энэхүү техникийн туслалцааны үр дүнд олон улсын сайн туршлагад нийцсэн

³³ АХБ (2019). Монгол улсын Банкны салбар дахь Санхүүгийн хэрэглэгчийн хамгаалалтыг бэхжүүлэх нь. Эндээс үзнэ үү: <https://www.adb.org/publications/protection-consumers-mongolia-banking-sector>

³⁴ Энэхүү дүн шинжилгээг Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6; Зөрчлийн тухай хууль; Зөрчлийн журмын тухай хууль; болон Төв банкны тухай хуульд үндэслэн боловсруулав.

	шинэчилсэн Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл боловсруулагдсан. Уг хуулийн төсөлд Санхүүгийн омбудсмен байгууллагын эрх зүйн статусыг тусгай хуулиар тодорхойлохоор заасан ба мэдээллийн ил тод байдал, хариуцлагатай зээл олголтын зарчмуудыг хангах шаардлагыг тусгаж, шударга бус зээл олголттой тэмцэх, санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий тусгай байгууллага байгуулах зэрэг арга хэмжээг хуульчилсан.
Оролцогч талууд	Монгол улсын Засгийн газар
Алхмууд	Монгол Улсын Засгийн газар Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийг ойрын хугацаанд батлуулахад анхаарах шаардлагатай.

6.2.2 Арга хэмжээ 4.2: Зээлийн мэдээллийн тайлагнах хугацаа богиносгох

Хүснэгт 18: Арга хэмжээ 4.2-ын хураангуй

Зорилт	Зээлийн мэдээлэл тайлагнах хугацааг богиносгох нь зээлдэгч болон санхүүгийн байгууллагуудад аль алинд нь үр ашигтай. Энэ нь зээлдүүлэгч байгууллагууд зээл олгосны дараа Монголбанкны зээлийн мэдээллийн сан шинэчлэгдэх хүртэлх хугацааг багасгаж, мэдээллийн хоцрогдлыг бууруулах боломжтой. Үүний үр дүнд хэт өрийн эрсдэлийг бууруулахын зэрэгцээ зээлдүүлэгчдийн зээлийн хүртээмжийг сайжруулах нөхцөл бүрдэнэ.
Тайлбар	Оролцогч талуудтай хийсэн зөвлөлдөх уулзалтуудаас үзэхэд, Монголбанк зээлийн мэдээллийг бодит цагийн горимоор тайлагнах системд шилжих чиглэлд аль хэдийн ажиллаж эхэлсэн байна. Цаашдын дараагийн алхам нь энэхүү системийг бүрэн хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх бөгөөд үүнд: (i) мэдээлэл дамжуулагч оролцогч талууд бодит цагийн мэдээлэл өгөх чадавхитай байхыг хангах; (ii) мэдээлэл цуглуулах хугацааг богиносгох, тэр дундаа бодит цагийн тайлагнал шаарддаг зохицуулалтыг хууль эрх зүйн хүрээнд бүрдүүлэх зэрэг багтана.
Хэрэгжилтийг хангах субъект	Монголбанкны Зээлийн мэдээллийн алба
Оролцогч талууд	Санхүүгийн Зохицуулах хороо (мөн ББСБ)
Алхмууд	Дараах алхмуудыг хэрэгжүүлэх боломжтой: 1. Оролцогч талуудтай зөвлөлдөх уулзалтууд зохион байгуулах: Зээлийн мэдээлэл тайлагнах хугацааг богиносгох эсвэл бодит цагийн мэдээллийн системд шилжих нь зээлдүүлэгч байгууллагуудын, ялангуяа жижиг хэмжээний үйл ажиллагаа явуулдаг зээлдүүлэгчдийн чадавхид нийцсэн байх шаардлагатай. Иймд Монголбанкны Зээлийн мэдээллийн алба оролцогч талуудтай уулзалт зохион байгуулж, тэдний техникийн болон зохион байгуулалтын дэмжлэг авах хэрэгцээ шаардлагыг үнэлэх хэрэгтэй. 2. Бодит цагийн зээлийн мэдээллийн тайлагналд шилжихэд шаардлагатай техникийн удирдамж гаргах: Монголбанк зээлийн мэдээллийг бодит цагийн горимоор хүлээн авах системд шилжих

шилжилтийг дэмжих зорилгоор зээлдүүлэгчдэд зориулсан техникийн удирдамж гаргах шаардлагатай. Уг удирдамжид мэдээлэл дамжуулах стандарт, API холболтын зааварчилгаа, мэдээллийн аюулгүй байдлын протокол, системийн туршилт зэрэг багтах бөгөөд эдгээр нь зээлдүүлэгч байгууллагууд одоо ашиглаж буй систем, үйл явцыг шинэ системд уялдуулахад тусална.

3. **Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах:** Одоогийн хүчин төгөлдөр Зээлийн мэдээллийн тухай хуульд мэдээлэл нийлүүлэгч нь мэдээлэлд орсон өөрчлөлтийг гурван ажлын өдрийн дотор зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэгчид хүргүүлэхээр заасан.³⁵ Тайлагналын хугацааг богиносгохын тулд уг хуулийг шинэчилж, илүү богино хугацааг тодорхой заах шаардлагатай. Хэрэв Монголбанк дүрэмд суурилсан зохицуулалт нэвтрүүлэхээр шийдвэл хэрэгжилтийг хангахтай холбоотой хяналтын заалтуудыг мөн тусгах нь зүйтэй. Энэ талаар дүрэмд суурилсан хандлага бүхий Сингапурын Мөнгөн зээлдүүлэгчдийн хууль болон зарчимд суурилсан хандлага бүхий Өмнөд Африкийн Үндэсний Зээлийн хууль зэрэг хууль тогтоомжийн жишээг харуулж байна (19-р хүснэгт).
4. **Алхам алхмаар хэрэгжүүлэх шилжилтийн стратегийг дэмжих заавар гаргах:** Банк, банк бус санхүүгийн байгууллага (ББСБ), хадгаламж зээлийн хоршоод (ХЗХ) зэрэг оролцогч талуудад тохирсон шилжилтийн хугацаатай, үе шаттай хэрэгжүүлэх стратегийг боловсруулж болно. Техникийн боломж хязгаарлагдмал байгууллагуудад илүү урт хугацаа олгож, харин техник, системийн бэлэн байдал сайтай байгууллагууд анхдагч хэрэгжүүлэгчийн үүрэг гүйцэтгэн, Монголбанкны Зээлийн мэдээллийн албатай хамтран стратеги боловсруулахад оролцох.
5. **ББСБ-ын үйл ажиллагааны тухай хуульд СЗХ-ны эрх мэдлийг нэмэгдүүлэх өөрчлөлт оруулах:** Урт хугацаанд, Монголын хэрэглэгчдийн дунд ББСБ-ын зээлжүүлэх үүрэг нэмэгдэж буйг харгалзан, зээлийн мэдээлэлтэй холбоотойгоор СЗХ-ны хяналтын эрх мэдлийг нэмэгдүүлэх шаардлагатай. Тухайлбал, ББСҮА-ны тухай хуулийн 3-р бүлэгт нэмэлт заалт оруулж, СЗХ шаардсан тохиолдолд тухайн байгууллага зээлийн мэдээллийг мэдээллийн санд заавал хүргүүлэх үүрэгтэй байхаар тусгах нь зүйтэй.
6. **СЗХ-д хяналтын болон хэрэгжилтийг хангуулах эрх олгох зорилгоор Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах:** Одоогийн Зээлийн мэдээллийн тухай хуулийн 6-р бүлэг, 28-р зүйлд зааснаар, Монголбанк нь банкууд, ББСБ, бусад санхүүгийн байгууллагаас авсан мэдээллийг эзэмших эрхтэй бөгөөд 7-р бүлэг, 29-р зүйлд уг хуулийн зөрчлийн талаар Монголбанкны хяналтын байгууллага хэрэгжилтийг хангуулах эрхтэй байхаар тусгасан. Иймд ХЗХ болон ББСБ зэргийг хяналтдаа байлгадаг СЗХ-д зээлийн

³⁵Зээлийн мэдээллийн тухай хуульд зээлийн мэдээлэл нийлүүлэгч хуулийн этгээдтэй байгуулсан гэрээний дагуу зээлдэгчийн зээлийн болон төлбөрийн үүргийн талаарх мэдээллийг зээлийн мэдээллийн санд нийлүүлдэг тодорхой зээлдэгч, төрийн байгууллагыг “мэдээлэл хангагч” гэж тодорхойлсон байдаг. Эх сурвалж Legalinfo Mongolia (n.d.). Зээлийн мэдээллийн тухай хууль- Албан бус орчуулга. <https://legalinfo.mn/mn/detail/15744>

мэдээллийг шинэчлүүлэх, шаардах, хэрэгжилтийг хангуулах эрхийг олгох тусгай заалтыг хуулийн нэмэлтээр оруулах шаардлагатай. Дэлхийн банкнаас зөвлөсөн олон улсын сайн туршлагаудтай (19-р хүснэгт) уялдуулан, энэ төрлийн хос хяналтын тогтолцоо нь Монголбанк, СЗХ-ийн хооронд илүү тодорхой, уялдаа холбоотой харилцаа, хяналтыг бий болгоно.

Хүснэгт 19: Арга хэмжээ 4.2-т хамаарах сайн туршлагауд

Байршил	Тодорхойлолт	Монгол улсад хэрэгжүүлж болох гол шийдлүүд
Сингапур	<p>Сингапурын Мөнгөн Зээлдүүлэгчийн хууль, 2008³⁶</p> <p>2008 оны “Мөнгөн зээлдүүлэгчдийн хууль”-ын дагуу, тусгай зөвшөөрөлтэй зээлдүүлэгчид нь зээлийн бүртгэлийн мэдээллийн бүрэн бүтэл байдлыг хангах үүднээс зээлийн хүсэлтийг хүлээн авсан өдөрт багтаан, зээл олгохоос өмнө зээлийн дүнгийн талаарх мэдээллийг дамжуулах үүрэгтэй. Хууль хэрэгжилтийн түвшинд, тусгай зөвшөөрөлтэй зээлдүүлэгчид ихэвчлэн зээлийн мэдээллээ Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч (MLCB)-ийн системд бодит цагийн (real-time) буюу “амьд” горимоор шинэчилж, зээлийн эргэн төлөлтийн мэдээллийг дараагийн ажлын өдөрт багтаан шинэчилдэг байна.³⁷</p> <ul style="list-style-type: none"> ● 76 дугаар зүйлийн 2 дахь хэсэг “...томилогдсон зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн мэдээллийн технологийн систем эсхүл мэдээлэл агуулсан аливаа бүртгэлийг дор хаяж өдөрт нэг удаа, эсхүл Сайд өөрөөр заасан тохиолдолд заасан давтамжтайгаар шинэчилж байх үүрэгтэй.” ● 76 дугаар зүйлийн 4 дэх хэсэг: “Хэрэв зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч үндэслэл бүхий шалтгаангүйгээр энэ зүйлийн (1) эсхүл (2) дахь хэсгийг зөрчсөн тохиолдолд, уг үйлчилгээ үзүүлэгч нь зөрчил үйлдсэнд тооцогдох бөгөөд буруутай нь тогтоогдсон нөхцөлд хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ...” 	<p>Дараах заалтуудад тусгай зөвшөөрөлтэй зээлдүүлэгчдийн заавал биелүүлэх үүрэг болон хэрэгжилтийг хангах механизмыг тодорхой тусгасан бөгөөд энэ нь Монголбанк Зээлийн мэдээллийн тухай хуульд өөрчлөлт оруулахдаа дүрэмд суурилсан хандлагыг авч үзэхэд хэрэгтэй жишээ болох боломжтой.</p>
Өмнөд Африк	<p>Өмнөд Африкийн “Үндэсний Зээлийн хууль”³⁸</p> <p>Хуульд зааснаар зээлдүүлэгчид нь “хариуцлагагүй зээл олголт” хийхийг хориглож, хэрэглэгчийн санхүүгийн байдал, төлбөрийн чадварыг урьдчилан үндэслэлтэй үнэлэх арга хэмжээ аваагүй тохиолдолд зээлийн гэрээ байгуулахыг хориглодог.</p>	<p>Өмнөд Африкийн “Үндэсний зээлийн хууль”-д зээлдүүлэгчийн заавал биелүүлэх үүргийг тодорхой заасан байдаг ч эдгээрийг хуулийн</p>

³⁶ Ерөнхий Прокуроруудын Танхим (2008). Мөнгө зээлдүүлэгчийн тухай хууль 2008. Эндээс үзнэ үү: <https://sso.agc.gov.sg/Act/MA2008>

³⁷ MLCB. Ерөнхий. Эндээс үзнэ үү: com.sg/faq.html#:~:text=How%20often%20is%20the%20Loan.updated%20the%20following%20business%20day.

³⁸ Өмнөд Африкын Засгийн газар (2005). Үндэсний Зээлийн тухай хууль 35 of 2005. Эндээс үзнэ үү: <https://www.gov.za/documents/national-credit-act>

Байршил	Тодорхойлолт	Монгол улсад хэрэгжүүлж болох гол шийдлүүд
	<ul style="list-style-type: none"> 80 дугаар зүйл “Зээлийн гэрээг хариуцлагагүй гэж үзэх үндэслэл нь зээлдүүлэгч дараах үнэлгээг хийлгүйгээр зээл олгосон тохиолдолд хамаарна. Үүнд: <ul style="list-style-type: none"> (i) хэрэглэгчийн тухайн зээлийн эрсдэл, зардал болон зээлийн гэрээний хүрээнд хэрэглэгчид хамаарах эрх, үүргийг ерөнхийд нь ойлгох, ухамсарлах чадвар; (ii) өмнөх зээлийн гэрээнүүдийн хүрээнд хэрэглэгчийн өрийн эргэн төлөлтийн түүх; (iii) хэрэглэгчийн одоогийн орлого, санхүүгийн боломж болон үүрэг хариуцлагуудыг үнэлээгүй байх.” 	<p>хүрээнд шууд хэрэгжүүлэх зохицуулалт тусгагдаагүй. Үүний оронд зээлдүүлэгчдэд зориулсан зөвлөмж, сайн туршлагын удирдамжийг гаргадаг. Ийм зарчимд суурилсан хандлага нь зээлдүүлэгчдэд илүү уян хатан байдлыг бий болгодог.</p>
<p>Дэлхийн банк</p>	<p>Үр дүнтэй хяналтын зөвлөмжүүд³⁹</p> <p>Зээлийн мэдээллийн тогтолцоонд үр дүнтэй хяналт хэрэгжүүлэхийн тулд уг тогтолцоо нь төв банк, санхүүгийн зохицуулах байгууллага эсхүл бусад холбогдох эрх бүхий байгууллагын зохих зохицуулалтад хамаарагдах ёстой. Хэрэв тухайн орны зохицуулалтын орчинд нэгээс дээш байгууллага холбогдож буй тохиолдолд, эдгээрээс аль нэг байгууллага нь хяналт тавих гол үүргийг хүлээх шаардлагатай.</p> <p>Түүнчлэн төв банк, санхүүгийн зохицуулах байгууллага болон бусад холбогдох байгууллагууд нь зээлийн мэдээллийн тогтолцоонд үр дүнтэй хяналт хэрэгжүүлэхэд шаардагдах эрх мэдэл, нөөц бололцоогоор бүрэн хангагдсан байх ёстой.</p>	<p>Зээлийн мэдээлэл тайлагналд хяналт тавих үндсэн үүргийг цаашид Монголбанк гүйцэтгэсээр байх нь зүйтэй. Гэсэн хэдий ч Санхүүгийн зохицуулах хороонд (СЗХ) уг чиг үүргийг дэмжих эрх зүйн үндэс, мөн шаардлагатай хүний нөөц, чадавхыг бүрдүүлэх нь чухал ач холбогдолтой.</p>
<p>Өмнөд Солонгос</p>	<p>БНСУ-ын Бодит Цагийн Зээлийн Мэдээллийн Систем⁴⁰</p> <p>БНСУ-ын Санхүүгийн хяналтын алба (FSS) нь зээлдэгчид олон байгууллагаас зэрэг зээл авснаар өрийн үйлчилгээний харьцаа (DSTI)-г хэтрүүлэхээс сэргийлэх зорилгоор бодит цагийн зээлийн хяналтын систем нэвтрүүлсэн. Энэхүү</p>	<p>Санхүүгийн хяналтын алба (FSS) нь санхүүгийн байгууллагууд</p>

³⁹ Дэлхийн банк (2022). Зээлийн тайлангийн үйлчилгээ үзүүлэгчдийн үйл ажиллагааг үр дүнтэй зохицуулах, хяналт тавих үндсэн зарчмууд. Эндээс үзнэ үү: <https://documents1.worldbank.org/curated/en/099915010282240277/pdf/P166475009f6f302e083e503257ba9fcd72.pdf>

⁴⁰ Зээлийн мэдээллийг ашиглах, хамгаалах тухай хууль. Эндээс үзнэ үү: https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=63719&lang=ENG

Байршил	Тодорхойлолт	Монгол улсад хэрэгжүүлж болох гол шийдлүүд
	системийг хэрэгжүүлэх хүрээнд FSS нь санхүүгийн байгууллагуудын дэд бүтцийг шинэчлэхэд дэмжлэг үзүүлж, техникийн нөөц, нарийвчилсан системийн загвар (blueprint), API холболтын заавар зэрэг чухал хэрэгслүүдээр хангасан.	бодит цагийн зээлийн мэдээлэл дамжуулах чадамжаа сайжруулахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор техникийн нөөц, шийдлүүдийг хангаж өгсөн.

6.2.3 Арга хэмжээ 4.3-т Санхүүгийн Омбудсмений үйлчилгээг нэвтрүүлэх

Хүснэгт 20: Арга хэмжээ 4.3-ын хураангуй

Зорилт	Санхүүгийн омбудсменийн тогтолцоог бий болгох нь хэрэглэгчид болон санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад өндөр зардалтай шүүхийн маргаангүйгээр гомдол, зөрчлийг шийдвэрлүүлэх боломжийг олгоно. Хүлээгдэж буй Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөлд санхүүгийн омбудсменийн үйлчилгээний эрх зүйн статусыг тусгай хуулиар зохицуулахаар заасан. Энэхүү тусгай хуульд санхүүгийн омбудсменийн эрх хэмжээ, үүрэг хариуцлага, засаглалын тогтолцоо зэргийг тодорхой тусгаж, тус байгууллагын гүйцэтгэх үүрэг, хариуцлагын хүрээг тодорхой болгох шаардлагатай. ⁴¹
Тайлбар	<p>Санал болгож буй санхүүгийн омбудсменийн тогтолцооны үндсэн үүрэг нь хэрэглэгч болон санхүүгийн байгууллагуудын хооронд үүссэн маргааныг шударга, бие даасан, хөндлөнгийн бөгөөд хямд өртөгөөр шийдвэрлэх механизмыг бий болгоход оршино. Омбудсмен нь эвлэрүүлэн зуучлах болон маргаан хянан шийдвэрлэх аргаар талуудын хооронд үүссэн зөрчилдөөнийг шударгаар, эвээр шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ.</p> <p>Санхүүгийн омбудсменийн байгууллага нь хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн салбарын практик, хууль эрх зүйн чиглэлээр мэдлэг, туршлагатай гишүүдээс бүрдэх ёстой. Тус байгууллага нь санхүүгийн зохицуулагч байгууллагуудаас бие даасан байдлаар үйл ажиллагаа явуулж, хэрэглэгчийн төлөөлөл болон хараат бус захирлуудаас бүрдсэн хараат бус удирдах зөвлөлд тайлагнадаг байх нь зохистой хяналт, тэнцвэртэй зохицуулалтыг хангана.</p>
Хэрэгжилтийг хангах субъект	Монгол Банк

⁴¹ АХБ (2023). Техникийн тусламжийн гүйцэтгэлийн тайлан. Монгол Улс: Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах зохицуулалттай тогтолцоог дэмжих нь. Эндээс үзнэ үү: <https://www.adb.org/sites/default/files/project-documents/53004/53004-001-tcr-en.pdf>

Оролцогч талууд	Санхүүгийн Зохицуулах Хороо, Монополын Эсрэг Газар (МЭГ)
Алхмууд	<p>Дараах алхмуудыг хэрэгжүүлэх боломжтой:</p> <ol style="list-style-type: none"> 1. Санхүүгийн омбудсменийн үйлчилгээний эрх зүйн статусыг тогтоох тусгай хуулийг батлах. Тус хуулийн санхүүгийн омбудсменийн эрх хэмжээ, үүрэг болон албан ёсны шийдвэр гаргалтыг тодорхой тусгах ёстой. Ялангуяа, уг байгууллагад маргаан хянан шийдвэрлэх болон хэрэгжилтийг хангах эрх олгож, түүний гаргасан шийдвэрүүдийг хууль ёсны хүчинтэй, заавал биелэгдэхүйц байхаар хуульчилснаар байгууллагын нэр хүнд, үр нөлөөтэй ажиллагааг хангана. Мөн уг хуулиар санхүүгийн омбудсменийн үйлчилгээ нь санхүүгийн үйлчилгээнд хамаарах маргааныг шийдвэрлэх Монгол Улс дах цор ганц албан ёсны механизм байхаар тодорхойлох шаардлагатай. Армений Санхүүгийн системийн зуучлагчийн тухай хууль (Хүснэгт 21) нь жишиг заалтуудыг агуулж байгаа бөгөөд харгалзан үзэж болно. Мөн Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид болон хэрэглэгчдийн хооронд үүссэн маргаанд хамаарах хяналтын давхардлыг арилгах үүднээс, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, СЗХ-ны уг чиглэл дэх хяналтын чиг үүргийг санхүүгийн омбудсменийн байгууллагад шилжүүлэх шаардлагатай. Тодруулбал, тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6 болон 33 дугаар зүйлийн 33.2 дахь заалтуудыг хүчингүй болгох нь зүйтэй. 2. Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдийн хариуцлага болон хууль зүйн үүргийг зураглалын дагуу нарийвчлан тусгах: Холбогдох хууль тогтоомжид дараах агуулгыг тусгасан заалтуудыг нэмэх шаардлагатай. (i) Бүртгэлтэй бүх санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд санхүүгийн маргаан шийдвэрлэх тогтолцоонд заавал хамрагдах; (ii) Эдгээр байгууллагууд санхүүгийн омбудсменийн хүсэлтийн дагуу хамтран ажиллах үүрэгтэй байх; (iii) Санхүүгийн омбудсменийн зүгээс гаргасан шийдвэр нь хууль ёсны хүчинтэй, заавал биелэгдэхүйц байх. Эдгээр заалттай холбоотойгоор дараах хууль тогтоомжуудад зохих нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай. Үүнд: Банкны тухай хууль, Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, Даатгалын тухай хууль, Хадгаламж, Зээлийн хоршооны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль. 3. Хараат бус санхүүгийн омбудсменийн байгууллагын удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн болон санхүүжилтийн загварыг тодорхойлох: Санхүүжилтийн загвар нь аливаа ганц байгууллагаас хэт хамаарахгүй байх ёстой бөгөөд ашиг сонирхлын зөрчлийг багасгах зарчим баримтлах хэрэгтэй.⁴² СЗХ нь санхүүгийн зах зээлийн тоглогчдоос ажлын ачаалал болон зах зээлд эзлэх байр суурийн харьцаанд үндэслэн санхүүжилт татан төвлөрүүлэх боломжтой. Жишээлбэл, тухайн байгууллагын бодит жилийн гүйлгээний хэмжээний түвшинд хамаарах төлбөрийн систем нэвтрүүлж болно. Үүн дээр нэмэлтээр тохиолдол тус бүр дээр үндэслэсэн төлбөрийг маргаан бүхий санхүүгийн байгууллагаас авах байдлаар санхүүжилтийг нэмэгдүүлж болно. Их Британийн Санхүүгийн омбудсменийн

⁴²АХБ (2019). Монгол улсын Банкны салбар дах Санхүүгийн хэрэглэгчийн хамгаалалтыг бэхжүүлэх нь. Эндээс үзнэ үү: <https://www.adb.org/sites/default/files/publication/545366/eawp-020-protection-consumers-mongolia-banking.pdf>

үйлчилгээ (Table 21) нь ийм холимог санхүүжилтийн загварыг хэрэгжүүлдэг.

Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах байгууллагууд (жишээлбэл, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах агентлаг — АМА) болон санхүүгийн салбарын байгууллагуудын (жишээлбэл, Монголбанк, СЗХ болон санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид) төлөөллөөс тэнцвэртэй байдлаар оролцуулах нь шударга, хөндлөнгийн шийдвэр гаргах нөхцөлийг хангана. Энэ хүрээнд санхүүгийн салбарын тоглогчид эсвэл холбоодын давамгайлал үүсэхээс зайлсхийх шаардлагатай.

Монгол Улс энэ чиглэлээр Сингапурын Санхүүгийн салбарын маргаан шийдвэрлэх төв (FIDReC)-ийн загварыг (Хүснэгт 21-д тусгагдсан) жишиг болгон авч үзэх боломжтой.

Хүснэгт 21: Арга хэмжээ 4.3-т хамаарах сайн туршлага

Байршил	Тодорхойлолт	Монгол улсад хэрэгжүүлж болох гол шийдлүүд
Армени	<p>Санхүүгийн Системийн Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль⁴³</p> <p>2008 оны “Санхүүгийн системийн зуучлагчийн тухай хууль”-аар санхүүгийн системийн зуучлагчид санхүүгийн маргааныг шийдвэрлэхдээ хууль ёсны хүчинтэй, заавал биелэгдэх шийдвэр гаргах эрх олгож, тэдгээр шийдвэрийн хэрэгжилтийг хангах механизмыг мөн тусгасан байдаг. Хуульд тусгагдсан жишээ заалтуудаас дурдвал:</p> <ul style="list-style-type: none"> ● 11 дүгээр зүйл. Нэхэмжлэлийг хянан шалгах: <ul style="list-style-type: none"> ○ (2) Санхүүгийн системийн зуучлагчаас нэхэмжлэлийн хувийг хүлээн авснаас хойш арван дөрвөн ажлын өдрийн дотор байгууллага нь уг нэхэмжлэлтэй холбогдуулан тайлбар, тодруулга, эсэргүүцэл болон зуучлагчаас шаардсан бусад баримт бичиг, мэдээллийг бичгээр хүргүүлэх үүрэгтэй. ○ (5) Талуудын аль нэгээс, эсвэл хамтран гаргасан хүсэлтээр, мөн өөрийн санаачилгаар Санхүүгийн системийн зуучлагч нь тайлбар, тодруулга авах зорилгоор талуудыг дуудаж уулзалт хийх боломжтой. ● 14 дүгээр зүйл. Нэхэмжлэлтэй холбогдуулан гаргасан шийдвэр: <ul style="list-style-type: none"> ○ (2) Санхүүгийн системийн зуучлагч нь нэхэмжлэлийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн 	<p>Санхүүгийн зохицуулах хороо нь санхүүгийн омбудсменийн үйлчилгээний тухай хуулийн төсөлд маргаан хянан шийдвэрлэх болон хэрэгжилтийг хангах эрхийг тодорхой тусгахад Арменийн хууль тогтоомжийг жишиг болгон ашиглах боломжтой.</p>

⁴³ Армены Нэгдсэн Улс (2008). Санхүүгийн системийн зуучлагчийн тухай хууль. Эндээс үзнэ үү: https://www.cba.am/EN/lalaws/Law_on_financial_system_mediator.pdf

Байршил	Тодорхойлолт	Монгол улсад хэрэгжүүлж болох гол шийдлүүд
	<p>хангаж шийдвэрлэсэн тохиолдолд, байгууллага шийдвэрийг хэрхэн, ямар хугацаанд хэрэгжүүлэхийг тодорхой заасан журам, хугацааг тогтооно.</p> <ul style="list-style-type: none"> ● 15 дугаар зүйл. Санхүүгийн системийн зуучлагчийн шийдвэрийг хэрэгжүүлэх: <ul style="list-style-type: none"> ○ (1) Хэрэв хэрэглэгч энэхүү хуульд заасан журмын дагуу зуучлагчийн шийдвэртэй санал нэгдсэн боловч байгууллага уг шийдвэрийг тогтоосон журам болон хугацааны дагуу биелүүлээгүй тохиолдолд, хэрэглэгч холбогдох шүүхэд хандаж, албадан гүйцэтгүүлэх захирамж гаргуулах эрхтэй.. 	
Англи	<p>Их Британийн Санхүүгийн Омбудсменийн Үйлчилгээ (FOS)⁴⁴</p> <p>Их Британийн Санхүүгийн Омбудсменийн Үйлчилгээ (FOS) нь 2000 оны “Санхүүгийн үйлчилгээ ба зах зээлийн хууль”-ын хүрээнд байгуулагдсан бөгөөд засгийн газар, санхүүгийн зохицуулагч байгууллагаас бие даасан байдлаар үйл ажиллагаа явуулдаг.</p> <p>FOS нь Санхүүгийн Зохицуулах Газар (FCA)-аас томилогдсон удирдах зөвлөлөөр удирдуулдаг. Санхүүжилт нь Их Британид FCA-ийн зохицуулалтад хамрагддаг бүх санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудаас авдаг жил бүрийн хураамж, түүнчлэн тухайн байгууллагад гомдол гаргасан тохиолдолд нэмэлт төлбөр (case fee) хэлбэрээр бүрддэг. FOS-ийн шийдвэрүүд нь түүний харьяалалд хамаарах маргаануудын хүрээнд санхүүгийн байгууллагуудад хууль ёсны хүчинтэй, заавал биелэгдэх үүрэгтэй бөгөөд тус байгууллага нь жил бүрийн тайлан, ил тод байдлын зарчмаар үйл ажиллагаагаа олон нийтэд нээлттэй тайлагнадаг.</p>	<p>Санхүүгийн зохицуулах хороо нь Санхүүгийн омбудсменийн үйлчилгээний бие даасан байдлыг хангах хүрээнд Их Британийн туршлагыг жишиг болгон авч үзэж болох бөгөөд үүнд санхүүжилтийн тогтолцоо болон жил бүрийн тайланг тогтмол нийтэлдэг практикийг харгалзан үзэх нь зүйтэй.</p>
Сингапур	<p>Сингапурын Санхүүгийн Салбарын Маргаан Шийдвэрлэх Төв (FIDReC)⁴⁵</p> <p>FIDReC нь Сингапурын Мөнгөний удирдах газар (MAS)-аас 2007 онд баталсан MAS-ийн Маргаан Шийдвэрлэх Тогтолцооны Журмын дагуу байгуулагдсан. Уг журмаар Сингапурын санхүүгийн салбарт хэрэгжих албан ёсны</p>	<p>Санхүүгийн зохицуулах хороо нь Санхүүгийн омбудсменийн үйлчилгээний шударга,</p>

⁴⁴ Санхүүгийн Омбудсменийн Үйлчилгээ (n.d.). Санхүүгийн маргааныг шударгаар шийдвэрлэх нь. Эндээс үзнэ үү: <https://www.financial-ombudsman.org.uk/>

⁴⁵ FIDReC. FIDReC 2024 оны тайлан – Хураангуй хувилбар. Эндээс үзнэ үү: https://www.fidrec.com.sg/_entity/annotation/a783d7cf-96a7-ef11-b8e9-6045bd22652a

Байршил	Тодорхойлолт	Монгол улсад хэрэгжүүлж болох гол шийдлүүд
	<p>маргаан шийдвэрлэх тогтолцооны байгууллагаар FIDReC-ийг томилсон байдаг.</p> <p>FIDReC-ийн үйл ажиллагаа нь санхүүгийн салбар, хэрэглэгчийн төлөөлөл, хууль, нягтлан бодох бүртгэлийн салбарын мэргэжилтнүүдээс бүрдсэн удирдах зөвлөл-өөр удирдуулдаг. Санхүүгийн салбарын туршлагатай гишүүдийг дотоод зөвлөгөө өгөх, салбарын онцлогт нийцсэн шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх зорилгоор тусгайлан томилдог.⁴⁶</p>	<p>хөндлөнгийн байдлыг хангах хүрээнд Сингапурын FIDReC-ийн туршлагыг жишиг болгон авч үзэх боломжтой. Үүнд салбарын болон хэрэглэгчийн төлөөллийг тэнцвэртэй оролцуулсан хяналтын тогтолцоог бүрдүүлэх зарчим онцгой ач холбогдолтой юм.</p>

6.2.4 Арга хэмжээ 4.4: Өрийн клиник байгуулах

Хүснэгт 22: Арга хэмжээ 4.4-ийн хураангуй

Зорилт	<p>Монгол Улсад иргэдийн өрийн эрсдэл нэмэгдэж буй нөхцөл байдалтай уялдуулан "Өрийн клиник" байгуулах шаардлагатай. Энэхүү клиник нь өнөөгийн өрийн дарамтад орсон хэрэглэгчдэд өрийн удирдлага, зөвлөх үйлчилгээ үзүүлэх бөгөөд үүний үр дүнд хэрэглэгчид өөрсдийн өрийн нөхцөл байдлыг илүү оновчтой, хариуцлагатайгаар удирдах боломжтой болно.</p>
Тайлбар	<p>Өрийн клиникийг Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ) болон Монголбанк (МБ)-ны хариуцлагын хүрээнд байгуулж, иргэдэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулах шаардлагатай. Учир нь СЗХ нь банк бус санхүүгийн байгууллага болон финтек тоглогчдыг, харин Монголбанк нь арилжааны банкуудын зээл олголтыг тус тус хариуцан хянаж байгаа бөгөөд эдгээр нь иргэдийн хэрэглээний зээл, өрийн өсөлтөд голлох нөлөө үзүүлж байна.⁴⁷</p> <p>Тус клиникийн үйл ажиллагаанд дараах чиглэлүүдийг багтааж болно: (1) Өрийн дарамтад орсон иргэдэд өрийн удирдлагын зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх; (2) Иргэдэд зориулсан хувийн санхүүгийн боловсролын сургалт, хөтөлбөр боловсруулах; (3) Хариуцлагатай зээллэгийн талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор нийгмийн ажил, сурталчилгаа, мэдээлэл хүргэх; (4) Монгол Улсын хүн амын дунд өрийн түвшин, нөлөөлөл, тархалтын талаар судалгаа хийх.</p>

⁴⁶ АХБ (2023). Монгол улсад санхүүгийн үйлчилгээний омбудсмен байгуулах нь: Армени, Австрали, Сингапур улсын туршлагаас. Эндээс үзнэ үү: <https://www.adb.org/sites/default/files/publication/892051/eawp-064-establishing-financial-services-ombudsman-mongolia.pdf>

⁴⁷ АХБ (2022). Монгол улс: Монгол Улсын санхүүгийн технологийн хууль эрх зүй, зохицуулалтын тогтолцоог боловсронгуй болгох нь. Эндээс үзнэ үү: https://www.adb.org/sites/default/files/project-documents/55234/55234-001-tar-en.pdf?utm_source=chatgpt.com#page=7

Хэрэгжилтийг хангах субъект	Санхүүгийн зохицуулах хорооны Санхүүгийн боловсрол, сургалтын алба
Оролцогч талууд	Монголбанкны Олон нийтийн санхүүгийн мэдээллийн алба, Монополийн эсрэг газар, Боловсрол Шинжлэх ухааны яам, Гэр бүл, Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Яам
Алхмууд	<p>Дараах алхмуудыг хэрэгжүүлэх боломжтой:</p> <ol style="list-style-type: none"> 1. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, өрийн зөвлөх үйлчилгээтэй холбоотой эрх, чиг үүргийг тусгах. Одоогийн байдлаар СЗХ нь Монгол Улсын иргэдэд санхүүгийн боловсрол олгох үйл ажиллагаа зохион байгуулах чиг үүрэгтэй. Гэсэн хэдий ч өрийн клиник нь СЗХ-ны хариуцлагын хүрээнд үр дүнтэй үйл ажиллагаа явуулахын тулд уг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн хүрээнд дараах агуулгатай дэд заалтуудыг шинээр нэмэх нь зүйтэй. Үүнд: (i) өртэй иргэдэд өрийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх, зохион байгуулах; (ii) өрийн клиникийн үйл ажиллагаанд мөрдөх журам, аргачлалыг батлах, хэрэгжилтийг зохион байгуулах, хянах эрхийг СЗХ-д олгоно. 2. СЗХ болон Монголбанк хооронд байгуулсан одоогийн Харилцан ойлголцлын санамж бичгийн (MOU) хүрээнд хамтын ажиллагааны чиглэл, үйл ажиллагааны хүрээг өргөтгөх. Банк, банк бус санхүүгийн байгууллага (ББСБ), хадгаламж, зээлийн хоршоод (ХЗХ)-ын хэрэглэгчдэд өрийн зөвлөх үйлчилгээ үр өгөөжтэй, хүртээмжтэй байхыг хангах үүднээс, СЗХ болон Монголбанк хооронд байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийн (MOU) хүрээнд өрийн клиникийн чиг үүргийг тусгаж, хамтын ажиллагааны хүрээг өргөтгөх боломжтой. Уг санамж бичигт оруулах нэмэлт өөрчлөлтүүд дараах агуулгыг тусгах. Үүнд: <ul style="list-style-type: none"> - СЗХ-ны Санхүүгийн боловсрол, сургалтын нэгж болон Монголбанкны Олон нийтийн санхүүгийн мэдээллийн төв хооронд мэдээлэл солилцох механизм бий болгох; - Өрийн клиникийг түшиглэн хэрэгжүүлэх өрийн дахин бүтэцлэлт болон зөвлөх үйлчилгээнд хамтран шийдвэр гаргах журмыг тодорхойлох; - Өрийн клиникийн хүрээнд зохион байгуулагдах санхүүгийн боловсрол, олон нийтэд чиглэсэн сургалт, сурталчилгааны үйл ажиллагаанд хамтран оролцох механизмыг тусгах; - Монголын хүн амын өрийн байдал, тархалт, нөлөөллийн талаар СЗХ болон Монголбанк хамтран судалгаа хийх хөтөлбөр хэрэгжүүлэх. 3. Өрийн клиникийн Үйл ажиллагааг тодорхойлох баримт бичиг (TOR)-ын төсөл боловсруулах. Өрийн клиникийн зорилго, бүтэц, оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг тодорхой болгохын тулд Үүрэг, чиг үүргийн тодорхойлолт (TOR) боловсруулах шаардлагатай. Уг баримт бичигт дараах гол агуулгыг багтаах. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Өрийн клиникийн эрх хэмжээ, зорилго; - Байгууллагын бүтэц, зохион байгуулалт; - Оролцогч тал тус бүрийн гүйцэтгэх үүрэг, хариуцлага; - Санхүүжилтийн эх үүсвэр болон урьдчилсан зардлын төсөөлөл. TOR-ын жишиг төсөл нь Хавсралт А-ийн Бокс С-д тусгагдсан болно.

- 4. Өрийн клиникийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн болон санхүүжилтийн загварыг тодорхойлох.** Өрийн клиник байгуулахад тулгамдах хамгийн чухал асуудлын нэг нь санхүүжилт юм. Хэрэв дотоод санхүүжилт хангалтгүй тохиолдолд, Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ) болон Монголбанк (МБ) нь санхүүгийн салбарын оролцогчдоос санхүүжилт татах хувилбарыг авч үзэх боломжтой.⁴⁸ Хүснэгт 23-т дурдсан Австралийн Үндэсний Өрийн Шуурхай Тусламжийн Шугам нь төр, хувийн хэвшлийн хамтарсан санхүүжилтийн загварын нэг жишээ бөгөөд Монголын нөхцөлд харгалзан үзэж болохуйц загвар юм. Санхүүжилтийн загвар нь аль нэг санхүүгийн байгууллагаас хэт хамааралыг бий болгохгүй, ингэснээр өрийн дахин бүтэцлэлттэй холбоотой ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь зайлшгүй чухал. Мөн өрийн клиникийн үйл ажиллагаанд Монголбанк, СЗХ эсхүл бие даасан байгууллага хяналт тавих бөгөөд тус байгууллагын удирдлагын бүрэлдэхүүнд өрийн зөвлөх үйлчилгээний салбарын төлөөллийг хангалттай түвшинд оролцуулах шаардлагатай.
- 5. Орон нутгийн иргэдэд мэдээллийг үр дүнтэй хүргэхийн тулд олон нийтэд чиглэсэн төлөвлөгөө боловсруулах, мөн холбогдох төрийн байгууллагуудтай хамтран ажиллах.** Өрийн клиник байгуулагдсан даруйд, олон нийтэд таниулах зорилгоор хэвлэл мэдээллийн сурталчилгаа, албан ёсны мэдэгдэл, хэвлэлийн бага хурал зохион байгуулах шаардлагатай. Мөн оролцогч яамд болон орон нутгийн иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах нь өрийн клиникийн талаарх олон нийтийн мэдлэг, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чухал нөлөөтэй. Хүснэгт 23-т дурдсан Хонг Конгийн Хөрөнгө оруулалт, санхүүгийн боловсролын зөвлөл нь олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан санхүүгийн боловсролыг амжилттай нийгэмшүүлсэн жишээ болохыг харуулж байна. Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ) нь орон нутгийн иргэдэд чиглэсэн үйлчилгээг хүргэхдээ тухайн бүс нутгийн хэрэгцээ, нөөцийг сайн ойлгодог нутгийн байгууллагуудтай хамтран ажиллах, тэдний сүлжээг ашиглах зэрэг олон төрлийн стратегийг ашиглах шаардлагатай. Мөн санхүүгийн боловсрол болон санхүүгийн удирдлагатай холбоотой мэдээллийг тухайн зорилтот бүлгийн онцлогт нийцүүлэн боловсруулж, хүргэх нь үр нөлөөг нэмэгдүүлнэ. Жишээлбэл, жижиг, дунд бизнес эрхлэгчид (ЖДБ)-д зориулсан тусгай сургалт, мэдээлэл бэлтгэх боломжтой. Хүснэгт 23-т дурдагдсан Малайзын Зээлийн зөвлөх ба өрийн удирдлагын агентлаг нь тодорхой зорилтот бүлгүүдэд зориулсан санхүүгийн боловсролын хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлж байгаа жишээ юм.

⁴⁸ АХБ (2019). Монгол улсын Банкны салбар дах Санхүүгийн хэрэглэгчийн хамгаалалтыг бэхжүүлэх нь. Эндээс үзнэ үү: <https://www.adb.org/sites/default/files/publication/545366/eawp-020-protection-consumers-mongolia-banking.pdf>

Хүснэгт 23: Арга хэмжээ 4.4-т хамаарах сайн туршлага

Байршил	Тодорхойлолт	Монгол улсад хэрэгжүүлж болох гол шийдлүүд
<p>Австрали</p>	<p>Үндэсний Өрийн Шуурхай Тусламжийн Шугам⁴⁹</p> <p>Үндэсний Өрийн Шуурхай Тусламжийн Шугам нь өрийн дарамтад орсон иргэдэд үнэ төлбөргүй санхүүгийн зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлдэг. Тус үйлчилгээ нь одоогоор Австралийн Санхүүгийн Зөвлөгөөний Холбоо (Financial Counselling Australia) хэмээх ашгийн бус байгууллагын хяналтад ажилладаг бөгөөд уг байгууллага нь улс орон даяарх санхүүгийн зөвлөгөө, дэмжлэгийн нөөц, чадавхийг хангаж ажилладаг. Шуурхай тусламжийн шугам нь муж эсхүл нутаг дэвсгэр бүрт харьяалах байгууллагуудаар дамжуулан бүс нутгийн онцлог, хэрэгцээ, нөөцөд үндэслэн зорилтот, уялдаа бүхий үйлчилгээ үзүүлдэг зохион байгуулалттай.</p> <p>Үндэсний Өрийн Шуурхай Тусламжийн Шугамын санхүүжилт дараах эх үүсвэрүүдээс бүрддэг: (1) Муж улс болон нутаг дэвсгэрийн санхүүжилт; (2) Холбооны (Commonwealth) төв санхүүжилт; (3) Санхүүгийн зөвлөгөөний салбар болон санхүүгийн салбарын тоглогчдын хамтын оролцоотойгоор хэрэгжүүлж буй “Салбарын хамтарсан санхүүжилтийн загвар” (Industry Funding Model for Financial Counselling). Энэхүү загвар нь санхүүгийн зөвлөх үйлчилгээг дэмжих зорилгоор төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгждэг.</p>	<p>Санхүүгийн зохицуулах хороо нь өрийн клиникийг дэмжих санхүүжилтийг зөвхөн дотоод нөөцөөс бүрдүүлэхээс зайлсхийхийн тулд, Австралийн төр-хувийн хэвшлийн хамтарсан санхүүжилтийн загварыг жишиг болгон авч үзэх боломжтой.</p>
<p>Малайз</p>	<p>Малайзын Зээлийн Зөвлөх ба Өрийн Удирдлагын Агентлаг (АКРК)⁵⁰</p> <p>АКРК нь 2006 онд байгуулагдсан бөгөөд зээл болон өрийн дарамтад орсон иргэдэд зээлийн эргэн төлөлтийн зохицуулалт хийхэд туслахын зэрэгцээ, санхүүгийн болон өрийн удирдлагын зөвлөгөө өгөх үйлчилгээг үзүүлдэг.⁵¹</p> <p>Санхүүгийн боловсролын хөтөлбөрүүдийг мөн АКРК-ийн хүрээнд хэрэгжүүлдэг бөгөөд эдгээр нь иргэдийг төрөл бүрийн санхүүгийн бүтээгдэхүүний талаарх мэдлэг, ойлголтоор хангах зорилготой. АКРК нь ерөнхий болон зорилтот бүлэгт чиглэсэн хосолсон аргачлалыг ашиглан олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагаа явуулдаг.</p>	<p>Санхүүгийн зохицуулах хороо нь Малайзын АКРК-ийн зорилтот бүлэгт чиглэсэн, оновчтой байдлаар хэрэгжүүлдэг санхүүгийн боловсрол, сургалтын аргачлалыг жишиг болгон авч</p>

⁴⁹ Нийгмийн үйлчилгээний яамны сайд нар (2024). Санхүүжилтийн загвар нь илүү олон Австраличуудад санхүүгийн зөвлөгөө авах боломжийг олгодог. Эндээс үзнэ үү: <https://ministers.dss.gov.au/media-releases/14381>

⁵⁰ НҮБ-ын Нийгмийн хөгжлийн судалгааны хүрээлэн (2024). Малайз, Тайланд, Индонезид өрийн удирдлагын хөтөлбөр эсвэл төлөвлөгөө (DMP) болон санхүүгийн болон зээлийн зөвлөгөө. Эндээс үзнэ үү: <https://cdn.unrisd.org/assets/library/papers/pdf-files/2024/wp-2024-2-debt-management-plan-financial-counselling-malaysia-thailand-indonesia.pdf>

⁵¹ Дэлхийн банк (2017). Малайз дахь санхүүгийн оролцоо: Бусад улс орнуудад зориулсан нэрэх сургамж. Эндээс үзнэ үү: <https://documents1.worldbank.org/curated/zh/703901495196244578/pdf/115155-WP-PUBLIC-GFM08-68p-FIpaperwebversion.pdf>

Байршил	Тодорхойлолт	Монгол улсад хэрэгжүүлж болох гол шийдлүүд
	<p>Тухайлбал, тус байгууллага нь коллеж, политехникумд суралцагч оюутнуудад зориулсан санхүүгийн боловсролын хөтөлбөрийг боловсруулж, сургалтын хөтөлбөрт тусгасан. Мөн жижиг, дунд бизнес эрхлэгчдэд (ЖДБ) зориулсан өр, санхүүгийн менежментийн тусгай хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн онцлогтой.</p>	<p>үзэх боломжтой. Энэхүү хандлага нь Монгол Улсад санхүүгийн боловсролыг олон нийтийн хэрэгцээ, онцлогт нийцүүлэн хүргэх үр дүнтэй арга зам болох юм.</p>
<p>Хонг Конг</p>	<p>Хөрөнгө оруулагч болон санхүүгийн боловсролын зөвлөл⁵²</p> <p>Хөрөнгө оруулагч болон санхүүгийн боловсролын зөвлөл (IFEC) нь Хонг Конгт хөрөнгө оруулагч болон иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэхэд зориулагдсан олон нийтийн байгууллага юм.</p> <p>IFEC (Хөрөнгө оруулагч болон санхүүгийн боловсролын зөвлөл) нь “Чингийн Гэр бүл” хэмээх санхүүгийн боловсролын платформуороо дамжуулан үнэ төлбөргүй, хөндлөнгийн, шударга мэдээлэл, сургалтын хөтөлбөр, нөөц бололцоог иргэдэд хүргэдэг. Энэхүү платформ нь олон нийтэд зориулсан үнэгүй мэдээлэл, боловсролын эх сурвалж, сургалтын хөтөлбөрүүдийг санал болгодог. IFEC нь олон нийтийн сонирхлыг татахуйц телевизийн сурталчилгаа, гудамжны зар сурталчилгаа, нийгмийн сүлжээгээр дамжуулсан мэдээллийн кампанит ажил зохион байгуулж, хөрөнгө оруулалт болон санхүүгийн боловсролын талаарх ойлголтыг түгээдэг. “Чингийн Гэр бүл” нь төрөл бүрийн насны бүлэг, амьдралын нөхцөлд тохируулан бүтээсэн дүрүүдтэй бөгөөд эдгээр дүрүүд нь үзэгч, хэрэглэгчдийн танил, ойлгомжтой байдлыг нэмэгдүүлж, өргөн хүрээтэй олон нийттэй илүү үр дүнтэй холбогдох нөхцөл бүрдүүлдэг. Мөн тус платформ нь хамтрагч байгууллагуудтай хамтран ажиллаж, хөрөнгө оруулалт болон санхүүгийн боловсролын хамрах хүрээг өргөжүүлдэг.</p>	<p>Санхүүгийн зохицуулах хороо нь өрийн клиник болон нийт иргэдэд чиглэсэн санхүүгийн боловсролыг сурталчлах хүрээнд IFEC-ийн ашигладаг олон нийтийн мэдээллийн стратегийг харгалзан үзэх боломжтой.</p>

⁵² Хөрөнгө оруулагч ба санхүүгийн боловсролын зөвлөл, Хонг Конг (n.d.). The Chin Family. Available at: <https://www.ifec.org.hk/web/en/about-the-chin-family/index.page>

7. Тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх

Санхүүгийн салбарт дижитал болон тоон гарын үсэг ашиглалтыг нэмэгдүүлэхийн тулд зохицуулалтын болон техникийн саад бэрхшээлүүдийг шийдвэрлэж, нэвтрүүлэхэд таатай орчныг бий болгох шаардлагатай. Зөвлөмжөөр (a) тоон болон цахим гарын үсгийн хууль зүйн үр дагаврыг тодорхой болгох; (b) тоон гарын үсэгт тавигдах техникийн болон тусгай зөвшөөрлийн шаардлагуудыг тодорхой болгох арга хэмжээг санал болгож байна.

7.1 Одоогийн нөхцөл байдал ба тулгамдаж буй асуудлууд

Финтекийг нэвтрүүлэх, хөгжүүлэхэд гэрээ хэлцэл, гүйлгээний цахимжилт нь чухал ач холбогдолтой бөгөөд Монгол улс цахим гарын үсэг, цахим гэрээ хэлцлийг нэвтрүүлэх чиглэлээр хэд хэдэн идэвхтэй алхмуудыг хийж байна. Гэвч санхүүгийн салбарт цахим болон тоон гарын үсгийн бодит хэрэглээнд техникийн болон хууль зүйн хэд хэдэн бэрхшээл тулгарсаар байна. Тулгамдаж буй асуудлуудыг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

- **Цахим болон тоон гарын үсгийн эрх зүйн орчны тодорхойгүй байдал.** Монгол улсын зарим хууль тогтоомжоор тодорхой тохиолдолд цахимаар байгуулсан гэрээг хүлээн зөвшөөрдөг⁵³ ч Цахим гарын үсгийн тухай хуульд цахим гарын үсгийн хууль зүйн статус тодорхойгүй зохицуулсан. Жишээлбэл, салбарын оролцогчид цахим гарын үсгийн хууль зүйн хувьд хүчин төгөлдөр байдлыг шүүхүүд бүрэн хүлээн зөвшөөрөөгүй талаарх санаа зовнилоо илэрхийлсэн. Цаашилбал, Цахим гарын үсгийн тухай хуулиар цахим болон тоон гарын үсгийн хууль эрх зүйн үр нөлөөний ялгаа болон тухайлсан баримт бичгүүдэд аль гарын үсгийн төрлийг ашиглаж болох эсвэл ашиглах боломжгүйг тодорхой тайлбарлаагүй байна.
- **Цахим гарын үсэгт тавигдах шалгуурын тодорхойгүй байдал.** Салбарын оролцогчид цахим гарын үсгийн шалгуурын талаар илүү их зааварчилгаа шаардлагатай байгааг хэлэв. Одоогийн Цахим гарын үсгийн тухай хуульд цахим гарын үсгийг хууль ёсны хүчинтэйд тооцох тодорхой шалгуур, тэр дундаа найдвартай байдлын тодорхой шалгуур, тодорхой технологид хязгаарлагдахгүй байх заалтуудыг тусгаагүй.
- **Тоон гарын үсэгт тавигдах техникийн шаардлагуудын тодорхойгүй байдал.** Цахим гарын үсгийн тухай хуулиар “тоон” гарын үсэг гэж үзэх техникийн нөхцөлүүдийг тодорхойлсон боловч салбарын оролцогчдын дунд түүний практик хэрэглээний асуудлыг тодорхойгүй үлдээжээ. Тодруулбал, зөвлөлдөх уулзалтын үеэр оролцогч талууд тоон гарын үсэг юунаас бүрддэг нь тодорхой бус байдаг гэжээ. ЦХИХХЯ шаардлага хангасан тоон гарын үсгийн хэрэгслийн төрлийн жагсаалтыг одоогоор нийтлээгүй байгаа бөгөөд энэ нь тоон гарын үсгийг ашиглалтыг дэмжихэд чухал нөлөө үзүүлэх байсан.⁵⁴

⁵³ Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулиар гэрээг цахим хэлбэрээр хийх боломжийг олгосон.

⁵⁴ Азийн Хөгжлийн Банк (ADB) (2023). Монгол Улс: Цахим худалдаа эрхлэх таатай орчныг бүрдүүлэх нь. Эндээс үзнэ үү: https://lpr.adb.org/sites/default/files/event/1768/FINAL-Report-on-Ecommerce-Law-of-Mongolia-March-10-EN_0_1.pdf

7.2 Замын зураглалд санал болгож буй арга хэмжээ

Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк болон салбарын оролцогчдоос ирүүлсэн санал хүсэлтэд үндэслэн цахим болон тоон гарын үсгийн хэрэглээ, хууль зүйн үр дагаврыг тодорхойлох, нэмэгдүүлэх, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдэд тоон гарын үсгийн хүртээмжийг сайжруулах зорилгоор 3 үйл ажиллагааг санал болгож байна. Үүнд (санал болгож буй дарааллын дагуу хэрэгжүүлнэ):

- (i) Цахим болон тоон гарын үсгийн хууль зүйн үр дагаврыг тодорхой болгох;
- (ii) Цахим болон тоон гарын үсгийг хууль зүйн хувьд хүчин төгөлдөр болоход тавигдах шаардлагыг тодорхой болгох;
- (iii) Санхүүгийн салбарт тоон гарын үсгийн бодит хэрэглээг хялбаршуулах;

7.2.1 Арга хэмжээ 5.1: Цахим болон тоон гарын үсгийн хууль зүйн үр дагаврыг тодорхой болгох

Хүснэгт 24: Арга хэмжээ 5.1-ын хураангуй

Зорилт	Цахим гарын үсгийн тухай хуульд гарын үсгийн төрөл тус бүрийн хууль зүйн үр дагаврыг тодорхой тусгасан нэмэлт өөрчлөлт оруулах, тоон болон цахим гарын үсгийн хэрэглээнд итгэх итгэлийг нэмэгдүүлэх.
Тайлбар	Цахим гарын үсгийн тухай хуульд оруулах нэмэлт өөрчлөлт нь цахим болон тоон гарын үсгийн ашиглалт, хэрэглээтэй холбоотой тодорхойгүй нөхцөлүүдийг тодруулахад зорилготой байна. Санал болгож буй нэмэлт өөрчлөлтүүдэд: <ul style="list-style-type: none"> (iv) Гарын үсэг шаардлагатай ихэнх тохиолдлуудад цахим гарын үсгийг хүлээн зөвшөөрөх тухай дэд заалтуудыг нэмэх; (v) Цахим болон тоон гарын үсгийн алийг нь хүлээн зөвшөөрөх ялгааг тодорхойлох заалт нэмэх; (vi) Цахим болон/эсвэл тоон гарын үсгийг оруулахгүй байх баримт бичиг/тохиолдлуулын талаарх тодорхой тусгасан нэмэлт дэд хэсэг/заалт нэмэх; (vii) Гадаад улсын тоон гарын үсгийг хүлээн зөвшөөрөхийг дэмжих тухай нэмэлт дэд хэсэг/заалт нэмэх;
Хэрэгжилтийг хангах субъект	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам (ЦХИХХЯ)
Оролцогч талууд	Улсын бүртгэлийн ерөнхий газар (УБЕГ), СЗХ болон Монгол банк зэрэг цахим/тоон гарын үсгийг хүлээн зөвшөөрөхгүй байх боломжтой бусад агентлагууд
Алхмууд	Санал болгож буй нэмэлт, өөрчлөлтүүдийг дараах байдлаар тодорхойлов. <ol style="list-style-type: none"> 1. Цахим гарын үсгийг хуулиар хүлээн зөвшөөрөх нөхцөлийг тодорхой болгох. Цахим гарын үсгийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр гарын үсэг шаардлагатай тохиолдлуудад цахим гарын үсгийг хүлээн зөвшөөрснөөр цахим гарын үсгийг өргөн хүрээнд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Тодруулбал, Цахим гарын үсгийн тухай хуульд цахим баримт бичиг (цахим гарын үсэг)-ийг хууль ёсоор хүлээн зөвшөөрөхийг тодорхой зааж, цахим гарын үсгийг хууль зүйн үүрэг, хууль зүйн шаардлагыг биелүүлэхэд ашиглах нөхцөлийг заана. Хүснэгт 25-д Тайланд улсын Цахим хэлцлийн тухай хууль (ЕТА)-ийн 1-р бүлэгт заасан цахим гарын үсгийг хууль зүйн хувьд хүлээн зөвшөөрөх нөхцөлийг жишээгээр оруулав.

2. **Цахим болон тоон гарын үсгийн хэрэглээний ялгааг тодорхой болгох.** Монгол улсын засгийн газар Цахим гарын үсгийн тухай хуульд цахим болон тоон гарын үсгийг хүлээн зөвшөөрөх, хэрэглээний ялгаатай нөхцөлүүдийг тодорхой тусгасан дэд заалтуудыг нэмэх хэрэгтэй. Тодруулбал, Цахим болон дижитал гарын үсэгтэй холбоотой хууль зүйн боломжит тохиолдлуудыг нэмэлт заалт эсвэл тусгай бүлэг болгон хуульд тусгах нь зүйтэй. **Хүснэгт 25**-д дурдсан Сингапур улсын Цахим хэлцлийн тухай хууль (ЕТА)-ийн 19-р зүйлийн 3 дах хэсэгт аюулгүй байдлын журам, шаардлагыг хангаж байгаа эсэхээр нь энгийн цахим гарын үсэг болон аюулгүй цахим гарын үсгийг хооронд ялгаж, аюулгүй байдлын шалгуурыг хангасан цахим баримт бичгийг хүлээн зөвшөөрөх хууль зүйн тохиолдлуудыг тухайлан заасан.
3. **Цахим ба/эсвэл тоон гарын үсгийг хүлээн зөвшөөрөхгүй байх баримт бичиг/тохиолдлыг тодорхойлох.** Монгол улсын засгийн газар Цахим гарын үсгийн тухай хуульд цахим ба/эсвэл тоон гарын үсгийг хүлээн зөвшөөрөхгүй байх баримт бичиг эсвэл тохиолдлуудыг тодорхойлсон хэсэг нэмэх шаардлагатай. Жишээ нь: Тайланд улсад гэр бүл болон өв залгамжлалтай холбоотой баримт бичигт цахим гарын үсгийг хүлээн зөвшөөрдөггүй бол Хятад, Сингапур, Энэхтхэг улсуудад цахим ба/эсвэл тоон гарын үсгээр эд хөрөнгө шилжүүлсэн тохиолдолд хүчин төгөлдөр бусад тооцдог.⁵⁵ **Хүснэгт 25**-д Сингапур улсын Цахим гарын үсгийн тухай хуулийн хүлээн зөвшөөрөхгү тохиолдолдлуудын жишээг оруулав.

Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа ЦХИХХЯ нь холбогдох яамдуудтай зөвлөлдөн зөвхөн гараар бичсэн гарын үсгийг хууль ёсны гэж үзэх баримт бичгүүдийг тодорхойлох шаардлагатай.

Мөн Цахим гарын үсгийн тухай хуульд гадаад улсын цахим ба/эсвэл тоон гарын үсгийн хүчин төгөлдөр байдлыг тодорхойлсон хэсэг нэмэх нь зүйтэй. Тодруулбал, цахим ба/эсвэл тоон гарын үсгийг Монгол улсын нутаг дэвсгэрээс гадна олгосон буюу ашигласан үндэслэлээр хууль зүйн хүчинтэй байдал, үр дагавар, эсхүл биелүүлэх боломжийг нь үгүйсгэх ёсгүй гэдгийг тодорхой заах хэрэгтэй.

Хүснэгт 25: Арга хэмжээ 5.1-т хамаарах сайн туршлагаууд

Байршил	Тайлбар	Монгол улсад хэрэгжүүлж болох гол шийдлүүд
Тайланд	Тайланд улсын Цахим Хэлцлийн тухай хууль 1997 (ЕТА-Т) ⁵⁶ Тайланд улсын Цахим хэлцлийн тухай хуулиар цахим хэлцлийн хууль зүйн үндэслэлийг тодорхойлсон. Уг хуулийн	ЦХИХХЯ нь цахим гарын үсгийг хууль зүйн хувьд хүлээн зөвшөөрөх

⁵⁵ Acclime (n.d.). Азийн бизнес эрхлэгчдэд зориулсан цахим гарын үсгийн бүс нутгийн гарын авлага. Эндээс үзнэ үү: <https://www.acclime.com/downloads/regional-esignature-guide/>

⁵⁶ Тайланд улсын Засгийн газар (1997). Цахим хэлцлийн тухай хууль. Эндээс үзнэ үү: <https://www.eta.or.th/getattachment/8faa736b-3235-49c8-8b01-d37ff53a9a45/ENG-Version.aspx>

Байршил	Тайлбар	Монгол улсад хэрэгжүүлж болох гол шийдлүүд
	<p>дараах хэсгүүдэд заасанчлан цахим гарын үсгийг хууль ёсоор хүлээн зөвшөөрдөг.</p> <ul style="list-style-type: none"> 1 дүгээр бүлэг, 7 дах хэсэг: “Мэдээлэл нь зөвхөн цахим хэлбэртэй байгаа гэх үндэслэлээр хууль зүйн хүчин төгөлдөр байдал, хэрэгжилтийг үгүйсгэж үл болно.” 1 дүгээр бүлэг, 9 дэх хэсэг: “Хэрэв тодорхой этгээдээс бичгээр гарын үсэг зурах шаардлагатай бол дараах нөхцөлийг хангасан тохиолдолд тухайн цахим мэдээлэл нь гарын үсэг зурсанд тооцно. Үүнд: (1) ашигласан арга нь гарын үсэг зурсан этгээдийг тодорхойлох боломжтой бөгөөд тухайн цахим мэдээлэлд багтсан мэдээллийг өөрийн зүгээс баталсан болохыг илэрхийлж байх; (2) тухайн арга нь тухайн цахим мэдээлэл үүсгэгдсэн буюу илгээгдсэн зорилгодоо нийцсэн, найдвартай арга байх бөгөөд тухайн нөхцөл байдал эсвэл талуудын хоорондын тохиролцоог харгалзсан байх.” 	<p>зохицуулалтыг тусгах зайлшгүй шаардлагатай. Үүнтэй зэрэгцэн, найдвартай байдлын тодорхой шалгуурыг хангаж байгаа тохиолдолд цахим гарын үсгийг хууль ёсны хүчинтэйд тооцох нөхцөлийг ч мөн хуульчилсан байх нь чухал юм.</p>
Сингапур	<p>Сингапур улсын Цахим хэлцлийн тухай хууль (2010)⁵⁷</p> <p>Цахим хэлцлийн тухай хууль нь Сингапур улсад цахим хэлцлийн хууль зүйн үндэслэлийг тодорхойлсон. Хуулиар баталгаатай цахим бичиг баримт болон гарын үсэгтэй холбоотой хууль зүйн тохиолдлуудыг тусгасан байдаг</p> <ul style="list-style-type: none"> 3 дугаар хэсэг, 19(1) дүгээр зүйл: “Баталгаатай цахим баримт бичигтэй холбоотой аливаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эсрэг нотлох баримт гаргаагүй тохиолдолд тухайн цахим баримт бичиг нь уг баримтыг баталгаатай гэж үзэх тодорхой цаг үеэс хойш өөрчлөгдөөгүй гэж үзнэ.” 3 дугаар хэсэг, 19(2) дугаар зүйл: “Баталгаатай цахим гарын үсэгтэй холбоотой аливаа хэрэг, маргааны үеэр эсрэг нотлох баримт гаргаагүй тохиолдолд дараах нөхцөлийг биелсэн гэж үзнэ: (а) баталгаатай цахим гарын үсэг нь түүнд хамаарах этгээдийн гарын үсэг байна; (б) уг цахим гарын үсгийг тухайн этгээд нь тухайн цахим баримт бичигт гарын үсэг зурах эсвэл батлах зорилгоор өөрөө хэрэглэсэн.” 	<p>ЦХИХХЯ аливаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед нотлох үүргийг тодорхой болгохын тулд цахим болон/эсвэл тоон гарын үсэгтэй холбоотой хууль зүйн тохиолдлуудыг тусгах хэрэгтэй.</p>
Сингапур	Сингапур улсын Цахим хэлцлийн тухай хууль (2010)⁵⁸	

⁵⁷ Сингапурын хуулийн цахим сан (SSO) (n.d.). Сингапур улсын Цахим хэлцлийн тухай хууль 2010. Эндээс үзнэ үү: <https://sso.agc.gov.sg/Act/ETA2010?ProvIds=P12->

⁵⁸ Сингапурын хуулийн цахим сан (SSO) (n.d.). Сингапур улсын Цахим хэлцлийн тухай хууль 2010. Эндээс үзнэ үү: <https://sso.agc.gov.sg/act/eta2010>

Байршил	Тайлбар	Монгол улсад хэрэгжүүлж болох гол шийдлүүд
	<p>Цахим гарын үсгийн тухай хуулиар 2-р бүлэгт зааснаар дараах асуудлуудад хэрэглэхгүй байхаар заасан:</p> <ul style="list-style-type: none"> ● <i>Эхний хуваарь (1):</i> “Гэрээслэлийн гүйцэтгэл үйлдэх” ● <i>Эхний хуваарь (2):</i> “Хууль зүйн үүрэг хүлээсэн гэрээ (indenture), итгэмжлэлийн тунхаг бичиг (declaration of trust), эсвэл далд, хууль ёсоор үүссэн болон үр дүнгийн итгэмжлэл үйлдэх, биелүүлэх, хэрэгжүүлэх үйлдэл болон 2008 оны ‘Сэтгэцийн чадавхийн тухай хууль’-ийн 2(1)-д заасан урт хугацааны итгэмжлэлд хамаарахгүй.” ● <i>Эхний хуваарь (3):</i> “Үл хөдлөх эд хөрөнгийг худалдах болон бусад захиран зарцуулах аливаа гэрээ, эсхүл уг эд хөрөнгийн аливаа сонирхол” ● <i>Эхний хуваарь (4):</i> “Үл хөдлөх эд хөрөнгийг шилжүүлэх эсвэл үл хөдлөх хөрөнгийн аливаа эрхийг шилжүүлэх.” 	<p>ЦХИХХЯ нь цахим болон/эсвэл тоон гарын үсгийг хууль ёсны хүчин төгөлдөр гэж үзэхгүй байх нөхцөл байдал, хэрэглэхгүй байх тохиолдлыг Цахим гарын үсгийн тухай хуульд тусгах хэрэгтэй.</p>

7.2.2 Арга хэмжээ 5.2: Цахим гарын үсгийн хууль зүйн хувьд хүчин төгөлдөрт тооцох шалгуурыг тодорхойлох

Хүснэгт 26: Арга хэмжээ 5.2-ын хураангуй

Зорилт	Цахим болон тоон гарын үсгийн хүчинтэй байдалд итгэх итгэлийг нэмэгдүүлэхийн тулд Цахим гарын үсгийн тухай хуульд тухайлсан найдвартай байдлын шалгуур болон тодорхой технологид хязгаарлагдахгүй байх заалтуудыг багтаах шаардлагатай.
Тайлбар	Цахим гарын үсгийн тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт нь: <ul style="list-style-type: none"> (i) Цахим болон/эсвэл тоон гарын үсгийн найдвартай байдлын шалгуурыг хууль ёсны хүчинтэйд тооцсон зүйл, бүлгийг нэмэх; (ii) Ашигласан технологиос үл хамааран хуулийн хүчинтэй байдлыг тодорхойлсон зүйл ба/эсвэл бүлгийг нэмж оруулах.
Хэрэгжилтийг хангах субъект	Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны яам (ЦХИХХЯ)
Оролцогч талууд	Улсын Бүртгэлийн Ерөнхий газар (УБЕГ)
Алхмууд	<p>Хэрэгжүүлэх алхмуудыг дараах хэлбэрээр тодорхойлов.</p> <ol style="list-style-type: none"> 1. Цахим/тоон гарын үсгийг хүчинтэйд тооцох найдвартай байдлын шалгуурыг боловсруулах. Одоогийн Цахим гарын үсгийн тухай хуулиар зөвхөн тоон гарын үсэгт тавигдах шаардлагыг тодорхойлсон. Цахим гарын үсгийг хэрэглээнд итгэх итгэлийг нэмэгдүүлэхийн тулд Цахим гарын үсгийн тухай хуульд гарын үсэг нь жинхэнэ, хөндлөнгийн оролцоогүй, гарын үсэг зурсан этгээдтэй хамаатуулж болох найдвартай байдлын тодорхой шалгууруудыг тусгасан нэмэлт өөрчлөлтийг хийх

хэрэгтэй. Тухайлбал, **Хүснэгт 27**-д оруулсан Юнситралын Цахим гарын үсгийн загвар хуульд тусгасанчлан Цахим гарын үсгийн тухай хуульд дараах агуулгатай заалтуудыг тусгах шаардлагатай: (i) гарын үсэг үүсгэсэн өгөгдөл нь зөвхөн гарын үсэг зурж буй этгээдтэй холбоотой байх бөгөөд өөр этгээдтэй хамааралгүй байх; (ii) гарын үсэг үүсгэх өгөгдөл нь гарын үсэг зурж буй үед тухайн этгээдийн хяналтанд байх ёстой; (iii) гарын үсэг зурсны дараа хийгдсэн аливаа өөрчлөлтийг илрүүлэх боломжтой байх;

Найдвартай байдлын шалгуурыг боловсруулах үед ЦХИХХЯ нь тоон гарын үсгийн найдвартай байдлыг хянах, хэрэгжилтийг хангах боломжтой эсэх талаар УБЕГ-аас санал авах боломжтой.

2. **Ашигласан технологиос үл хамааран хууль зүйн хувьд хүчин төгөлдөр байх нөхцөлийг хангах технологийн төвийг сахисан заалтуудыг боловсруулах.** Одоогийн Цахим гарын үсгийн тухай хуульд технологиос үл хамаарах заалтуудыг тусгаагүй байгаа нь цахим гарын үсгийн хэрэглээнд зөрчил үүсгэж болзошгүй. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Олон Улсын Гэрээнд Цахим Харилцааг Хэрэглэх Тухай Конвенцийн (ЕСС)⁵⁹ сайн туршлагуудтай нийцүүлэн, Цахим гарын үсгийн тухай хуульд *"найдвартай байдлын шаардлагуудыг хангасан цахим гарын үсэг үүсгэх ямар ч арга нь хууль зүйн хүчин төгөлдөр байдлыг үгүйсгэх, хязгаарлах, эсхүл хэрэгсэхгүй болгох ёсгүй"* болохыг тодорхой заасан заалтыг нэмэх шаардлагатай.

Хүснэгт 27: Арга хэмжээ 5.2-т хамаарах сайн туршлагууд

Байршил	Тайлбар	Монгол улсад хэрэгжүүлж болох гол шийдлүүд
НҮБ	<p>ЮНСИТРАЛ Цахим гарын үсгийн загвар хууль (2001)⁶⁰</p> <p>Юнситралын Цахим гарын үсгийн загвар хуулиар цахим гарын үсгийн хууль ёсны хүчинтэй байдлыг тодорхойлоход уян хатан стандарт хэрэглэгддэг. Тус Загвар хууль нь найдвартай, үл мөртэй, болон өөрчлөгдөшгүй байдлын тодорхой түвшингүүдийг харгалзан үздэг. Дараах тохиолдолд цахим гарын үсэг нь найдвартай гэж тооцогддог:</p> <ul style="list-style-type: none"> • <i>6(3a) дугаар зүйл:</i> “Гарын үсэг үүсгэсэн өгөгдөл нь тэдгээрийг хэрэглэсэн агуулгын хүрээнд гарын үсэг зурсан хүнээс бусад этгээдтэй холбоогүй байна ” • <i>6(3b) дугаар зүйл:</i> “Гарын үсэг үүсгэсэн өгөгдөл нь гарын үсэг зурах үед зөвхөн тухайн хүний хяналтан дор байна” 	<p>ЦХИХХЯ нь цахим гарын үсэгтэй холбоотой найдвартай байдлын холбогдох бүлгүүдийг боловсруулахдаа санал болгож буй найдвартай байдлын шалгууруудыг харгалзан үзэж болно.</p>

⁵⁹НҮБ (2005). Нэгдсэн Үндэстний Байгууллагын Олон Улсын Гэрээнд Цахим Харилцааг Хэрэглэх Тухай Конвенц (ЕСС). Эндээс үзнэ үү: https://wipolex-res.wipo.int/edocs/lexdocs/treaties/en/uncitral-uecic/trt_uncitral_uecic.pdf

⁶⁰ НҮБ (2002). ЮНСИТРАЛ Цахим гарын үсгийн загвар хууль. Эндээс үзнэ үү: <https://uncitral.un.org/sites/uncitral.un.org/files/media-documents/uncitral/en/ml-elecsig-e.pdf>

	<ul style="list-style-type: none"> • <i>6(3c) дугаар зүйл:</i> “Гарын үсэг үүсгэсэн өгөгдөл нь гарын үсэг зурагдсаны дараа хийсэн ямар ч өөрчлөлтийг илрүүлэх боломжтой байна” • <i>6(3d) дугаар зүйл:</i> “Гарын үсэг зурсан зорилго нь мэдээллийн бүрэн бүтэн байдлыг баталгаажуулахад чиглэсэн бол, гарын үсэг зурахаас хойш тухайн мэдээлэлд хийсэн ямар ч өөрчлөлт илрэх боломжтой.” байна. 	
--	--	--

7.2.3 Арга хэмжээ 5.3: Санхүүгийн үйлчилгээний салбарт тоон гарын үсгийн бодит хэрэглээг хөнгөвчлөх

Хүснэгт 28: Арга хэмжээ 5.3-ын хураангуй

Зорилт	Тоон гарын үсгийн бодит хэрэгжилтэд одоо ч тодорхойгүй байдал байсаар байна. Тоон гарын үсгийн техникийн шаардлагууд нь Финтек үйлчилгээ үзүүлэгчдийн ашигладаг гарын үсэгт хэрхэн хамаарах талаар тодорхойгүй байна. Тоон гарын үсгийн техникийн шаардлагуудын талаар тодорхой удирдамж нь санхүүгийн салбарт тоон гарын үсгийг ашиглахад чиглүүлж болох бөгөөд санхүүгийн салбарын тоон гарын үсгийн үйлчилгээ үзүүлэгчдийн хүртээмжийг өргөжүүлэх нь цаашдын хэрэглээг дэмжих болно.
Тайлбар	Тоон гарын үсгийн хэрэглээ, ашиглалтыг хөнгөвчлөх талаар дараах үйл ажиллагааг санал болгож байна. <ul style="list-style-type: none"> (i) Тоон гарын үсгийн үйлчилгээ үзүүлэгчдийг магадлан итгэмжлэх шалгуурыг тодорхой болгож, цахим гарын үсгийн шаардлага, үйл явцыг ил тод болгох; болон (ii) Тоон гарын үсгийг ашиглах боломжтой холбогдох тоон гарын үсгийн үйлчилгээ үзүүлэгчдийг тодорхойлох.
Хэрэгжилтийг хангах субъект	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам (ЦХИХХЯ)
Оролцогч талууд	Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар (УБЕГ)
Алхмууд	Дараах алхмуудыг санал болгож байна: <ol style="list-style-type: none"> 1. Тоон гарын үсэгт тавигдах техникийн болон тусгай зөвшөөрлийн шаардлагуудын талаар удирдамж боловсруулах. Цахим гарын үсгийн тухай хуулийн 2 дугаар бүлгийн 8 дугаар зүйлд тоон гарын үсгийн хэрэгсэл, түүнд тавигдах шаардлагуудыг тодорхойлсон. Гэвч санхүүгийн салбарын оролцогч талууд олон тохиолдолд тоон гарын үсэг олгох, хүлээн авах боломжгүй байгаагаа илэрхийлсэн; бөгөөд тоон гарын үсгийн агуулга, үйл ажиллагааны талаар буруу ойлголттой байгаагаа ч мөн илэрхийлсэн. Тоон гарын үсэгт тавигдах шаардлагын талаар ерөнхий болон тухайлсан салбарын хүрээнд удирдамж боловсруулах хэрэгтэй. Эдгээр удирдамж нь тоон гарын үсгийг хүчинтэйд тооцохын тулд тоон гарын үсгийн үйлчилгээ үзүүлэгчдийн дагаж мөрдөх шаардлагуудыг харуулахад дэмжлэг үзүүлнэ. Хүснэгт 29-д Малайзын Дижитал гарын үсгийн тусгай зөвшөөрлийн гарын авлагад ийм шалгууруудын жишээг тоймлон харуулав.

2. Магадлан итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагуудын бүрэн жагсаалтыг нийтлэх. Итгэмжлэгдсэн гуравдагч этгээдүүд буюу төрийн зөвшөөрөгдсөн гэрчилгээжүүлэх байгууллагаас гаргасан тоон гарын үсгийг автоматаар найдвартай гэж үзэж, хуулиар хүлээн зөвшөөрдөг.⁶¹ УБЕГ-ын саналын дагуу баталгаажуулалтын байгууллагуудын урьдчилан баталсан жагсаалтыг гаргаснаар тоон гарын үсгийн хэрэгжилтийг оновчтой болгож, хүлээн зөвшөөрөлтийг дэмжих болно.

Хүснэгт 29: Арга хэмжээ 5.3-т хамаарах сайн туршлагууд

Байршил	Тайлбар	Монгол улсад хэрэгжүүлж болох гол шийдлүүд
Малайз	<p>Тоон гарын үсгийн тусгай зөвшөөрлийн гарын авлага⁶²</p> <p>Тоон гарын үсгийн тусгай зөвшөөрлийн гарын авлага нь Малайз дахь тоон гарын үсэгтэй холбоотой бүх тусгай зөвшөөрөл, өргөдөлд хамаарах үйл явцын талаар мэдээлэл өгдөг. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Өргөдлийг үнэлэхэд хэрэглэгдэх шалгуурууд, үүнд төрөл бүрийн тусгай зөвшөөрлийн ерөнхий болон тусгай шаардлагууд; • Өргөдөл гаргах журам; • Аудит, төлбөрийн үйл явц гэх мэт. 	<p>ЦХИХХЯ нь санхүүгийн салбарт тусгай шаардлага бүхий тоон гарын үсгийн баталгаажуулалтын байгууллагуудын магадлан итгэмжлэлийн үйл явцын удирдамжийг бүрдүүлэхийн тулд эдгээр элементүүдийг харгалзан үзэж болно.</p>
Индонези	<p>Цахим гэрчилгээжүүлэх байгууллага (PSrE) мэдээллийн сан болон PDFSign</p> <p>Харилцаа холбоо, цахим хөгжлийн яам (Комдиги) нь бүртгэгдсэн цахим гэрчилгээжүүлэх байгууллагуудын жагсаалтыг цахим мэдээллийн санд нэгтгэн, олон нийтэд хялбар нэвтрэх боломжтой байдлаар байршуулсан.⁶³</p> <p>PSrE-ийн шаардлага болон нийцлийн удирдамжийг нийтлэхээс гадна, Komdigi нь олон нийтэд баталгаажсан цахим гарын үсгийг шалгахад тусалдаг PDFSign нэртэй программыг хөгжүүлсэн.⁶⁴</p>	<p>ЦХИХХЯ нь тоон гарын үсгийн хэрэглээнд илүү их итгэл төрүүлэх, хэрэглээг хөнгөвчлөхийн тулд энэхүү арга хэмжээг авч үзэж болно.</p>

⁶¹ Сингапурын Мэдээлэл, Харилцаа Холбоо, Медиа Хөгжлийн Газарт (Infocomm Media Development Authority, Singapore) (2024). Үндсэн ойлголтууд. Эндээс үзнэ үү: <https://www.imda.gov.sg/regulations-and-licensing-listing/electronic-transactions-act-and-regulations/controller-of-certification-authorities/key-conceptsc>

⁶² Малайзын Харилцаа Холбоо, Медиа Комисс(МСМС) (2024). Лицензжүүлэх гарын авлага: Цахим гарын үсэг. Эндээс үзнэ үү: <https://mcmc.gov.my/skmmgovmy/media/General/pdf/DSA-Licensing-Guidebook.pdf>

⁶³ Комдиги (Komdigi) (n.d.). Цахим гарын үсгийн гэрчилгээ олгогч байгууллага. Эндээс үзнэ үү: <https://www.rootca.id/>

⁶⁴ Комдиги (Komdigi) (n.d.). PDFSign: баримт бичиг, PDF-ыг шалгах. Эндээс үзнэ үү: <https://tte.kominfo.go.id/verifyPDF>

8. eKYC-н илүү өргөн хэрэглээг нэмэгдүүлэх

Санхүүгийн салбарт дижитал үйл ажиллагааг өргөн хүрээнд нэвтрүүлэхийг дэмжихийн тулд зохицуулалт болон техникийн удирдамжууд нь уялдуулах, цахим “Харилцагчийг таньж мэдэх” (eKYC) шийдлүүдийг хэрэглэхэд зах зээлийн итгэлцлийг бүрдүүлэх шаардлагатай. Үүний тулд авч хэрэгжүүлэх гол арга хэмжээний нэг нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд зааснаар биечлэн хийдэг KYC шалгалтын үед л баримт бичгийг эх хувьтай тулган баталгаажуулах шаардлагатай болохыг тодорхой заах юм. Үүнээс гадна, хялбаршуулсан таньж мэдэх тогтолцоог нэвтрүүлэх, eKYC-ийн удирдамж боловсруулах нь санхүүгийн салбарт eKYC шийдлүүдийг түргэн шуурхай, өргөн хүрээнд хэрэгжүүлэхэд дэмжлэг болно.

8.1 Одоогийн нөхцөл байдал болон тулгамдаж буй асуудал

Одоогийн байдлаар цахим “Харилцагчийг таньж мэдэх” (eKYC) үйл явцыг хэрэгжүүлэх талаарх тодорхой удирдамж дутмаг, мөн eKYC-ийн хууль ёсны хүчинтэй байдлын талаарх ойлголт бүрэн тодорхой бус байгаагаас үүдэн уг процессыг нэвтрүүлэхэд итгэл үнэмшил сул, цаашлаад финтек хөгжлийг сааруулж байна. Ил тод болгох, сайжруулах шаардлагатай голлох дутагдал болон анхаарах асуудлуудыг дараах байдлаар тодорхойлов.

- **Санхүүгийн салбарт eKYC-ийг нэвтрүүлэхэд тодорхой техникийн шаардлагууд дутмаг байна.** Стандартад нийцсэн удирдамж дутмаг байгаа нь тодорхойгүй байдал үүсгэж, хэрэгжилтийг удаашруулж байна. Иргэний үнэмлэх баталгаажуулалтын үйл явц, өгөгдлийн аюулгүй байдлын арга хэмжээ, техникийн дэд бүтцийн стандарт зэрэг хамгийн бага шаардлагыг тодорхойлох нь санхүүгийн байгууллагуудад eKYC-г илүү итгэлтэй, үр дүнтэй нэвтрүүлэхэд шаардлагатай тодорхой байдал, итгэлцлийг бүрдүүлнэ.
- **KYC-г зохицуулсан хуулиудын хоорондын зөрчилтэй байдал гэж ойлгогдож буй нөхцөл байдал.** Оролцогч талуудтай хийсэн уулзалтын үеэр санхүүгийн салбарт eKYC ашиглалтын талаар хууль хоорондын зөрчилдөөнтэй байдлаас үүдсэн ойлгомжгүй байдал үүсэж байгааг онцолсон. Жишээлбэл, *Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 7.1-р зүйлд “бичгээр, эсхүл цахимаар гэрээ байгуулсан данс нээсэн харилцагчид тухайн данстай холбоотой хадгаламж, шилжүүлэг, зээлийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлж болно” гэж заасан байдаг. Энэ заалт нь “өндөр эрсдэлтэй” ангилалд хамаарахгүй хэрэглэгчийн хувьд цахим данс нээх, гүйлгээ хийх боломжийг хууль ёсоор зөвшөөрч буйг илтгэнэ. Үүний эсрэгээр Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 5.2.1 дүгээр хэсэгт санхүүгийн байгууллагууд хэрэглэгчийг таньж, баталгаажуулах зорилгоор “овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр болон иргэний үнэмлэх эсвэл гадаад паспортын хуулбар гаргуулж авах” үүрэгтэй гэж заасан байдаг. Гэвч энэхүү шаардлага нь биечлэн KYC хийж буй үйл явцад хамаарах юм. Цаашилбал, 2024 оны 6 дугаар сарын 5-нд батлагдсан “Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль”-д, “нийтийн мэдээллийн дэд бүтэц”-ийг ашиглан хэрэглэгчийг таних боломжийг тодорхой тусгасан бөгөөд энэхүү дэд бүтэцэд цахим танилт (eKYC) зэрэг цахим таних системүүд хамаарна гэж заасан байдаг. Эдгээр хууль хоорондын ойлгомжгүй зохицуулалт нь санхүүгийн байгууллагуудыг eKYC үйл явцыг бүрэн нэвтрүүлэхээс болгоомжлоход хүргэж,*

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нийцэхгүй гэж ойлгогдохоос эмээж байна.

8.2 Санал болгож буй арга хэмжээ

СЗХ, Монголбанк болон хувийн хэвшлийн оролцогч талуудаас гаргасан санал, дүгнэлтийн үндсэн дээр eKYC үйл явцыг илүү өргөн хүрээнд нэвтрүүлэх, байгууллагуудын итгэлийг нэмэгдүүлэх зорилгоор дараах хоёр арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг санал болгож байна. (Хэрэгжүүлэхийг санал болгож буй дараалал):

- (i) eKYC-ийн шаардлагыг тодорхой тусгасан удирдамж боловсруулах;
- (ii) Хялбаршуулсан хянан шалгах (due diligence) тогтолцооны зохицуулалт нэвтрүүлэх, мөн МУТСТ хуулийн хүрээнд биечлэн хийдэг KYC үйл явцын хэрэглээг тодорхой болгох.

8.2.1 Арга хэмжээ 6.1: eKYC-ын шаардлагыг тодорхойлсон удирдамжтай болох

Хүснэгт 30: Арга хэмжээ 6.1-ийн хураангуй

Зорилт	eKYC хүчин төгөлдөр байдлыг хангах хамгийн бага шалгуур, стандартыг заасан, тодорхой бүтэцтэй удирдамж боловсруулах, ингэснээр байгууллагуудад eKYC шийдлийн нэвтрэлтийг нэмэгдүүлнэ.
Тайлбар	Санхүүгийн байгууллага хувь хүн болон хуулийн этгээдийг харилцаа үүсгэхийн тулд eKYC-ийг хэрэгжүүлэхдээ дагаж мөрдөх ёстой наад захын шаардлага, стандартыг тодорхойлсон тусгай удирдамжийг танилцуулах, үүнд өндөр эрсдэлтэй бүтээгдэхүүн санал болгодог санхүүгийн байгууллагуудын хэрэгжүүлэх eKYC-ийн хамгаалалтууд болон тайлагнах шаардлага багтана. Ийм удирдамжид гурван давхар баталгаажуулалтын үйл явцыг хангах шаардлага, eKYC үйл явцад ашиглаж болох технологийн нэмэлт үзүүлэлтүүдийг багтаана.
Хэрэгжилтийг хангах субъект	Монголын Финтек Ажлын хэсэг (МФАХ)
Оролцогч талууд	Монголбанкны Санхүүгийн мэдээллийн алба, ЦХИХХЯ-ны Хүний хувийн мэдээлэл хамгаалах газар
Алхмууд	Санал болгож буй дараах алхмуудыг хэрэгжүүлэх боломжтой: <ol style="list-style-type: none"> МФАХ нь Монгол банкны Санхүүгийн мэдээллийн алба (СМА) болон ЦХИХХЯамны харьяа Хүний хувийн мэдээлэл хамгаалах газартай хамтран санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад зориулсан eKYC үйл явцыг хэрэгжүүлэх тусгай удирдамж боловсруулж гаргах шаардлагатай. eKYC-ийн тодорхой, ойлгомжтой удирдамж боловсруулснаар санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдийн дунд эрх зүйн тодорхой байдлыг нэмэгдүүлж, Монгол Улсад цахим гүйлгээний шилжилтийг хурдасгах чухал алхам болно. Монгол Улс уг удирдамжийг боловсруулахдаа Малайзын Төв банкнаас гаргасан eKYC бодлогын баримт бичгийг (Хүснэгт 31-д дурдсан) жишиг болгон авч үзэх боломжтой. Уг баримт бичигт иргэн болон хуулийн этгээдийг цахим аргаар бүртгэхэд санхүүгийн байгууллагуудын заавал хангах хамгийн бага шаардлага болон стандартыг тодорхой заасан байдаг. Үүнд: (a) Иргэний үнэмлэхийн

баталгаажуулалт зэрэг баримт бичгийн шалгалт; (б) Хувийн мэдээллийг баталгаажуулах биометрик танилт; (в) Луйвраас сэргийлэх “амьд байдал”-ыг илрүүлэх технологи (liveness detection). Мөн, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд нь ашиглаж буй eKYC технологио найдвартай, хараат бус, бие даасан үнэлгээний байгууллагаар үнэлүүлсэн байх ёстой. eKYC-ийн зохицуулалт нь мөн одоо хүчин төгөлдөр үйлчилж буй санхүүгийн хууль тогтоомжтой, ялангуяа, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль (Монголбанкны СМА), Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль (ЦХИХХЯ-ны Хүний хувийн мэдээлэл хамгаалах газар)-тай уялдаатай байх шаардлагатай. Ингэснээр хуулийн нийцэл болон мэдээллийн аюулгүй байдлыг хангах боломжтой.

Хүснэгт 31: Арга хэмжээ 5.1-тэй холбоотой сайн туршлага

Байршил	Тодорхойлолт	Монгол улсад хэрэгжүүлж болох гол шийдлүүд
Малайз	<p>Малайзын Цахим “Харилцагчийг таньж мэдэх” (eKYC) бодлогын баримт бичиг⁶⁵</p> <p>Малайзын Цахим “Харилцагчийг таньж мэдэх” (eKYC) бодлогын баримт бичиг нь иргэн болон хуулийн этгээдийг бүртгэх явцад санхүүгийн байгууллагууд заавал мөрдөх ёстой хамгийн бага шаардлага болон стандартыг тодорхойлдог. Холбогдох хэсгүүдэд дараах зүйлс багтана:</p> <ul style="list-style-type: none"> ● 8.10 дугаар хэсэгт санхүүгийн байгууллагууд иргэдэд зориулсан eKYC үйл явцыг хэрхэн хэрэгжүүлэх талаар удирдамж өгсөн бөгөөд eKYC-ийн хүрээнд иргэнийг таних, баталгаажуулах үйл ажиллагаа зайлшгүй шаардлагатай бөгөөд дараах (гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй) арга хэмжээг авч хэрэгжүүлж болно гэж заасан. Үүнд: <ul style="list-style-type: none"> ○ Баримт бичгийн баталгаажуулалт – төрөөс олгосон иргэний үнэмлэхийг жинхэнэ эсэхийг шалгахын тулд зохих луйврыг илрүүлэх механизм ашиглан баталгаажуулах; ○ Биометр тохиролт – Биометрийн технологи ашиглан хэрэглэгчийг төрөөс олгосон үнэмлэхтэй нь тулган шалгах; ○ “Амьд байдал” илрүүлэх (Liveness detection) – Хэрэглэгчийг бодит хүн мөн эсэх, хуурамч этгээд биш болохыг баталгаажуулах. ● 8.22 дугаар хэсэгт eKYC шийдлүүдэд тавигдах шаардлагыг тодорхойлсон бөгөөд, хэрэв eKYC шийдлийг ашиглаж байгаа тохиолдолд дараах шаардлагуудыг хангасан байх ёстой гэж заасан. Үүнд: 	<p>ЦХИХХЯ нь eKYC үйл явцыг хууль ёсны, хүчин төгөлдөр гэж үзэхэд тавигдах нарийвчилсан хамгийн бага шаардлагуудыг тодорхойлохдоо Малайзын eKYC бодлогын баримт бичгийг жишиг болгон авч үзэх боломжтой.</p>

⁶⁵ Малайзын Төв банк (BNM) (2024). Цахим “Мэдэх-Харилцагч” (eKYC) бодлогын баримт бичиг. Эндээс үзнэ үү: <https://www.bnm.gov.my/documents/20124/938039/pd-e-KYC-apr2024.pdf?pr>

Байршил	Тодорхойлолт	Монгол улсад хэрэгжүүлж болох гол шийдлүүд
	<ul style="list-style-type: none"> ○ еKYC шийдэл нь дараах гурван үндсэн бүрэлдэхүүн модулийг агуулсан байх шаардлагатай. баримт бичгийн баталгаажуулалт, биометрийн тохиролт, “амьд байдал” илрүүлэх нь еKYC бодлогын баримт бичгийн Хавсралт 3-т заасан хүрээнд, хараат бус, найдвартай гуравдагч этгээдээр үнэлгээ хийлгэх шаардлагатай. ○ еKYC-ийн модулиудад холбогдох гэрчилгээжүүлэлт боломжтой бол, тухайн модулиудыг хариуцсан байгууллага нь зохих гэрчилгээ, баталгаажуулалтыг авсан байх ёстой. ● 8.19 дүгээр хэсэг нь хиймэл оюун ухаан болон машин сургалт зэрэг технологийг ашиглан хэрэглэгчийг үнэн зөвөөр таних, баталгаажуулах үйл явцыг хэрэгжүүлэхийг зөвшөөрдөг. ● 8.21 дүгээр хэсэгт байгууллагууд еKYC шийдлийнхээ нарийвчлалыг хангах үүднээс “Хуурамч хүлээн зөвшөөрөлтийн түвшин” (False Acceptance Rate, FAR)-ийг хянах шаардлагатай гэж заасан. FAR нь дараах томъёогоор тодорхойлогдоно: $FAR = \frac{\text{хуурамч эерэг}}{\text{хуурамч эерэг} + \text{үнэн сөрөг}} \times 100.$ 	

8.2.2 Арга хэмжээ 6.2: Хялбаршуулсан хянан шалгах тогтолцооны зохицуулалтыг нэвтрүүлэх, мөн МУТСТгХ-д биечлэн хийх KYC үйл явцын хэрэглээг тодорхой болгох

Хүснэгт 32: Арга хэмжээ 6.2-ын хураангуй

Зорилт	еKYC үйл явцыг үр ашигтай хэрэгжүүлэх, өргөн хүрээнд нэвтрүүлэхийн тулд холбогдох хууль, тогтоомжийг шинэчлэн боловсруулж, биечлэн хийх харилцагчийг таньж мэдэх (ХТМ) шаардлагыг нэг мөр болгох, мөн хялбаршуулсан хянан шалгах зохицуулалтыг нэвтрүүлэх шаардлагатай.
Тайлбар	<p>Биечлэн хийдэг болон цахим KYC-ийн хэрэглээтэй холбоотой ойлгомжгүй байдал, зөрчлийг арилгах, уялдаа холбоог сайжруулахын тулд Монгол Улс Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, баримт бичгийг эх хувилбартай тулгаж шалгах шаардлага нь зөвхөн биечлэн хийж буй ХТМ үйл явцад хамаарах болохыг тодорхой заах боломжтой.</p> <p>Дээрх зохицуулалтаас гадна, бага эрсдэлтэй гүйлгээнд еKYC ашиглах боломжийг дэмжих зорилгоор хялбаршуулсан хянан шалгалтын (simplified due diligence) зохицуулалтын хүрээ боловсруулбал, финтек инновацийн хөгжилд түлхэц өгөх боломжтой. Ийм хүрээ нь еKYC үйл явцыг илүү өргөн хүрээнд нэвтрүүлэхэд хувь нэмэр оруулж, зөвхөн банкнуудаар</p>

	хязгаарлагдахгүйгээр шинээр зах зээлд нэвтэрч буй тоглогчид болон апп-д суурилсан санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдэд ч хялбар, хямд зардалтай, бага эрсдэлтэй цахим шийдлүүдийг санал болгох нөхцөлийг бүрдүүлнэ.
Хэрэгжилтийг хангах субъект	Монголбанкны Санхүүгийн Мэдээллийн алба
Алхмууд	<p>Хэрэгжүүлэх шаардлагатай алхмууд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 5.2.1 дүгээр заалтыг өөрчлөн найруулж, баримт бичгийг тулган шалгах шаардлага нь зөвхөн биечлэн (in-person) хийж буй ХТМ үйл ажиллагаанд хамаарна гэдгийг тодорхой тусгах шаардлагатай. Одоогийн байдлаар хуулийн 5.2 дугаар зүйлд зааснаар, энэ хуулийн 4.1 дүгээр зүйлд заасан этгээдүүд (санхүүгийн байгууллагууд) хэрэглэгчийн хэн болохыг тогтоох, баталгаажуулах зорилгоор баримт бичгийн эх хувийг тулган шалгах үүрэгтэй гэж заасан байдаг. Тодруулбал, 5.2.1 дэх заалтад хэрэглэгчийг таньж, баталгаажуулах зорилгоор санхүүгийн байгууллагууд “овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр болон иргэний үнэмлэх эсвэл гадаад паспортын хуулбар гаргуулж авах” үүрэгтэй гэж заасан байдаг. Дараа нь эрх бүхий этгээд баримт бичгийг эх хувилбартай нь тулгаж, жинхэнэ эсэхийг шалган бүртгэх үүрэгтэй. Хэрэв баримт бичгийг шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбарыг гаргуулж авах шаардлагатай. Энэ шаардлага нь зарим байгууллагуудад биетээр КҮС шалгах нь дурдагдаагүй байсан ч заавал шаардлагатай хэмээх ойлголт төрүүлэх болзошгүй юм. 2024 оны 6 дугаар сарын 5-нд батлагдсан Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуульд⁶⁶ зааснаар хэрэглэгчийг “нийтийн мэдээллийн дэд бүтэц” ашиглан таних боломжийг хуулиар зөвшөөрсөн.⁶⁷ Уг “нийтийн мэдээллийн дэд бүтэц”-д eKYC зэрэг цахим танилт, баталгаажуулалтын системүүд хамаарахыг тусгайлан заасан байдаг. Иймд хууль хоорондын зөрчил болон ойлгомжгүй байдлыг арилгах үүднээс, 5.2.1 дэх заалтад өөрчлөлт оруулж, иргэний үнэмлэх эсвэл гадаад паспортын хуулбар нь зөвхөн “биечлэн ирсэн” буюу in-person ХТМ-д шаардлагатай гэдгийг тодорхой заах шаардлагатай байна 2. Эрсдэл багатай гүйлгээг “хялбаршуулсан хянан шалгалт”-д хамруулах боломжтой эсэхийг тодорхойлох зорилгоор холбогдох байгууллагуудтай оролцогч талуудын зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулах шаардлагатай. Монголбанкны зүгээс холбогдох оролцогч талууд болох салбарын оролцогчид, СМА, СЗХ-ны хянан шалгагч нартай хамтран “хялбаршуулсан хянан шалгалт”-д хамаарах эрсдэл багатай үйл ажиллагааны жагсаалт бүхий хүснэгт боловсруулах нь зүйтэй. Харилцагчийг таньж мэдэх (CDD) үйл явцыг хөнгөвчилсөн байдлаар хэрэгжүүлэх боломжтой нөхцөл байдалд дараах жишээг дурдаж болно: (1) Банк нь тухайн харилцагчийн

⁶⁶Легал инфо (2023). Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль. Эндээс үзнэ үү: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17141128575401&showType=1>

⁶⁷ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлд “Нийтийн мэдээллийн дэд бүтэц” гэж мэдээллийн систем, мэдээллийн сүлжээ, санхүүгийн үйлчилгээг үзүүлэгч байгууллагуудын ашигладаг нийтийн мэдээллийн сан жишээлбэл ХҮР, ДАН, И-Монголиа зэргээс бүрдэнэ. Эндээс үзнэ үү: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390263044601>

талаар найдвартай мэдээлэлд нээлттэй эх сурвалжаар дамжуулан хандах боломжтой байх; (2) тухайн банк өмнө нь хамтран ажиллаж байсан, мөн МУТС хяналтын тогтолцоог нь сайн мэддэг өөр банк эсхүл санхүүгийн байгууллагатай харьцаж байгаа тохиолдол.

Мөн үүнтэй зэрэгцэн, хялбаршуулсан CDD арга хэмжээг авахыг хориглох нөхцөлүүдийг ч тодорхой заах шаардлагатай. Үүнд: МУТС зохицуулалт хангалтгүй, өндөр эрсдэлтэй гэж хүлээн зөвшөөрөгдсөн улс, бүс нутагт харьяалагдах харилцагч; Банк нь тухайн гүйлгээтэй холбогдуулан мөнгө угаах эсвэл терроризмыг санхүүжүүлэх эрсдэлтэй гэж сэжиглэж буй тохиолдол; Улс төрийн нөлөө бүхий этгээд (PEP); Бусад өндөр эрсдэлтэй ангилалд багтах этгээд. (Сингапурын “бусад өндөр эрсдэлтэй ангиллын” тодорхойлолтыг Хүснэгт 33-т харна уу.)

3. **Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд биечлэн бус харилцаанд (non-face-to-face) хэрэглэгдэх CDD арга хэмжээнд тавигдах хамгийн бага шаардлагыг тодорхой тусгах шаардлагатай.** Бизнесийн харилцаа тогтоох үед биечлэн уулзах боломжгүй нөхцөлд үүсэх эрсдэлийг бууруулах зорилгоор дараах арга хэмжээнүүдийн аль нэгийг буюу хэд хэдийг зэрэг авч хэрэгжүүлэх нь зүйтэй. Үүнд: (а) хэрэглэгчтэй гэрийн эсвэл ажил хэргийн дугаарт холбогдох, уг дугаарыг бие даан баталгаажуулсан байх; (б) хэрэглэгчийн хаягийг харилцаа холбоо эсвэл өөр тохиромжтой аргаар баталгаажуулах; (в) хэрэглэгчийн ажил эрхэлж буй эсэхийг ажил олгогчийн хүний нөөцийн албаар дамжуулан, байгууллагын бүртгэлтэй утсаар баталгаажуулах; (г) хэрэглэгчийн цалингийн мэдээллийг өөр банкны сүүлийн үеийн дансны хуулга ирүүлэх замаар шалгах; (д) нотариат эсвэл хуульчийн баталгаажуулсан үнэмлэх бичиг баримт хэрэглэгчээр гаргуулан ирүүлэх; (е) банк өөрийн биечлэн бус үйлчилгээнд хэрэглэдэг, найдвартай шалгалтын бусад арга хэмжээг хэрэгжүүлэх. Монгол Улс эдгээр зохицуулалтыг боловсруулж хэрэгжүүлэхдээ Сингапур зэрэг бусад улсын туршлагыг жишиг болгон авч үзэх боломжтой. (Дэлгэрэнгүйг Хүснэгт 33-д үзүүлэв).⁶⁸

4. **Бага эрсдэлтэй гүйлгээний хувьд хялбаршуулсан хянан шалгалт хэрэглэхийг зөвшөөрсөн зохицуулалтыг тусгах зорилгоор холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай.** Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд “хялбаршуулсан хянан шалгалт”-ын тухай тусгай заалт нэмэх боломжтой. Уг заалтад банкууд харилцагчийг МУТС эрсдэл багатай гэж үзсэн тохиолдолд хялбаршуулсан хянан шалгалтын арга хэмжээ (үүнд биечлэн бус шалгалт болон eKYC багтана) хэрэглэхийг зөвшөөрөх зохицуулалтыг тусгах нь зүйтэй. Гэхдээ хялбаршуулсан хянан шалгалт хэрэглэхийн өмнө тухайн харилцагчийн болон гүйлгээний эрсдэлийг нарийвчлан үнэлсэн байх шаардлагатай.

⁶⁸Сингапурын Санхүүгийн Зохицуулах Хороо (MAS) (2022). биечлэн бус харилцаанд хэрэглэгдэх Due Diligence-ийн хэмжүүр. эндээс үзнэ үү: <https://www.mas.gov.sg/-/media/mas-media-library/regulation/circulars/amld/circular---non-face-to-face-customer-due-diligence-measures-1.pdf>

Хүснэгт 33: Арга хэмжээ 6.2-тай хамаатай сайн туршлага

Байршил	Тодорхойлолт	Монгол улсад хэрэгжүүлж болох гол шийдлүүд
Сингапур	<p>Сингапурын Мөнгөний удирдах газар (MAS)-ын “626 дугаар мэдэгдэл”-ийн хавсралт удирдамж: Мөнгө угаахаас урьдчилан сэргийлэх болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай⁶⁹</p> <p>Сингапурын Мөнгөний удирдах газрын 626 дугаар мэдэгдлийн 4.25–4.27 дугаар догол мөрт биечлэн бус танилт, баталгаажуулалтын талаар дурдсан бөгөөд банкууд хэрэглэгчтэй биечлэн уулзахгүйгээр бизнесийн харилцаа тогтоох, санхүүгийн үйлчилгээ үзүүлэх тохиолдолд зохих эрсдэлийг бууруулах арга хэмжээг авах шаардлагатай гэж заасан байдаг. Уг мэдэгдэлд цахим баталгаажуулалтын дараах хүлээн зөвшөөрөгдөх аргууд дурдагдсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ● Харилцагчтай гэрийн эсвэл бүртгэлтэй ажлын дугаараар холбогдож, тухайн дугаарыг бие даан баталгаажуулах; ● Харилцагчийн хаягийг харилцаа холбоо эсвэл цахим харилцаагаар баталгаажуулах; ● Мэргэжлийн этгээд (жишээлбэл, хуульч, нотариат)-ээр цахим баримт бичгийг баталгаажуулах; ● Бусад банкин дахь хэрэглэгчийн нэр дээрх данснаас анхны шилжүүлэг хийлгэх. 	<p>МУТС хуулийг өргөн хүрээтэй дижитал шилжилтийн чиг хандлагатай уялдуулах зорилгоор шаардлагатай заалтуудыг нэмж тусгах шаардлагатай.</p>
Сингапур	<p>Сингапурын Мөнгөний удирдах газрын 626 дугаар мэдэгдлийн удирдамж – Бусад өндөр эрсдэлтэй ангиллууд⁷⁰</p> <p>6.3 дугаар зүйлд улс төрийн нөлөө бүхий этгээдээс (PEP) гадна, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх өндөр эрсдэлтэй гэж үзэж болох бусад хэрэглэгчийн ангилалд ч нарийвчилсан харилцагчийг таньж мэдэх арга хэмжээг хэрэгжүүлэхийг банкнуудаас шаардсан. Ийм нарийвчилсан арга хэмжээ авах шаардлага нь тухайн банкны мөнгө угаалт болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой тухайн гүйлгээний эрсдэлийн хараат бус үнэлгээнд үндэслэж байж болно. Үүнд харилцагчийн төрөл (жишээ нь: өндөр бэлэн мөнгөтэй үйл ажиллагаа эрхлэгч, гадаад иргэн гэх мэт); Харилцагчийн худалдан авч буй бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл; Харилцагчийн үйл ажиллагаа явуулдаг газар зүйн бүс нутгийн эрсдэл зэрэг хүчин зүйлсийг харгалзах боломжтой.</p> <p>Мөн банк нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зохицуулалт сул орнуудын иргэн</p>	<p>Хялбаршуулсан хянан шалгалт (eKYC) хэрэглэхийг зөвшөөрөхгүй өндөр эрсдэлтэй бүс нутгийг тодорхойлохдоо Сингапурын Мөнгөний удирдах газрын 626 дугаар мэдэгдлийн удирдамжийг эш татан ашиглах боломжтой.</p>

⁶⁹Сингапурын Санхүүгийн Зохицуулах Хороо (MAS) (n.d.). Сингапурын Санхүүгийн Зохицуулах Хороо (MAS)-ны 626 дугаар мэдэгдлийн удирдамж – Бусад өндөр эрсдэлтэй ангиллууд. Эндээс үзнэ үү: https://www.mas.gov.sg/-/media/mas/resource/legislation_guidelines/aml/626-banks_gco-vetted.pdf?sc_lang=en&hash=9A20F729EFA686BF60FC4DA0EAD3059E

⁷⁰Сингапурын Мөнгөний удирдах газар (MAS) (n.d.). Сингапурын MAS-ны 626 дугаар мэдэгдлийн удирдамж – Бусад өндөр эрсдэлтэй ангиллууд. Эндээс үзнэ үү: https://www.mas.gov.sg/-/media/mas/resource/legislation_guidelines/aml/626-banks_gco-vetted.pdf?sc_lang=en&hash=9A20F729EFA686BF60FC4DA0EAD3059E

Байршил	Тодорхойлолт	Монгол улсад хэрэгжүүлж болох гол шийдлүүд
	<p>эсвэл тухайн улс оронд байрлаж буй этгээдтэй тогтоосон бизнесийн харилцаа болон гүйлгээнд онцгой анхаарал хандуулах үүрэгтэй.</p> <p>Энэ нь зохицуулагч байгууллагаас өгсөн заалт болон банкны өөрийн үнэлгээний үндсэн дээр байж болно.</p>	

9. Сэндбоксын зохицуулалтын хэрэгжилтийг бэхжүүлэх

Туршилт, инновацийг дэмжсэн орчныг бүрдүүлэхийн тулд Сэндбоксын алба нь шинэ оролцогчдод туршилт хийх боломж олгох, салбарт нэвтрэхэд нь чиглүүлэн дэмжихэд шаардлагатай нөөц, эрх мэдлээр хангагдсан байх ёстой. Үүнд хүрэхийн тулд зарим арга хэмжээг санал болгож байгаа нь Сэндбоксын хүсэлт гаргагчдыг оруулах эсэх шийдвэрийг уян хатан гаргахтай холбоотой удирдамжаар хангах, Сэндбоксоос гарсан бодлогын сургамжуудыг нэгтгэх, Сэндбоксоос гарах зохицуулалтыг тодорхой болгох зэрэг багтана.

9.1 Одоогийн нөхцөл байдал болон тулгамдаж буй асуудлууд

Сэндбокс зохицуулалтын орчны журамд нь одоогоор зохицуулагч байгууллагад сэндбокст хамрагдах хүсэлт гаргагчдын хэрэгцээнд нийцүүлэн техникийн болон захиргааны шаардлагыг өөрчлөх эрх мэдлийг олгоогүй байна. Энэ нь финтек компаниудыг сэндбокст бүртгүүлэх сонирхлыг бууруулж, байгууллагууд туршилт хийх, зохицуулагчид шинэ бүтээгдэхүүн, бизнес загваруудын талаар суралцах боломжийг олгох сэндбоксын үр нөлөөг сулруулан, зохистой зохицуулалтын хүрээ хөгжих боломжийг алдагдуулах эрсдэлтэй юм. Энэ хүрээнд анхаарах гол асуудлууд нь:

- **Сэндбокст орох шаардлагыг тохируулах боломжтой эсэх тодорхойгүй байна.** Салбарын оролцогчид сэндбокст орох шаардлагууд нь төвөгтэй санагддаг, өргөдөл гаргагчид шаардлагыг хангахад хүндрэлтэй байдаг гэдгийг илэрхийлсэн. Хэдийгээр зохицуулагчид тодорхой нөхцөлд зарим шаардлагыг чөлөөлж болохыг мэдэгдсэн ч хууль тогтоомжид тусгагдсан шаардлагууд нь оролцогчдын идэвхийг бууруулах эрсдэлтэй хэвээр байна. Жишээлбэл, Сэндбокс зохицуулалтын орчны журамд заасны дагуу өргөдөл гаргагчид нь Tier 2 стандартын мэдээллийн төвд системээ байрлуулах, хэрэглэгчийн өгөгдөлд шифрлэлтийн арга хэмжээг хэрэгжүүлэх зэрэг техникийн шаардлагыг өмнө нь хангах шаардлага тавигдсан хэвээр байна.⁷¹
- **Сэндбоксын сургамж, үр дүнг бодлогын түвшинд тусгах тодорхой механизмгүй байна.** Сэндбокс зөвлөлийн гол үүрэгт сэндбокст оролцогчдын зах зээлд нэвтрэхэд шаардлагатай зохицуулалт, заавар, зөвлөмжийг боловсруулах санал дэвшүүлэх, мөн сэндбокс хөтөлбөрөөс гарсан гол сургамжуудыг нэгтгэн дүгнэх зэрэг багтдаг. Гэвч өнөөгийн байдлаар сэндбоксоос гарсан үр дүн, дүгнэлтийг бодлого, зохицуулалтад тусгах тогтсон журам, хариуцлагын тогтолцоо бүрдээгүй байна. Энэ зөрүү нь сэндбоксыг санал, туршлага цуглуулах үр дүнтэй механизм болгох боломжийг хязгаарлаж, финтект хамаарах зохицуулалтыг сайжруулах бололцоог бууруулж байна.
- **Сэндбоксоос гарсны дараах нөхцөл байдал тодорхойгүй.** Сэндбоксоос гарах эсвэл сэндбоксын хугацаа дууссаны дараа, компаниуд гарах арга нь тодорхойгүй байдаг. Ялангуяа одоогийн тусгай зөвшөөрөлд хамаарахгүй шинэ бизнес загвартай компаниудын хувьд, сэндбоксын дараах зах зээлд нэвтрэх, оролцох үйл явц хэрхэн өрнөх нь тодорхой бус байна.

⁷¹ Санхүүгийн Зохицуулах хороо (2021), Сэндбокс зохицуулалтын орчны журам, Эндээс үзнэ үү: <http://www.frc.mn/resource/frc/Document/2023/01/10/c0zsjpdkfjvfy3/Regulation%20on%20Sandbox%20Environment.pdf>

9.2 Санал болгож буй арга хэмжээ

СЗХ, МБ-ны оролцогч талууд болон салбарын оролцогчдоос авсан саналын үндсэн дээр сэндрбоксын зохицуулалт, үйл явцыг илүү тодорхой болгохын тулд дараах гурван үйл ажиллагааг (хэрэгжүүлэх дарааллын дагуу) санал болгож байна:

- (i) Сэндрбоксоос гарсан сургамжийг бодлого, зохицуулалтад тусгахыг үйл явцыг сайжруулах;
- (ii) Сэндрбокст өргөдөл гаргахад уян хатан байдлаар хүлээн авах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх;
- (iii) Сэндрбоксоос гарах арга замыг тодорхой болгох.

9.2.1 Арга хэмжээ 7.1: Сэндрбоксоос гарсан сургамжийг бодлого, зохицуулалтад тусгахыг анхаарч хэрэгжүүлэх

Хүснэгт 34: Арга хэмжээ 7.1-ийн хураангуй

Зорилт	Монгол Улсын санхүүгийн салбарын бодлого, зохицуулалтыг хөгжүүлэхэд Сэндрбоксын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх зорилгоор, сэндрбоксоос гарсан дүгнэлт, сургамжийг бодлогод тусгах тогтсон институцийн үйл явцыг хөгжүүлэх.
Тайлбар	<p>Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд Сэндрбоксын алба нь бодлогын санал боловсруулж, түүнийг Засгийн газарт танилцуулан бодлого боловсруулах үйл явцад ашиглах шаардлагатай.</p> <p>Хариуцлагын түвшинг нэмэгдүүлэхийн тулд Сэндрбоксын зөвлөл нь СЗХ-ны жилийн тайланд өөрсдийн албан ёсны тайланг нийтэлдэг байх хэрэгтэй. Мөн Засгийн газарт гаргасан санал, зөвлөмжүүдийг олон нийтэд нээлттэй байлгах хэрэгтэй. Энэ нь Зөвлөлийн сэндрбоксын үр нөлөөг бэхжүүлэх үүргээ хэрэгжүүлж буй байдлыг үнэлэх, хянахад дэмжлэг үзүүлнэ.</p>
Хэрэгжилтийг хангах субъект	Сэндрбоксын зөвлөл
Оролцогч талууд	СЗХ Сэндрбоксын алба, МУ-ын Их Хурлын гишүүд
Алхмууд	<p>Дараах алхмуудыг хэрэгжүүлэх хэрэгтэй:</p> <ol style="list-style-type: none"> 1. Сэндрбоксын алба сэндрбоксоос гарсан үр дүн, сургамжид үндэслэн бодлого боловсруулах үүргийг хариуцуулна. Сэндрбоксын алба нь бодлого боловсруулахдаа сэндрбоксоод үйл ажиллагаа явуулж байгаа финтек компаниудаас цуглуулсан мэдээлэл, мөн ижил бизнесийн загваруудыг бусад улс орнууд хэрхэн зохицуулж байгаа талаар хийсэн судалгаанд үндэслэн боловсруулж болно. Эдгээр санал, зөвлөмжид шинэ зохицуулалт шаардлагатай байгаа чиглэлүүд, мөн бодлогын өөрчлөлт хийснээр финтек салбарын өсөлтөд дэмжлэг үзүүлэх боломжтой чиглэлүүдийг хамарна. Нэгтгэн боловсруулсан эдгээр санал, дүгнэлтийг санаачлагч талуудад — тухайлбал, Улсын Их Хурлын гишүүд, Засгийн газар болон Монгол Улсын Үндсэн хуулийн 26.1-д заасан бусад этгээдэд хүргүүлэх боломжтой. 2. Сэндрбоксын албаны хүний нөөц, чадавхыг бэхжүүлэх. СЗХ-ны Сэндрбоксын алба нь сэндрбоксын оролцогчидтой үр дүнтэй хамтран ажиллах, дэлхийн сайн туршлагыг судлахад шаардлагатай хүний

нөөцөөр бүрэн хангагдсан байх ёстой. Үүний тулд Сэндбоксын албаны одоогийн чадамж болон ирээдүйд нэмэгдэх ажлын ачааллыг тодорхойлох дүн шинжилгээг хийж, ажилчид нэмэх шаардлагатай эсэхийг тодорхойлох хэрэгтэй. Хэрэв шаардлагатай бол ажилчдын ур чадварыг нэмэгдүүлэх (чадавхжуулах) сургалт, арга хэмжээг зохион байгуулах хэрэгтэй.

3. **Сэндбоксын албаны үйл ажиллагааны тайланг СЗХ-ны жилийн тайлангийн нэг хэсэг болгон олон нийтэд нээлттэй нийтлэх.** Жилийн тайланд сэндбокст хүлээн авсан оролцогчдын тоо, гарсан оролцогчдын тоо, СЗХ-оос олгосон тусгай зөвшөөрлийн тоо зэрэг мэдээллийг тусгах бөгөөд Сэндбоксын зөвлөлийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн зохицуулалтын шинэчлэлийн хөшүүргүүдийг онцлон харуулах ёстой.

Хүснэгт 35: Арга хэмжээ 7.1-тэй холбоотой сайн туршлага

Байршил	Тодорхойлолт	Монгол улсад хэрэгжүүлж болох гол шийдлүүд
Кени	<p>Кени улсын Хөрөнгийн зах зээлийн зохицуулах байгууллага (СМА)⁷²</p> <p>Кени улсын зохицуулалтын сэндбокст туршилтын хүрээнд, СМА нь оролцогчдод хоёр төрлийн боломжийг олгосон. Үүнд одоогийн зохицуулалтын хүрээнд үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, Зохицуулалтыг шинэчлэх хүртэл хязгаарлагдмал хүрээнд үйл ажиллагаа явуулах боломж олгох юм.</p> <p>СМА нь шинэ бизнес загваруудтай холбоотой зохицуулалтыг боловсруулахдаа сэндбоксын оролцогчидтой ойр ажилладаг. Жишээ нь: Pezesha нэртэй компани жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулсан олон нийтийн санхүүжилтийн платформыг сэндбоксоор дамжуулан туршсан. СМА нь Pezesha-ийн туршилтаас гарсан үр дүнг ашиглан Кени улсад олон нийтийн санхүүжилтийн талаарх заавар, журам боловсруулж, тухайн бизнес загварт нийцүүлэн зохицуулалтаа шинэчилсэн.</p>	<p>СЗХ нь Кени улсын Хөрөнгийн Зах Зээлийн Зохицуулах Байгууллагаас жишээ авч, оролцогч компаниудтай хамтран ажиллаж, зохицуулалтаа цаг тухайд нь шинэчилж байсан туршлагыг хэрэгжүүлэх боломжтой.</p>
Саудын Араб	<p>Саудын Арабын Санхүүгийн салбарыг хөгжүүлэх хөтөлбөрийн жилийн тайлан⁷³</p> <p>Саудын Араб Алсын хараа 2030 хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй гол санаачилга болох Санхүүгийн салбарыг хөгжүүлэх хөтөлбөр нь эдийн засгийн өсөлтийг дэмжих төрөлжсөн,</p>	<p>СЗХ нь Сэндбоксын тайлагналын ил тод байдлыг сайжруулах үүднээс санхүүгийн салбарын жилийн тайлан хэрхэн гарч байгааг харгалзан үзэж, өөрийн жилийн тайланг</p>

⁷² Дэлхийн банк (2020). Зохицуулалтын Сэндбокст дэлхийн туршлага, эндээс үзнэ үү:

<https://documents1.worldbank.org/curated/en/912001605241080935/pdf/Global-Experiences-from-Regulatory-Sandboxes.pdf>

⁷³ Саудын Арабын Сангийн яам (MFSА) (n.d.). Санхүүгийн салбарыг хөгжүүлэх хөтөлбөр. эндээс үзнэ үү:

https://www.mof.gov.sa/en/about/Pages/Development_Program.aspx

	<p>үр ашигтай санхүүгийн салбарыг бий болгохыг зорьдог. Жилийн тайланд финтекийн хөгжил, хөрөнгийн зах зээлийн дэвшлээс гадна зохицуулалтын сэндрокс хөтөлбөрийн талаарх мэдээлэл бас багтдаг. Мэдээлэлд жил бүр сэндрокст хүлээн авсан компаниудын тоо, Сэндроксоор дамжуулан дэмжигдсэн гол финтек инноваци, онцлох санаанууд зэрэг статистик мэдээлэл нийтлэгддэг.</p>	<p>боловсруулахдаа ашиглах боломжтой.</p>
--	---	--

9.2.2 Арга хэмжээ 7.2: Сэндроксоод хүсэлт гаргагчдыг уян хатан байдлаар хүлээн авах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх

Хүснэгт 36: Арга хэмжээ 7.2-ын хураангуй

Зорилт	<p>Сэндрокс зохицуулалтын орчны журамд тусгагдсан техникийн шаардлагыг хангах чадамжгүй байж болзошгүй жижиг хэмжээний компани, эхний шатны старт-апуудыг дэмжихийн тулд Сэндроксын албаны чадамжийг нэмэгдүүлж, үүргийг нь бэхжүүлэх, үүний зэрэгцээ шаардлагатай хамгаалалтын зохицуулалтыг хадгалах.</p>
Тайлбар	<p>Одоогийн байдлаар Сэндрокс зохицуулалтын орчны журамд сэндрокст орох шаардлагыг хүсэлт гаргагчийн чадамж, хэмжээ, эрсдэлийн онцлогт нийцүүлэн тохируулах талаар ямар нэгэн эрх зүйн зохицуулалт тусгагдаагүй байна. Иймд Сэндроксын зөвлөл нь одоо мөрдөгдөж буй Сэндрокс зохицуулалтын орчны журмыг дэмжсэн, тодорхой техникийн шаардлагуудыг нэгдмэл байдлаар хэрэглэхээс чөлөөлөх боломжтой зохицуулалтын хүрээг боловсруулж, чиглэл болгох ёстой.</p>
Хэрэгжилтийг хангах субъект	<p>Сэндроксын зөвлөл</p>
Оролцогч талууд	<p>СЗХ-ны Сэндроксын алба</p>
Алхмууд	<p>Дараах алхмуудыг хэрэгжүүлэх хэрэгтэй:</p> <ol style="list-style-type: none"> 1. Сэндрокст орох шаардлагыг дахин хянаж үзэх: Одоогоор Сэндрокс зохицуулалтын орчны журмын 2.2 болон 4.4 дүгээр зүйлд зааснаар бүх сэндроксын оролцогчид хууль тогтоомжоор тогтоосон техникийн шаардлага болон бизнес төлөвлөгөөний шаардлагыг бүрэн хангах ёстой. Үүнд: эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө, санхүүгийн болон төлбөрийн чадвартай гэдгээ нотлох баримт, мөн өгөгдлийн стандарт болон сүлжээний аюулгүй байдлын тодорхой шаардлагуудыг дагаж мөрдөх зэрэг багтана. Эдгээр шаардлагууд дунд зарим нь хэт хатуу байж болзошгүй эсэхийг тодорхойлохын тулд өнгөрсөн, одоогийн болон ирээдүйн сэндроксын оролцогчидтой хамтран нарийвчилсан дүн шинжилгээ хийх шаардлагатай. Ингэснээр эрсдэл багатай финтек компаниудыг сэндроксын зохицуулалтад хамруулах боломжийг нэмэгдүүлж, зарим шаардлагыг чөлөөлөх нөхцөлийг бий болгох боломжтой болно. 2. Шалгалт, үнэлгээний үр дүнд үндэслэн сэндроксын алба нь сэндрокст орох шаардлагыг уян хатан болгоход удирдамж буюу зохицуулалтын хүрээг тогтооно. Сэндроксын оролцогчдыг

тохиолдол тус бүрээр үнэлэх боломжийг бүрдүүлэхийн тулд эрсдэлд суурилсан үнэлгээний хүрээ боловсруулж, ямар шаардлагыг чөлөөлж болох, аль нь зайлшгүй мөрдөх шаардлагатайг тодорхой ялгах хэрэгтэй. Эрсдэлийн удирдлага болон хэрэглэгчийг хамгаалахтай холбоотой шаардлагууд нь чөлөөлөх боломжгүй (non-waivable) байх ёстой. Харин дараах шаардлагуудыг тохиолдолд нь үндэслэн чөлөөлөх боломжтой гэж үзэж болно. Үүнд хүний нөөцийн доод шаардлага, хөрөнгийн хадгалалттай холбоотой шаардлага, технологийн эрсдэл, аутсорсингийн удирдлагатай холбоотой шаардлагууд багтана. Монгол Улс нь ийм төрлийн зохицуулалтын хүрээг хэрхэн боловсруулж болох талаар Сингапурын Зохицуулалтын сэндбоксын удирдамжийн 37-р хүснэгтийг жишээ болгон авч үзэх боломжтой.

Хүснэгт 37: Үйл ажиллагаа 7.2-т хамаарах сайн туршлагууд

Байршил	Тайлбар	Монгол улсад хэрэгжүүлж болох гол шийдлүүд
Тайландын Төв банк	<p>Тайландын Төв Банкны Сэндбоксын Зохицуулалтын Удирдамж⁷⁴</p> <p>Тайландын Төв Банкны сэндбоксын зохицуулалтын удирдамжид оролцогч этгээдийн ангиллаас хамаарсан өөр өөр шалгуур үзүүлэлтүүдтэй байдаг. Тухайн этгээд дараах ангилалд хуваадаг:</p> <ul style="list-style-type: none"> ● Финтек компани ● Санхүүгийн байгууллага ● Санхүүгийн бус байгууллага ● Технологийн үйлчилгээ үзүүлэгч ● Бусад холбогдох этгээд <p>Энэ ангилал нь тухайн санхүүгийн инновац ямар төрлийн сэндбокст хамрагдахыг тодорхойлно. Жишээлбэл, банк болон зохицуулалттай байгууллагуудын хувьд өргөдөл нь “Зохицуулалтын сэндбокст”-т⁷⁵ багтдаг бөгөөд дараах шаардлагууд тавигдана: (i) Мэдээллийн технологийн стандартуудыг мөрдөж буй эсэх; (ii) Бизнес, үйл ажиллагааны урсгалын тайлбар, (iii) Технологийн эрсдэл, үйл ажиллагааны эрсдэл зэрэг багтсан эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө; (iv) Хэрэглэгчийг хамгаалах арга хэмжээний тодорхойлолт.</p>	<p>СЗХ нь Сэндбокст ороорх шаардлагын хүрээ, удирдамждаа Тайландын Төв Банкны уян хатан, эрсдэлд суурилсан хандлагыг харгалзан үзэх боломжтой.</p>

⁷⁴ Тайландын Төв Банк (BOT) (2024). Тайландын Төв Банкны (BOT) Сэндбоксын Зохицуулалтын Удирдамж. Эндээс үзнэ үү: https://www.bot.or.th/content/dam/bot/financial-innovation/digital-finance/fintech/sandbox/UnofficialTranslation_RegulatorySandboxGuidelines.pdf

⁷⁵ “Зохицуулалтын сэндбокст” гэж Тайландын Төв Банкны (BOT) харьяанд хэрэгждэг туршилтын хүрээг хэлнэ. Энэхүү хүрээ нь санхүүгийн үйлчилгээг сайжруулах, шинэ технологийг нэвтрүүлэх, мөн BOT-ийн хяналт дор эрх олгогдсон үйлчилгээний хүрээнд шинэлэг санаачлагыг туршихад дэмжлэг үзүүлдэг. Энэ хүрээний зорилго нь Тайландын санхүүгийн салбарын үндсэн дэд бүтэц, төвлөрсөн стандарт болохуйц шинэчлэл, дэвшлийг бий болгоход оршино. Мөн зарим хууль, журамд зааснаар туршилтыг зөвхөн BOT-ийн зохицуулалтын сэндбоксын хүрээнд явуулахыг шаардсан байдаг. Эндээс үзнэ үү: https://www.bot.or.th/content/dam/bot/financial-innovation/digital-finance/fintech/sandbox/UnofficialTranslation_RegulatorySandboxGuidelines.pdf#page=4

	<p>Нөгөө талаас, “Зохицуулалтын сэндрокс”-т хамрагддаггүй боловч шинэ технологи турших зорилготой дижитал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч болон зарим финтек компаниуд нь зохицуулагч байгууллагуудтай ойр хамтран ажиллаж, шинэ технологийн онцлог, эрсдэл, хэрэглэгчийг хамгаалах арга хэмжээг тодорхойлох замаар “Өөрийн сэндрокс” (Own Sandbox)⁷⁶ орчинд туршилт хийдэг. Эдгээр тохиолдолд мэдээллийн технологитой холбоотой эрсдэлийн удирдлагын болон хэрэглэгчийг хамгаалах зохицуулалт шаардагдана. Эрсдэлийн удирдлагын шаардлагыг бүх оролцогчдод нэгэн жигд хэрэглэгддэггүй.</p>	
<p>Сингапур</p>	<p>Сингапурын Финтекийн Зохицуулалтын Сэндроксын Удирдамж⁷⁷</p> <p>Сингапурын Мөнгөний удирдах газар нь өөрийн зохицуулалтын сэндроксын удирдамжид зарчимд суурилсан хандлага (principle-based approach)-ыг баримталдаг. Финтек зохицуулалтын сэндроксын удирдамжид MAS нь сэндроксын хугацаанд уян хатан хэрэглэх боломжтой хууль, зохицуулалтын шаардлагуудын жагсаалтыг тусгасан байдаг. Үүнд санхүүгийн чадавх болон хөрөнгийн хангалттай байдал, санхүүгийн тогтвортой байдлын шалгуур, технологийн эрсдэлийн удирдлагын удирдамж, гадаад эх үүсвэрийн удирдамжууд орно.</p> <p>MAS нь мөн энэхүү шаардлагуудын жагсаалт нь бүрэн биш бөгөөд илүү уян хатан болгох хэрэгцээ байгааг тодотгож, тухайн санал болгож буй санхүүгийн үйлчилгээ, өргөдөл гаргагч, болон өргөдлийн агуулгаас хамаарч тохиолдол бүрээр үнэлэгдэж шийдвэрлэгдэнэ гэдгийг тодорхой заасан байдаг.</p>	<p>СЗХ нь Сингапурын уян хатан, эрсдэлд суурилсан зохицуулалтын хандлагыг Сэндрокст орох шаардлагын зохицуулалтдаа харгалзан үзэх боломжтой.</p>

⁷⁶ "Өөрийн сэндрокс" (Own Sandbox) гэж финтек бизнесүүд тухайн санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын өөрийн хяналт дор технологийн шийдлийг турших туршилтын хүрээг хэлнэ. Энэхүү туршилт нь Тайландын Төв Банкны (BOT) хяналтын хүрээнд хамаарах боловч Зохицуулалтын сэндрокст хамрагдах болзлыг хангадаггүй тохиолдолд ашиглагддаг. Туршилт нь санхүүгийн үйлчилгээний чанарыг сайжруулах, цаашлаад шинэлэг санхүүгийн шийдэл, инновац бий болгоход чиглэгдсэн технологийн хэрэглээг хамардаг. Эндээс үзнэ үү: https://www.bot.or.th/content/dam/bot/financial-innovation/digital%20finance/fintech/sandbox/UnofficialTranslation_RegulatorySandboxGuidelines.pdf#page=4

⁷⁷ Сингапурын Мөнгөний удирдах газар (MAS) (2022). Финтекийн Зохицуулалтын Сэндроксын Удирдамж. эндээс үзнэ үү: <https://www.mas.gov.sg/-/media/mas-media-library/development/regulatory-sandbox/sandbox/fintech-regulatory-sandbox-guidelines-jan-2022.pdf>

9.2.3 Арга хэмжээ 7.3: Сэндбоксоос гарах арга замыг тодорхой болгох

Хүснэгт 38: Арга хэмжээ 7.3-ын хураангуй

Зорилт	Сэндбоксоос зохицуулалтын орчноос амжилттай гарсан компаниудыг зах зээлд нэгтгэх, зохицуулалтыг дагаж мөрдөхөд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор гарах замыг тодорхой болгох хэрэгтэй.
Тайлбар	Сэндбоксоос амжилттай гарсан компаниудад гарах замыг нь тодорхойлсноор цаашдын үйл ажиллагааны талаар зааварчилгаа өгч, санхүүгийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй болох хүртэл нь тэдэнд байнгын дэмжлэг үзүүлж, тодорхой ойлголт өгөх болно.
Хэрэгжилтийг хангах субъект	Сэндбоксын зөвлөл
Оролцогч талууд	СЗХ Сэндбоксын алба
Алхмууд	<p>Хэрэгжүүлэх алхмуудыг дараах байдлаар тодорхойлов.</p> <ol style="list-style-type: none"> Тусгай зөвшөөрлийг дуусгавар болоход гарах удирдамжийг тодорхой болгох. Сэндбоксоос зохицуулалтын журамд Сэндбоксоос зөвлөл нь нэвтрэх цэг дээр бизнесийн загвар нь зохицуулалтгүй байсан сэндбоксоос оролцогчдын хэрэгжүүлж болох боломжит замыг тодорхойлох ёстой. Тодруулбал, сэндбоксоос байх хугацаа дуусах эсвэл дуусах дөхөхөд Финтекийн оролцогч дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжтой гэдгийг удирдамжид заана. <ol style="list-style-type: none"> Зохицуулагчийн шийдвэрээр сэндбоксоос зөвшөөрлийн хүчинтэй байх хугацааг тухай бүр, тохиолдол бүрд сунгах; Туршилтын үр дүнд хүрсэний дараа бүрэн хяналтын горимд шилжих эрхтэй байх; NOL авах хүсэлт гаргах (Арга хэмжээ 3.3-р зүйлийн дагуу)⁷⁸; Гарах стратегийг ашиглах; <p>Хүснэгт 39-д Абу Даби дэлхийн зах зээлийн зохицуулалтын лабораторид сэндбоксын оролцогчид зориулсан боломжит гарах стратегиудыг тусгаснаас жишээ авч болно.</p> <ol style="list-style-type: none"> СЗХ-ноос санхүүгийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл шинээр олгох үйл явцыг бий болгож, шинээр зөвшөөрөл олгох бодлогын зөвлөмжийн төслийг боловсруулах. Сэндбоксоос орчинд хийсэн туршилтын үр дүнд үндэслэн СЗХ шинэ зөвшөөрөл шаардлагатай гэж шийдсэн тохиолдолд СЗХ энэхүү бизнесийн шинэ загварыг зохицуулах шинэ зөвшөөрлийг нэмэгдүүлэх боломжтой байх ёстой. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1 дүгээр зүйлд СЗХ нь санхүүгийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж

⁷⁸Сэндбоксоос гарах үед, эрх бүхий этгээдээс тухайн оролцогч нь одоо байгаа зохицуулалтын хүрээнд шууд хамаарахгүй гэж үзвэл, тусгай зөвшөөрөл авахаас өмнөх шилжилтийн хугацааг өгөх эсвэл шинэ хууль тогтоомж батлагдах хүртэл түр хугацаанд үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрөх зорилгоор "эсэргүүцэлгүй тухай албан бичиг" (No-Objection Letter, NOL) олгож болно. Энэхүү NOL-той холбоотой хязгаарлалт, нөхцөлүүд нь сэндбоксоос төгсөгчдөд адил тэгш үйлчилнэ. Энэ талаар энэхүү замын зураглалын 3.3 дугаар үйл ажиллагааны чиглэлд тодорхой заасан болно.

байгаа эсэхэд хяналт тавих бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасан.⁷⁹ Эдгээр үйл ажиллагаанд ББСБ үйл ажиллагаа болон үнэт цаасны зах зээл, даатгалын үйл ажиллагаанууд хамаарна. Сэндбоксоос гарсан компанийн үйл ажиллагаа нь 3.1 дүгээр зүйлд хамаарахгүй тохиолдолд СЗХ нь Монгол Улсын Үндсэн хуулийн 26.1 дүгээр зүйлд заасан дагуу зөвлөмжийн төслийг УИХ болон намуудад өргөн барьж, хуульд тусгах шаардлагатай болно.

Хүснэгт 39: Арга хэмжээ 7.3-т хамаарах сайн туршлагууд

Байршил	Тайлбар	Монгол улсад хэрэгжүүлж болох гол шийдлүүд
Абу Даби	<p>Абу Даби дэлхийн зах зээлийн зохицуулалтын лаборатори (RegLab)⁸⁰</p> <p>Абу Дабигийн RegLab нь санхүүгийн шийдлүүдийг боловсруулахад финтекийн компаниудад дэмжлэг үзүүлэх зорилготой зохицуулалтын сэндбокс орчин юм.</p> <p>Орон нутгийн зохицуулалтын шаардлага хангаагүй байгаа санхүүгийн шинэчлэлийг туршиж буй пүүсүүдэд тусгайлан зориулсан Sandbox өргөдөл гаргагч нь Абу Дабигийн Санхүүгийн үйлчилгээний зохицуулах газрын харьяа Санхүүгийн үйлчилгээний зөвшөөрөл (FSP) авах хүсэлт гаргаж, пүүсийг хоёр жилийн хугацаанд "Санхүүгийн технологийн үйлчилгээг хөгжүүлэх зохицуулалттай үйл ажиллагаа"-ыг үргэлжлүүлэх боломжийг олгодог.</p> <p>Хүчинтэй байх хугацаа дууссаны дараа Финтекийн оролцогч дараахь зүйлийг хийх боломжтой.</p> <ol style="list-style-type: none"> 1. Зохицуулагчийн үзэмжээр санхүүгийн үйлчилгээний зөвшөөрлийн хүчинтэй хугацааг тухайн тохиолдол бүрээр сунгах; 2. Туршилтын үр дүнд хүрсэний дараа бүрэн зөвшөөрөл, хяналтын горимд шилжих, Финтек шийдлээ илүү өргөн хүрээнд ашиглах эрхтэй байх; эсвэл 3. Гарах стратегийг ашиглах 	<p>СЗХ Сэндбокс оролцогчдын хувьд сэндбоксоос гарах арга замыг хэрхэн тодорхойлж байгаагийн жишээг Абу Дабигийн туршлагаас харгалзан үзэх боломжтой.</p>

⁷⁹ Санхүүгийн Зохицуулах Хорооны Эрх Зүйн Байдлын тухай хуулийн 3.1 дүгээр зүйлд Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа, үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх этгээдийн үйл ажиллагаа, даатгагчийн үйл ажиллагаа, даатгалын төлөөлөгч, зуучлагч, хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа, хоршооны хадгаламж зээлийн үйл ажиллагаа, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа, зээлийн батлан даалтын үйл ажиллагаа, малын индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаа, үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа, үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаа багтана. дэлгэрэнгүйг <https://legalinfo.mn/mn/detail?lawId=446>

⁸⁰ Абу Даби Дэлхийн Зах Зээл (2015). Финтек Зохицуулалтын лаборатори удирдамж. Эндээс үзнэ үү. <https://assets.adgm.com/download/assets/fintech-reglab-guidance.pdf/800da29e606e11ef9c36e210a144be73>

	<p>Гарах стратегид хүчинтэй байх хугацаа дууссаны дараа бизнесийн үйл ажиллагаагаа зогсоох эсвэл Финтекийн бүтээгдэхүүнийг бусад эрх бүхий санхүүгийн байгууллагуудад шилжүүлэх зэрэг орно.</p>	
--	---	--

10. Засгийн газрын оролцогч талуудын чадавхийг бэхжүүлэх

Санхүүгийн салбар дахь өрсөлдөөний динамикийг өөрчилж болох Финтекийн сүүлийн үеийн хөгжлийн үүднээс өрсөлдөөний эрх бүхий байгууллагуудыг санхүүгийн салбарт шинээр гарч ирж буй өрсөлдөөний асуудлыг шийдвэрлэх ур чадвар, нөөцөөр хангах ёстой. Санал болгож буй арга хэмжээнд Монополийн эсрэг газар (МЭГ)-ын зохицуулагчдыг чадавхижуулах санаачилгыг хөгжүүлэх тухай тусгасан.

10.1 Одоогийн нөхцөл байдал ба тулгамдаж буй асуудлууд

Хэлэлцүүлгийн үеэр оролцогч талууд жижиг тоглогчдыг тэгш өрсөлдөхөд саад учруулж болзошгүй бэрхшээлүүд байгааг онцолж байсан. Замын зураглалын зарим хэсэгт онцолсон тухайлсан жишээнүүдэд төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдийг зөвхөн спонсор банкаар дамжуулан автомат клиринг хаус системд хандахыг үүрэг болгох (Арга хэмжээний 3.2), бусад тохиолдолд зарим төрийн үйлчилгээнд худалдааны үйлчилгээний хураамж авахыг банкууд хязгаарлах (Арга хэмжээ 3.1). Ийм практик нь ялангуяа жижиг фирмүүдийн хувьд зах зээлд нэвтрэхэд саад учруулж, урт хугацаанд Финтекийн илүү идэвхтэй экосистемийг хөгжүүлэхэд нөлөөлж болзошгүй юм. Монополийн эсрэг газар (хуучнаар Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар) болон СЗХ нь санхүүгийн салбарын өрсөлдөөний асуудлыг тодорхойлж, шийдвэрлэхэд идэвхтэй оролцож, чадавхийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх шаардлагатай.

10.2 Замын зураглалд санал болгож буй арга хэмжээ

Санхүүгийн салбарын өрсөлдөөний асуудлыг зохих ёсоор шийдвэрлэхийн тулд СЗХ, Монголбанк болон салбарын оролцогч талуудын саналд үндэслэн Монополийн эсрэг газар (МОГ) болон СЗХ-ны зохицуулагчдыг чадавхижуулахыг санал болгож байна.

10.2.1 Арга хэмжээ 8.1: Засгийн газрын оролцогч талуудын чадавхийг бэхжүүлэх

Хүснэгт 40: Арга хэмжээ 8.1-ын хураангуй

Зорилт	Санхүүгийн салбарын өрсөлдөөний асуудлыг тодорхойлох, шийдвэрлэхэд зохицуулагчдын чадавхийг бэхжүүлэх.
Тайлбар	Чадавхийг бэхжүүлэх санаачилгууд нь дотоод сургалтын хөтөлбөрөөр дамжуулан зохицуулагчдыг санхүүгийн салбарын мэдлэгтэй болгох боломжтой. Сургалтын хөтөлбөрийн хамрах хүрээ нь аналитик программ хангамж ашиглахаас эхлээд санхүүгийн салбарын өрсөлдөөний тодорхой асуудлаар зорилтот сургалт явуулах зэрэг байж болно. Байгууллага хооронд түр томилолт хийх нь мэдлэг харилцан солилцох боломжийг сайжруулах үр дүнтэй хэрэгсэл байх боломжтой.
Хэрэгжилтийг хангах субъект	МФАХ
Оролцогч талууд	Санхүүгийн зохицуулах хороо, Монгол банк, Монополийн эсрэг газар
Алхмууд	<u>Монополийн эсрэг газар</u>

1. **Монополийн эсрэг газар нь санхүүгийн үйлчилгээ болон финтекийн өрсөлдөөнтэй холбоотой мэдлэгийг нэмэгдүүлэх хүрээг тодорхойлох зорилгоор Монголбанк болон СЗХ-ны зохицуулагчидтай хамтран тогтмол шалгалт хийх болно.** Хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй санхүүгийн орчин нь тасралтгүй суралцах, дасан зохицохыг шаарддаг тул эдгээр байгууллагуудын дунд байнгын сургалт, зохион байгуулалттай хэлэлцүүлэг хийх нь чадавхийг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой. Монополийн эсрэг газрын ахлах түвшний удирдлагыг хамарсан олон талт үнэлгээг хийж, санхүүгийн салбар дахь өрсөлдөөний асуудлын янз бүрийн хэмжигдэхүүнийг хамрах замаар сургалтын хэрэглэгдэхүүн болон сургалтын хөтөлбөрийг оролцогчдын онцлог хэрэгцээнд нийцүүлэн сайжруулах боломжтой. Эдгээр үнэлгээ нь зохицуулагчийн сүүлийн үеийн үйл явдлын талаарх үндсэн мэдлэгийг үнэлэхээс эхлээд бодлогын үр дагавар, зохицуулалтын боломжит арга барилын талаар илүү гүнзгий ойлголттой болох хүртэлх агуулгыг хамрах нь зүйтэй.
2. **Монополийн эсрэг газарт зориулсан зорилгот сургалтын материал боловсруулна.** Сургалтын хөтөлбөр нь практик дадлага болон бодит амьдрал дээр тулгуурласан өрсөлдөөний жишээнүүдийг нэн тэргүүнд тавих ёстой. Сургалтыг зохион байгуулж, зохицуулагчдын өрсөлдөөний хэрэг хянан шийдвэрлэх ур чадварыг дээшлүүлэх боломжтой. Үүнтэй зэрэгцэн, банк бус зээлийн эрсдэл, платформын зах зээлийн өрсөлдөөний асуудал зэрэг дэлхий нийтийн хэмжээнд тулгарч буй хуучин болон шинэ сорилтуудын бодит кейс судалгаануудыг хамруулах нь зүйтэй.
3. **Төрийн байгууллагууд хооронд түр томилолт хийх боломжуудыг бүрдүүлнэ.** Монополийн эсрэг газрын байцаагчдыг бусад санхүүгийн байгууллагууд (жишээлбэл, СЗХ болон Монгол банк) руу 6 сараас 1 жилийн хугацаатай дотоод шилжилтээр ажиллуулах нь салбар хоорондын мэдээлэл солилцоо, мэдлэг хуваалцах боломжийг бүрдүүлнэ. Ийнхүү түр томилогдон ажилласнаар Монгополийн эсрэг газрын байцаагчид санхүүгийн салбарын хөгжлийн чиг хандлагыг тасралтгүй дагаж, ойлгож байх нөхцөл бүрдэнэ. Үүний нэгэн адил, СЗХ болон Монгол банкны хянан шалгагчдыг ч мөн түр томилгоогоор ажиллуулах нь санхүүгийн бодлого нь өрсөлдөөний асуудалд нийцтэй, уян хатан байх нөхцөлийг хангана.

Санхүүгийн зохицуулах хороо

1. **СЗХ-ны хянан шалгагчдыг академик сургалтаар дамжуулан салбарын мэдлэгийг дээшлүүлэх дотоодын болон олон улсын эрдэм шинжилгээ, дээд боловсролын байгууллагуудтай хамтран ажиллах.** Мэдлэгийг тасралтгүй нэмэгдүүлэх болон сургалтын хөтөлбөр хөгжүүлэх ажлын хүрээнд СЗХ нь Монгол Улсын Их Сургууль (МУИС), Санхүү, Эдийн Засгийн Их Сургууль (СЭЗИС) зэрэг байгууллагуудтай нягт хамтран ажиллах хэрэгтэй. Энэхүү хамтын ажиллагаа нь СЗХ-ны хяналт, шалгалтын ажилтнуудад салбарын хөгжлийн чиг хандлага, шинэ сорилтуудын талаарх ойлголтыг байнга шинэчилж, тэдний мэдлэгийг тэлэх боломжийг бүрдүүлнэ. Академик байгууллага ба салбарын хамтын ажиллагаа нь зохицуулагчдад шинээр гарч буй финтек чиг хандлагын талаар гүнзгий судалгаанд үндэслэсэн мэдээлэлд хандах, салбарын өөрчлөлтөд түргэн шуурхай хариу үзүүлэх боломжийг олгоно. Сингапурын MAS (Мөнгөний удирдах газар) болон

NUS (Үндэсний их сургууль)-ийн хамтарсан загварыг Хүснэгт 41-д тусгасан бөгөөд амжилттай хамтын ажиллагааны жишээ юм.

Хүснэгт 41: Арга хэмжээ 8.1-ийн хураангуй

Байршил	Тайлбар	Монгол улсад хэрэгжүүлж болох шийдлүүд
Их Британи	<p>Өрсөлдөөн ба Зах зээлийн зохицуулах газар (СМА) бусад зохицуулах газруудтай хамтран ажиллах боломж</p> <p>(СМА) нь Санхүүгийн Зохицуулах Алба (FCA) зэрэг бусад зохицуулагч байгууллагуудтай түр томилолт хийх санаачлагын хүрээнд хамтран ажилласан туршлагатай. Ийм томилолтууд нь өрсөлдөөний бодлогыг тухайн салбарын онцлог мэдлэг, туршлагатай уялдуулахад тус дэм болдог бөгөөд зохицуулалтын уялдаа холбоог хангах хандлагыг дэмждэг.</p> <p>Түр томилолтын зорилгодоо хүрэх боломжийг нэмэгдүүлэхийн тулд Их Британийн Өрсөлдөөний Сүлжээ (UKCN)⁸¹ нь <i>Түр томилолтын зарчмууд</i>⁸² нэртэй баримт бичгийг гаргасан. Энэхүү баримт бичигт түр томилолтыг “чадвар солилцох, шилжүүлэх чухал арга хэрэгсэл” хэмээн тодорхойлсон бөгөөд UKCN-ийн гишүүд нь бусад гишүүдийн “нэг эсвэл хэд хэдэн ажилтныг түр томилох хүсэлтийг зохих ёсоор авч үзэх” ёстойг дурдсан байдаг. Үүний зэрэгцээ, зарим тохиолдолд зөвлөгөө өгөх эсвэл сургалт зохион байгуулах зэрэг бусад хэлбэрийн дэмжлэг нь түр томилолтоос илүү тохиромжтой байж болохыг харгалзан үзэх шаардлагатайг онцолсон.</p>	<p>Сайн бүтэцлэгдсэн, ил тод түр томилолтын хөтөлбөр нь тодорхой зарчим, чиглэлд тулгуурласнаар байгууллагууд хоорондын мэдлэг, туршлага солилцоо болон чадавх бэхжүүлэх үйл явцыг үр дүнтэй болгодог. Ингэснээр зохицуулагчид тухайн салбарын онцлог сорилтуудыг илүү гүнзгий ойлгож, зохицуулалтын арга барилаа уялдуулах боломжтой болохын зэрэгцээ, илүү бат бөх, дасан зохицох чадвартай хяналт, зохицуулалтын тогтолцоог хөгжүүлэх нөхцөл бүрдэнэ.</p>
Сингапур	<p>Сингапурын Мөнгөний удирдах газар болон Сингапурын Үндэсний их сургуулийн түншлэл⁸³</p> <p>MAS болон NUS-ийн түншлэл нь Үндэсний Их Сургуулийн (NUS) янз бүрийн</p>	<p>СЗХ нь салбар болон эрдэм шинжилгээний байгууллагуудын хооронд мэдлэг солилцохын тулд дээд боловсролын байгууллагуудтай ижил төстэй</p>

⁸¹ Их Британийн Өрсөлдөөний Сүлжээ (UK Competition Network, UKCN) нь Өрсөлдөөн ба Зах зээлийн газрын (СМА) болон өөр өөр салбарт өрсөлдөөнийг дэмжих үүрэг бүхий Их Британийн зохицуулагч байгууллагуудын хамтарсан эвсэл юм. Энэхүү сүлжээ нь хэрэглэгчдийн ашиг сонирхлыг хамгаалж, зохицуулалттай салбаруудад үүсч болзошгүй өрсөлдөөний эсрэг үйлдлүүдийг таслан зогсоох зорилгоор эдийн засгийн хүрээнд илүү хүчтэй өрсөлдөөн бий болгоход чиглэдэг. Эндээс үзнэ үү: <https://www.gov.uk/government/groups/uk-competition-network>

⁸² Их Британийн Өрсөлдөөний Сүлжээ (2017). Түр томилолтын зарчмууд. Эндээс үзнэ үү: <https://assets.publishing.service.gov.uk/media/5a81e19a40f0b62302699aab/ukcn-secondment-principles-march-2017.pdf>

⁸³ Сингапурын Мөнгөний зохицуулах газар (MAS), (2024). MAS нь NUS-ын Профессорын программыг амжилттай шинэчлэн түншлэл тогтоолоо. Эндээс үзнэ үү. <https://www.mas.gov.sg/news/media-releases/2024/mas-renews-its-successful-partnership-with-nus-on-term-professorship-programme>

	<p>факультетуудад MAS-ийн нэр хүндтэй ажилтнуудыг Зочин Профессороор томилдог “MAS Терм Профессорын алба”-аас бүрддэг. Энэхүү түншлэл нь MAS-ийн ахлах зохицуулагчдад эдийн засаг, санхүү, нийтийн бодлого болон засаглалын чиглэлээр гарч буй хөгжлийн талаар судалгаа хийх, академичидтай мэдлэг солилцох боломжийг олгодог.</p> <p>Харин MAS-ийн зохицуулагчдын салбарын туршлага, мэдлэг нь NUS-ийн багш, оюутнуудад онолын ойлголтыг бодит амьдрал дээр хэрхэн хэрэгжүүлэх талаар чухал, үнэ цэнтэй ойлголтуудыг өгдөг. Энэ нь академик мэдлэгийг практикт уялдуулахад томоохон хувь нэмэр оруулдаг.</p>	<p>хамтын ажиллагааны хэлбэрийг авч үзэх боломжтой.</p>
--	---	--

11. Хавсралт

11.1.1 Хавсралт А: Үйл ажиллагааг тодорхойлох баримт бичгүүд

Бокс А: Агентлаг хоорондын Финтек ажлын хэсгийн Үйл ажиллагааг тодорхойлох баримт бичгийн загвар

Тойм

Монголын Финтекийн Ажлын хэсэг (МФАХ) нь засгийн газрын хэмжээнд Финтекийн салбарыг хөгжүүлэхэд чиглэсэн зохицуулалтыг чиглүүлэх зорилгоор байгуулагдсан. МФАХ нь хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, зах зээлийн нэгдмэл байдал, системийн тогтвортой байдлыг хангахын зэрэгцээ Финтекийн инновацийн таатай орчныг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд зорино.

Хамрах хүрээ

МФАХ нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

1. **Бодлогын зохицуулалт:** Засгийн газрын агентлагууд, тэр дундаа MFWG-д харьяалагддаггүй агентлагууд хоорондын Финтектэй холбоотой бодлого, зохицуулалтыг зохицуулах, уялдуулах.
2. **Мэдээлэл хуваалцах:** Финтекийн хөгжил, чиг хандлага, тулгамдсан асуудлын талаар засгийн газрын агентлаг хооронд мэдээлэл, сайн туршлагыг солилцоход дэмжлэг үзүүлэх.
3. **Чадавхжуулалт:** Шинээр гарч ирж буй өрсөлдөөний асуудлуудыг оролцуулан санхүүгийн салбарын хөгжлийг хянах, удирдах санхүүгийн зохицуулагчдын чадавхийг бэхжүүлэх.
4. **Төр, хувийн хэвшлийн түншлэл:** Инноваци, өсөлтийг дэмжихийн тулд засгийн газрын агентлагууд болон Финтекийн салбар хоорондын түншлэлийг дэмжих.
5. **Хил дамнасан хамтын ажиллагаа:** Финтекийн асуудлаар олон улсын хамтын ажиллагаа, хамтын ажиллагааг дэмжих, түүний дотор Финтектэй холбоотой олон улсын оролцоог хангах холбоо барих цэг болон ажиллах.
6. **Хэрэглэгчийн хамгаалалт:** Финтект суурилсан санхүүгийн үйлчилгээний шинэ бүтээгдэхүүн бий болохтой холбоотой хэрэглэгчийн эрхийг хамгаалах хүчин чармайлтыг дэмжих.

Бүтэц ба гишүүнчлэл

МФАХ-ийг Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-ны дарга, Монголбанкны Ерөнхийлөгч (Монголбанк) нар хамтран удирдана.

Мөн дараахь засгийн газрын агентлаг/яамдын (эсвэл тэдгээрийн томилогдсон хэлтсийн) төлөөлөгчдөөс бүрдэнэ.

1. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам
2. Эдийн засаг, хөгжлийн яам
3. Хадгаламж, даатгалын корпораци
4. Сангийн яам
5. Хууль зүй, дотоод хэргийн яам
6. Татварын ерөнхий газар
7. Улсын бүртгэлийн ерөнхий газар

8. Харилцаа холбооны зохицуулах хороо

Агентлаг бүр ажлын хэсэгт ажиллах ахлах/удирдах түвшний албан тушаалтныг томилно. Ажлын хэсэг нь шаардлагатай бол төсөл, ажлын урсгал, хэлэлцэх асуудлаар хувийн хэвшлийн төлөөлөл, мэргэжилтнүүдийг урьж болно. Ийнхүү оролцуулахын тулд тухайн хурал, ажлын хэсгийн дарга нараас зөвшөөрөл авах шаардлагатай.

Чиг үүрэг

МФАХ нь чиг үүргийнхээ хүрээнд дараах үйл ажиллагааг гүйцэтгэж, хяналт тавина.

1. Бодлогын зохицуулалт, боловсруулалт

Засгийн газрын агентлаг, байгууллагуудын хооронд Финтектэй холбогдсон бодлого, зохицуулалтын одоогийн байдалд хяналт тавьж, бодлогыг уялдуулан зохицуулах болон Финтек бодлого, зохицуулалтын байнгын хяналтыг хийх механизмыг боловсронгуй болгох үүрэгтэй. Үүний зэрэгцээ, ажлын урсгал нь “Зөрчилгүй тухай албан бичиг” гаргасан Финтек компаниуд зохицуулалтад шилжих процессыг хамтран удирдана, тусгай зөвшөөрөл олгох процессыг хянаж, зохицуулалтыг шинэчлэх шаардлагыг тодорхойлоход дэмжлэг үзүүлнэ. Мөн Финтектэй холбогдсон бодлогын шинэчлэл болон зохицуулалтын өөрчлөлтийг таниулах зорилгоор мэдлэг хуваалцах суваг хөгжүүлэхэд хяналт тавина.

2. Чадавхжуулалт

Засгийн газрын агентлагуудын чадавхийг бэхжүүлэх санаачлага, тэр дундаа санхүүгийн салбарын тодорхой асуудлаар зорилтот сургалтын хөтөлбөр, шаардлагатай тохиолдолд техникийн сургалтын хөтөлбөр боловсруулна.

3. Салбарын хөгжил, инновацийг дэмжих

Финтекийн инновацийн оффисыг хөгжүүлэх замаар Финтекийн гарааны бизнесүүд болон компаниудыг дэмжих санаачилгад хяналт тавьж, Зохицуулалтын Сэндбоксын нэгжтэй тогтмол хамтран ажиллана.

4. Хэрэглэгчийн хамгаалалт ба боловсрол

Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах заавар, стандартыг боловсруулах, тусгайлсан санхүүгийн омбудсмен байгуулахад хяналт тавина. Санхүүгийн мэдлэг, боловсролыг дэмжих, өрийн клиник байгуулахад хяналт тавина.

5. Олон улсын хамтын ажиллагаа

Гадаадын түншүүдтэй Финтекийн асуудлаар харилцаа тогтоох асуудалд санаачилга гаргаж, хил дамнасан хамтын ажиллагаа, мэдлэг хуваалцах боломжийг тодорхойлох үүрэг хүлэнэ.

Ажлын хэсгийг СЗХ болон Монголбанкны ахлах албан тушаалтнуудын төлөөлөл хамтран удирдана. СЗХ-ны төлөөллийг СЗХ-ны дарга, Монголбанкны төлөөллийг Монголбанкны Ерөнхийлөгч нэр дэвшүүлнэ. Төлөөлөгчийг өөрчлөхөд аль аль талуудын зөвшөөрөл шаардлагатай.

Ажлын хэсэг бүрийн гишүүдэд МФАХ-г бүрдүүлдэг агентлагуудын төлөөлөгч багтаж болох бөгөөд эсвэл МФАХ-ээс гадуурх агентлагууд буюу хувийн хэвшлийн компаниуд; болон зарим тохиолдолд боловсролын байгууллагаас оруулж болно. Ажлын хэсгийн хэлэлцэх асуудлаас хамаарч оролцох гишүүдийг хамтарсан удирдалагаас нэр дэвшүүлж, батална.

МФАХ-ийн үйл ажиллагааны хүрээнд ахиц дэвшил гаргахын хэрээр ажлын хэсгийн тодорхой үүрэг даалгавар, цар хүрээ тухай бүр өөрчлөгдөж болно. Үйл ажиллагааг тодорхойлох баримт

бичиг (“TOR”)-г СЗХ болон Монголбанкны хамтарсан удирдлагуудын саналыг үндэслэн ажлын хэсэг тус бүрээр, мөн МФАХ-ийн хамтарсан удирдлагын зөвшөөрлөөр өөрчлөлт хийж болно.

Уулзалт ба тайлагнал

Ажлын хэсэг тус бүр улирал тутам хуралдаж, хийж гүйцэтгэсэн ажил, тодорхой ажлуудад хүрсэн ахиц дэвшлийн талаар тайлагнана. Хурлын тэмдэглэлийг МФАХ-ийн Нарийн бичгийн дарга эмхэлж, МФАХ-ийн гишүүдэд хүргүүлнэ.

МФАХ жилд хоёроос доошгүй удаа хуралдаж, ахиц дэвшилд хяналт тавьж, дараагийн алхмуудад өргөн хүрээтэй чиглэл өгнө. Хурлын тэмдэглэлийг МФАХ-ийн Нарийн бичгийн дарга хөтөлж, МФАХ-ны гишүүдэд хүргүүлнэ.

СЗХ-ны жилийн ажлын тайланд оруулах МФАХ-ийн жилийн тайланг Нарийн бичгийн дарга бэлтгэж, хүргүүлнэ. Тайланд МФАХ-ийн ажлын хэсгүүдийн үйл ажиллагаа болон ажил бүрийг гүйцэтгэх явцад гарсан ахиц дэвшлийг нэгтгэн тусгана.

Нарийн бичгийн дарга нарын газар (Secretariat)-ыг байгуулах

МФАХ-ийн үйл ажиллагааг дэмжих үүрэг бүхий Нарийн бичгийн дарга нарын газар (НБД нарын газар) байгуулагдана. Нарийн бичгийн дарга нарын нөөцийн асуудлыг МФАХ хариуцна. НБД нарын газрын үүрэг хариуцлагад дараах зүйлс орно.

1. МФАХ-ийн хурлын зохион байгуулалтыг (жишээ нь: хуралдах газар, цагыг захиалах, хурлын материалыг нэгтгэх, тараах)
2. Уулзалтын тэмдэглэлийн төслийг боловсруулах
3. Үйл ажиллагааны мэдээллийг нэгтгэх, МФАХ-ийн үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэх явцад гарсан ахиц дэвшлийг нэгтгэсэн жилийн тайлангийн төслийг боловсруулах.

Хамтарсан удирдлагын шийдвэрээр НБД нарын газарт МФАХ-ийн үйл ажиллагааг хэвийн явуулахтай холбоотой бусад ажлыг мөн хариуцуулж болно.

Хяналт, шинэчлэл

МФАХ-ийн үйл ажиллагааг тодорхойлох баримт бичиг (“TOR”)-ийг тогтмол үр дүнтэй, тасралтгүй байлгах үүднээс хамтарсан удирдлагын саналаар хянаж, шинэчилнэ.

Бокс В: Финтек Консьерж үйлчилгээний хүрээг тодорхойлох баримт бичиг (“TOR”)-ийн загвар

Тойм

Финтек Консьерж (FC) үйлчилгээ нь Монгол Улсын Засгийн газар болон Финтекийн салбар хоорондын нэгдсэн цэг байхаар байгуулагдсан. Энэ нь санхүүгийн байгууллагууд, бизнес эрхлэгчид болон хэрэглэгчдэд үр ашигтай санхүүгийн үйлчилгээний салбарт инновацийг дэмжих хамтын ажиллагааны орчинг сайжруулж, бүрдүүлэхэд туслах зорилготой.

Хамрах хүрээ

Финтек Консьерж үйлчилгээ нь дараах үүрэг хариуцлагыг хүлээнэ.

1. **Харилцаа холбоог хөнгөвчлөх:** Харилцан ойлголцол, хамтын ажиллагааг дэмжих зорилгоор Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо болон санхүүгийн үйлчилгээний салбарын компаниудын хооронд харилцах үр дүнтэй сувгийг бий болгох.
2. **Бодлого боловсруулалтыг дэмжих:** Инновацийг хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахтай тэнцвэржүүлэх хүрээнд Финтекийн бодлого, зохицуулалтын тогтолцоог боловсронгуй болгоход Финтекийн салбарын нөхцөл байдлын талаарх мэдээлэл өгөх.
3. **Финтек компаниудад дэмжлэг үзүүлэх:** Финтекийн хууль тогтоомжтой холбоотой асуудлыг тодруулах, дэмжлэг авах Финтек фирмүүдэд үр дүнтэй нэг цэгийн платформ бий болгох.

Засаглал ба тайлагнал

Финтек Консьерж үйлчилгээг СЗХ-ны Сэндбокс зохицуулалтын алба болон Монгол банкны Инновацийн төв хамтран удирдах болно. Улирал тутам үйл ажиллагаагаа нэгтгэн дүгнэж, дэмжлэг үзүүлсэн болон үйлчилгээнд хамрагдсан компаниудын тоо, төрлийг нэгтгэн гаргаж, МФАХ-т хүргүүлнэ.

Төсөв

Финтек консьерж үйлчилгээний үйл ажиллагааг дэмжих зорилгоор төсвийн хөрөнгө, боловсон хүчин зэрэг нөөцийг хоёр тал хуваарилна. Ажилд авах, боловсон хүчнийг сонгох зэрэг үйл ажиллагааны шийдвэрүүдийг хоёр тал хянаж, тохиролцоно.

Чиг үүрэг

Хамрах хүрээнд хамаарах үүрэг хариуцлагаа биелүүлэхийн тулд Финтек Консьерж Үйлчилгээ нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

1. **Салбарын оролцоо:** Зохицуулагчид (жишээлбэл, Монголбанк, Санхүүгийн Зохицуулах Хороо) болон Финтекийн салбарын төлөөлөгчдийн хооронд зохицуулалтын шинэчлэлт, салбарын сорилт, хамтын ажиллагааны боломжуудын талаар тогтмол салбарын оролцооны хуралдааныг зохион байгуулна.
2. **Санал, хүсэлтийн механизм:** Финтек компаниудад одоо мөрдөгдөж буй зохицуулалтын талаар санал хүсэлтээ өгөх, зохицуулагчид шинээр батлагдах хууль тогтоож, зохицуулалтын талаар санал хүсэлт авах зорилгоор олон нийтэд зориулсан платформ боловсруулна.

Үйл ажиллагааны зарчим:

Финтек консьерж үйлчилгээний өдөр тутмын үйл ажиллагаанд дараах зарчмуудыг баримтална.

1. **Ил тод байдал.** Бүх үйл ажиллагаа ил тод явагдах бөгөөд үйл ажиллагаа, үр дүнг олон нийтэд тогтмол мэдээлдэг байна.

2. **Хүртээмжтэй байдал.** Хөгжлийн бэрхшээлтэй эсвэл санхүүгийн мэдлэг багатай хүмүүс зэрэг боломжит бүх хэрэглэгчдэд үйлчилгээг хүртээмжтэй байлгах.
3. **Мэдээллийн хамгаалалт.** Финтек Консьержийн үйлчилгээний явцад цуглуулсан хэрэглэгчийн болон арилжааны мэдээллийг хамгаалахын тулд өгөгдөл хамгаалах хатуу арга хэмжээг хэрэгжүүлнэ.
4. **Санал хүсэлтийн механизм.** Гүйцэтгэл болон сайжруулах шаардлагатай хэсгүүдийн талаар санал хүсэлт өгөх хэрэглэгчдэд зориулсан сувгуудыг бий болгох.

i.

Бокс С: Өрийн клиникийн үйл ажиллагааг тодорхойлох баримт бичиг (“TOR”)-ийн загвар

Тойм

Өрийн клиник нь хувь хүмүүст өрийн асуудлаа шийдвэрлэх зорилтот өрийн зөвлөгөө болон зөвлөх үйлчилгээгээр хангах зохион байгуулалттай орчныг бүрдүүлэх зорилготой. Мөн өргөн хүрээг хамарсан сургалтын болон санхүүгийн суурь боловсролыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөтөлбөрүүдийг боловсруулна. Эдгээр хөтөлбөрүүд хэрэглэгч санхүүгийн тогтвортой байдалд хүрэх, тэдний сайн сайхан байдлыг сайжруулахад шаардлагатай мэдлэг, хэрэгслээр хэрэглэгчдийг чадавхжуулах зорилготой.

Хамрах хүрээ

Өрийн клиникийн үүрэг хариуцлага:

1. **Өрийн талаар зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлэх:** Санхүүгийн бэрхшээлтэй, өртэй тулгарсан хүмүүст санхүүгийн зөвлөгөө өгөх, өрийн удирдлага болон/эсвэл өрийн бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрөөр дамжуулан дэмжлэг үзүүлэх.
2. **Иргэдэд зориулсан санхүүгийн боловсрол, менежментийн хөтөлбөрүүдийг боловсруулах:** Хувь хүнд тухайлан зориулсан дэмжлэг үзүүлэх ба/эсвэл санхүүгийн боловсролыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх
3. **Хувийн санхүүгийн чиглэлээр олон нийтийг сургах:** Иргэний нийгмийн байгууллагууд, засгийн газрын агентлагууд, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч нартай хамтран өрийн удирдлагын үр дүнтэй стратеги, төсвөө төлөвлөх зэрэг хувийн санхүүгийн талаарх олон нийтэд зориулсан соён гэрээрүүлэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх
4. **Өрийн асуудлын талаар судалгаа хийх:** Монголын хүн амын өрийн асуудлын цар хүрээ, нөлөөлөл, хуваарилалтын талаар судалгаа хийж, дэмжлэг үзүүлэх зорилтот аргуудыг тодорхойлж, санал болгох.

Засаглалын бүтэц

Монголбанкны Олон нийтийн санхүүгийн мэдээллийн төв, СЗХ-ны Санхүүгийн боловсрол, сургалтын алба хамтран Өрийн клиникийн үйл ажиллагаанд стратегийн хяналт тавьж, клиникийн үйл ажиллагаа, үйл ажиллагаанд зарцуулах төсвийг батлах үүрэг хүлээнэ.

Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-ны дарга, Монголбанкны Ерөнхийлөгч (Монголбанк)-аас нэр дэвшүүлж, баталсан Клиникийн дарга нь захиргааны ажилтнуудаас бүрдсэн багийн дэмжлэгтэйгээр өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих үүрэг хүлээнэ. Ажилд авах, боловсон хүчний асуудлыг Клиникийн дарга хянана.

Чиг үүрэг

Клиник нь үндсэн үүрэг, хариуцлагаа хэрэгжүүлэхдээ дараах чиг үүрэгтэй байхаар төлөвлөнө.

1. **Өрийн удирдлага.** Өрийн асуудалтай иргэдэд санхүүгийн байдлыг үнэлэх, өрийн удирдлагын хувийн төлөвлөгөө боловсруулахад туслах, зээлдүүлэгчидтэй хэлэлцээр хийх, эргэн төлөлтийн боломжит төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүлэх зөвлөгөө өгөх.
2. **Хувийн санхүүгийн боловсрол.** Төсөв, зээлийн удирдлага, өрийг бууруулах стратеги, санхүүгийн мэдлэг зэрэг сэдвүүдийг хамарсан боловсролын хичээлүүдийг иргэний нийгмийн байгууллагууд, ТББ-уудтай хамтран зохион байгуулна.
3. **Олон нийтэд хүрч ажиллах.** Хариуцлагатай зээл, санхүүгийн менежментийн талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн олон нийтийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор иргэний нийгмийн байгууллага, ТББ-уудтай хамтран ажиллана.

4. **Судалгаа ба тайлагнах.** Монгол улсын хүн амын өрийн асуудлын цар хүрээ, нөлөөлөл, хуваарилалтын талаар судалгаа хийж, сургалтын хөтөлбөр боловсруулах, иргэдэд хүргэх.

Үйл ажиллагааны зарчмууд:

Дараах зарчмуудыг өдөр тутмын үйл ажиллагаанд баримтална.

1. **Ил тод байдал.** Бүх үйл ажиллагаа ил тод явагдах бөгөөд үйл ажиллагаа, түүний үр дүнг олон нийтэд тогтмол мэдээлнэ.
2. **Хүртээмжтэй байдал.** Хөгжлийн бэрхшээлтэй эсвэл санхүүгийн мэдлэг багатай хүмүүс зэрэг бүх хэрэглэгчдэд үйлчилгээ хүртээмжтэй байлгахад анхаарна.
3. **Мэдээлэл хамгаалалт.** Клиникийн үйл ажиллагааны явцад цуглуулсан хэрэглэгчийн мэдээллийг хамгаалахын тулд мэдээллийн хамгаалалтын хатуу арга хэмжээг хэрэгжүүлнэ.
4. **Хамтын ажиллагаа.** Монгол Улсад санхүүгийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр бусад төрийн байгууллага, ТББ, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллана.
5. **Санал хүсэлтийн механизм.** Үйл ажиллагааны гүйцэтгэл болон сайжруулах шаардлагатай хэсгүүдийн талаар санал хүсэлтээ өгөх хэрэглэгчдэд зориулсан сувгуудыг бий болгох

Хяналт-шинжилгээ, үнэлгээ

Клиникийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэх зорилгоор гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүд (KPI)-ийг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Жилд үйлчлүүлсэн иргэдийн тоо.
2. Өрийн удирдлагын төлөвлөгөөгөө амжилттай биелүүлсэн үйлчлүүлэгчдийн хувь.
3. Үйлчлүүлэгчдийн санхүүгийн боловсролыг үйлчилгээ үзүүлэхээс өмнөх болон дараах үнэлгээгээр хэмжсэн сайжруулалт.
4. Тодорхой хугацааны туршид үйлчлүүлэгчийн өрийн нийт хэмжээний бууралт.

Үйлчилгээ нь олон нийтийн хэрэгцээг хангахад хамааралтай, үр дүнтэй хэвээр байгаа эсэхийг баталгаажуулахын тулд тогтмол үнэлгээ хийнэ.

Тайлагнал

Клиникийн үйл ажиллагааны талаар Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-ны дарга, Монголбанкны Ерөнхийлөгч (Монголбанк) нарт улирал тутам мэдээлэл өгч байхаар төлөвлөнө. Мөн жил бүр гүйцэтгэсэн ажил үйлчилгээ, тэдгээрийн тайлан, төсвийн хуваарилалт, зарцуулалт зэргийг нэгтгэн хүргүүлж байхаар төлөвлөнө.

Төсөв

Клиникийн санхүүжилтийг Засгийн газраас олгох санхүүжүүлж, СЗХ, Монголбанкаар дамжуулан олгож, үйл ажиллагааг нь үр дүнтэй дэмжихэд хангалттай эх үүсвэрийг хуваарилна.



Биднийг дагаарай



Манай оффисууд

Хойд Америк

Washington DC
Suite 512
1730 Rhode Island Ave N.W.
Washington DC 20036
USA
+1 202 503 1570
washingtondc@accesspartnership.com

Ойрх Дорнод

Abu Dhabi
Al Wahda City Tower, 20th Floor
Hazaa Bin Zayed The First Street
PO Box 127432
Abu Dhabi, UAE
+971 2 815 7811
abudhabi@accesspartnership.com

Европ

London
The Tower, Buckingham Green,
Buckingham Gate,
London, SW1E 6AS
United Kingdom
+44 20 3143 4900
london@accesspartnership.com

Африк

Johannesburg
119 Witch-Hazel Avenue
Highveld Technopark
Johannesburg
Gauteng, South Africa
+27 72 324 8821

Brussels

8th Floor, Silversquare Europe, Square
de Meeüs 35,
1000 Bruxelles,
Belgium
+32 (0)2 791 79 50
brussels@accesspartnership.com

Ази-Номхон далай

Singapore
Asia Square, Tower 2
#11-01
12 Marina View
Singapore 018961
+65 8323 7855
singapore@accesspartnership.com